



JAPAN FOUNDATION

# ТАЙЛАН

МОНГОЛ-ЯПОНЫ ХҮНИЙ  
НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ



2024 он  
16-р дугаар



**МОНГОЛ-ЯПОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ**



# **ТАЙЛАН**

**(2023.01.01-2023.12.31)**

**2024 он**



## ТӨВИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв (Цаашид Монгол-Японы төв гэх) нь Монголын зах зээлийн эдийн засагт хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг хөгжүүлэх Монгол, Япон хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (Цаашид ЖАЙКА гэх), Боловсрол, Шинжлэх ухааны яам болон МУИС-ийн хамтарсан төсөл хэлбэрээр 2002 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Одоо бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, япон хэлний боловсрол, хамтын ажиллагаа гэсэн үндсэн үйл ажиллагаа явуулдаг. 2012 оноос япон хэлний боловсрол болоод хоёр орны хамтын ажиллагааны хувьд Япон сантай хамтран ажиллаж байна. Мөн өнөөг хүртэл бий болгосон харилцаа холбоогоо үр дүнтэйгээр ашиглан Япон, Монголын бизнесийн гүүр болон ажиллахыг зорьж байна.

2002 он 01 сарын 22	ЖАЙКА болон МУИС-ийн оролцоотойгоор Төслийн нэгдүгээр үе шатыг эхлүүлсэн.
2002 он 03 сарын 14	Япон улсын засгийн газрын буцалтгүй тусламжаар Монгол-Японы Төвийн барилга байгууламж тоног төхөөрөмжийг (нийт 4.43 сая ам доллар) хүлээлгэн өгсөн. (Барилгын талбайн хэмжээ нь 1,520 m <sup>2</sup> , нийт талбайн хэмжээ нь 7,000 m <sup>2</sup> )
2002 он 06 сарын 21	Албан ёсны нээлтийн үйл ажиллагаанд Японы эрхэм дээд ханхүү Акишинономия, Гүнж Кикогийн хамт оролцсон.
2007 он 01 сарын 22	Төслийн хоёрдугаар үе шат эхэлсэн. (2012 оны 1 сарын 21 хүртэл)
2007 он 07 сарын 16	Төвийн 5 жилийн ойн арга хэмжээнд Японы эрхэм дээд угсаа залгамжлах ханхүү Нарүхито морилон ирсэн.
2009 он 07 сарын 03	Үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 1,000,000-д хүрсэн.
2012 он 01 сарын 22	ЖАЙКА-ын техникийн хамтын ажиллагаа бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх төслийг эхлүүлсэн
2012 он 04 сарын 01	Япон сангийн хэлний төвийн төслийг эхлүүсэн.
2012 он 04 сарын 13	Монгол Улсын Их Сургуулийн бүрэлдэхүүн, санхүүгийн бие даасан нэгж болсон.
2012 он 06 сарын 21	Төвийн 10 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан.
2015 он 04 сарын 22	Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх төслийг эхлүүлсэн.
2016 он 04 сарын 01	Үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 2,000,000-д хүрсэн.
2017 он 06 сарын 14	Канэко Харүкогийн вааран урлалын “Аз жаргалын цэнхэр хана” бүтээлийн нээлтийн ёслол.
2017 он 06 сарын 21	Төв байгуулагдсаны 15 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан.
2020 он 04 сарын 22	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх, бизнесийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх төсөл
2020 он 10 сарын 19	Үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 2,500,000-д хүрсэн.
2022 он 06 сарын 21	Төв байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан.





## АЛСЫН ХАРАА

Монгол улсын ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг бэлтгэж, Монгол, Япон хоёр улсыг холбогч гүүр болон ажиллах болно.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Үйлчлүүлэгчдийн эрэлтэд нийцсэн үйлчилгээ бий болгон хэрэгжүүлж, Монгол, Япон хоёр улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна.

## УРИА

Монголын ирээдүйг энд хөгжүүлье!

## ҮНЭТ ЗҮЙЛС

- ✓ Монгол дахь япон орчин
- ✓ Япон маягийн үйлчилгээ, японы талаарх мэдээллийг түгээх
- ✓ Японд хуримтлуулсан мэдлэг, мэдээллийг түгээх
- ✓ Чадварлаг Монгол, Япон ажилтнуудын баг
- ✓ МУИС болон бусад байгууллагуудын хамтын ажиллагаа
- ✓ ЖАЙКА, Япон сан ба японы бусад байгууллагуудын хүчтэй дэмжлэг





# ГАРЧИГ

## ӨМНӨХ ҮГ

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн захирал Ц.Даваадорж.....7

## МЭНДЧИЛГЭЭ

Япон улсаас Монгол улсад суугаа  
Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Игавахара Масарү.....8

МУИС-ийн захирал, доктор Д.Бадарч.....9

ЖАЙКА Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Танака Шиничи.....10

Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
Япон сан Япон хэлний 1-р хэлтсийн дарга Ёцүя Томоаки.....11

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Ерөнхий зөвлөх,  
ЖАЙКА-ын мэргэжилтэн Изаки Хироши.....13

## I. БИЗНЕСИЙН СУРГАЛТЫН ТАСАГ

**1. 2022 онд зохион байгуулсан бизнесийн сургалт, семинарын тайлан.....15**

Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын хэрэгжилт.....15

1) Танхимын сургалт “Бизнесийн сургалт” .....15

2) “Ажлын байран дээрх сургалт” болон “Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх  
хөтөлбөр” .....18

3) Япон дахь дадлага сургалт.....19

**2. Монгол-японы хүний нөөцийн хөгжлийн төвийн бизнесийн хамтын ажилгааг  
дэмжих ажил.....32**

1) Бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа илүү өргөжин илүү  
олон төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаа.....32

2) “Монгол-японы бизнес форум 2023”-ыг амжилттай зохион байгууллаа.....34

**3. Онцлох мэдээ.....35**

1) Жайка-ийн хувийн хэвшлийн хамтын ажиллагааны төслийн хэрэгжилтийн  
жишээ.....35

2) Бизнесийн ахисан түвшний сургалт Завхан аймагт анх удаа амжилттай зохион  
байгууллаа.....36

3) “Global value chain” сэдэвт ахисан түвшний шинэ сэдэв нэмэгдлээ.....37

4) “ICT/digital Business Study Tour in Mongolia” зохион байгуулав.....38

**4. Төгсөгчдийн дуу хоолой.....39**



## II. ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТАСАГ

<b>1. 2023 онд зохион байгуулсан япон хэлний сургалт, семинарын тайлан</b> .....	44
1) Япон хэлний сургалтын талаар.....	44
2) Хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны талаар.....	45
<b>2. Онцлох мэдээ</b> .....	62
1) “Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт” /Шинэ сургалт/.....	62
2) “Бизнесийн япон хэлний сургалт” /Шинэ сургалт/.....	63
3) “Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”.....	64
4) “Кёото их сургуульд элсэн орохын өмнөх япон хэлний бэлтгэл сургалт-2023”....	65
5) “Тусгай ур чадварын тогтолцоо” гэрээт ажлын хүрээнд.....	66
<b>2. Үйл ажиллагааны талаарх онцлох мэдээ</b> .....	69
1) “ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалт-2023”.....	69
2) “15 дахь удаагийн япон хэлний боловсролын симпозиум”.....	70
3) “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 29 дэх удаагийн тэмцээн”....	71
<b>3. Суралцагчдын дуу хоолой</b> .....	72

## III. НОМЫН САН, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАСАГ

<b>1. 2023 оны үйл ажиллагааны ерөнхий тайлан</b> .....	82
1) Номын сангийн үйл ажиллагаа.....	82
2) Япон киноны өдөр.....	83
3) Нээлттэй семинар.....	83
4) Японд суралцах мэдээллийн яармаг-2023.....	83
5) Гэрээгээр гүйцэтгэх ажил.....	84
<b>2. Онцлох мэдээ</b> .....	87
1) “Японд суралцах талаар цахим мэдээллийн яармаг – 2023”.....	87
2) 83-р нээлттэй семинар: “Өдгөө ч өдөр тутамдаа өмссөөр буй үзэмж төгөлдөр үндэсний хувцас ДЭЭЛ”.....	89



3) Хакүходо боловсролын сангийн “Япон хэл, солилцооны хөтөлбөр”.....	91
4) Зохиолч уншигчдын уулзалт: Мүраками Харүки “Эрэг дээрх Кафка” номын хэлэлцүүлэг.....	92
5) Япон соёлын танилцуулга хичээл “Юката өмсөгчөө”.....	94
6) Японд амьдрахад таны мэдвэл зохих шаардлагатай багц мэдээлэл.....	95

#### **IV. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ТАСАГ**

<b>1. 2023 оны үйл ажиллагааны ерөнхий тайлан.....</b>	<b>98</b>
<b>2. Онцлох мэдээ.....</b>	<b>101</b>
1) Олон улсын тэмцээнийг амжилттай хамтран зохион байгууллаа.....	101

#### **V. БАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

<b>1. 2023 оны багуудын үйл ажиллагааны тайлан.....</b>	<b>103</b>
1) Маркетингийн баг.....	103
2) 5S Кайзен баг.....	104
3) Эрүүл мэнд, спортын баг.....	105
4) Үйл ажиллагаа зохион байгуулах баг.....	106





## ӨМНӨХ ҮГ



2023 оны ажлын тайлангаа Та бүхэнд толилуульж байна.

2023 онд БИД 37 төрлийн 276 ажил хэрэгжүүлсэн. Нийт төлөвлөсөн ажлын биелэлт 100.7% боллоо.

Төвийн нийт ажиллагсдын дундаж цалин 2.1 сая төгрөгт хүрсэн нь Монгол улсын дундаж цалингаас өндөр байгаа юм. Гэвч улсын хэмжээгээр инфляци 9.4%-тай гарсан нь бодит цалин буурахад хүрсэн юм.

Ажиллагсдын тоонд ч өөрчлөлт гарсан. Өмнө батлагдсан боловч орон тоо эзгүй байсан ерөнхий менежерийн албан тушаалд Батдэлгэр багшийг сонгон шалгаруулж, 40%-ийн цалинтай ажиллуулах болов. Баярмаа нь ЖАЙКА-гийн тэтгэлэгээр, Япон улсад суралцаж, төгсөөд ажилдаа буцаж ирсэн.

Санхүүгийн байдал ч хэвийн үйл ажиллагааг явуулах боломж олгож байна. 2023 оны төлөвлөгөөт орлогыг 9.2%-иар давуулж, зарлагаа 2.1%-иар хэмнэж чадлаа. Япон улсын ЖАЙКА байгууллага болон Япон сангийн дэмжлэг урьдын адил үргэлжилж байна. Жилийн нийт төсвийн 30 орчим хувийг дээрх 2 байгууллагын санхүүжилт эзэлж байна. 2023 оны төвийн дулаан, цахилгаан, усны төлбөр болох тогтмол зардлын ихэнх хэсгийг БШУЯ-ны төсвөөс санхүүжүүлсэн нь томоохон дэмжлэг болсон юм. Төвийн жилийн төсвийн 2%-тай тэнцэх 32 сая төгрөгийн санхүүжилтийг БШУЯ-наас олгосон.

2023 оны дэлгэрэнгүй тайланг энэ товхимолоос танилцах боломжтой. Энэ жилийн тайланг өмнө жилийн нэгэн адил цахим хэлбэрээр гаргаж байна.

Бидний үйл ажиллагааг ямагт дэмжиж, тусалж байдаг хамтран ажиллагч Японы болон Монголын бүх байгууллага, хувь хүмүүст халуун талархлаа дахин дахин илэрхийлье. Та бүхний дэмжлэг, туслалцаа, хамтын ажиллагаа байгаа учраас манай төвийн үйл ажиллагаа үргэлж урагш ахиж, амжилт дүүрэн байдаг.

Манай хамт олон ч цаашид ихээр хичээн, өөрсдийн чадвар, мэдлэгээ бүрэн дайчлан ажиллах болно. Та бүхний дэмжлэг, туслалцаа, хамтын ажиллагааг амжилттай болгон, төвийнхөө нэр хүндийг өндөрт өргөн явахаа амлаж байна.

Монголын ирээдүйг гэрэлтэй, гэгээлэг болгохын төлөө МЯТ-ийн хамт олон ажил үүргийнхээ хүрээнд бүхнийг хийх болно. Бүх хүмүүст сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Баярлалаа.

*Монгол-Японы Хүний Нөөцийн хөгжлийн төвийн  
Захирал Ц.Даваадорж*



## МЭНДЧИЛГЭЭ



2023 он бол Япон, Монгол хоёр орны ард иргэдийн харилцаа аажмаар сэргэж, төрөл бүрийн харилцан солилцоо явагдсан жил байлаа. Хоёр орны холбогдох талууд төрөл бүрийн чиглэлд харамгүй сэтгэлээр дэмжлэг үзүүлж ирсэнд Япон Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс гүнээ талархаж буйгаа илэрхийлье.

Миний бие 2023 оны 12 дугаар сард Улаанбаатар хотод томилогдон ирсэн билээ. Би өнөөг хүртэл Япон, Хятадын харилцаанд оролцож ирсэн ч энэ хугацаандаа үе үе Япон, Монголын харилцаа, түүнтэй холбоотой ажилд оролцож байсан билээ. 1988 онд Бээжин хотоос албан томилолтоор анх Монголд ирж байснаас хойш 1991 онд Япон Улсын Ерөнхий сайд Т.Кайфү төрийн тэргүүний хувиар Монгол Улсад анх удаа айлчлал хийх үеэр Улаанбаатар хотод бэлтгэл ажлын багт ажиллаж байсан. Мөн эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр /ЕРА/ байгуулах урьдчилсан хэлэлцүүлэгт оролцож, Японы компаниудтай нүүрсний уурхайг үзэж танилцаж байснаас гадна гэр бүл, найз нөхдийн хамт хувиараа ирж байсан тул Монгол Улс миний дуртай орнуудын нэг болсон билээ. Монгол Улсад Элчин сайдаар томилогдон ажиллах болсноо туйлын их аз завшаантай хэрэг хэмээн бодож байна.

Япон Улс нь Монгол Улстай өнөөг хүртэл найрамдалтай харилцааг бүтээж ирсэн билээ. Энэхүү найрсаг харилцаа олон ахмад үеийнхэн болон холбогдох хүмүүсийн уйгагүй хичээл зүтгэлийн үр дүн юм. Үүний дотроос Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв томоохон үүрэг гүйцэтгэж, 20 гаруй жилийн хугацаанд Япон хэлний сургалт, Япон, Монголын хүн хоорондын харилцаа холбоо тогтоох төв, бизнесийн хүний нөөцийг бэлтгэх зэрэг цаг үе болон хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлсээр ирсэн билээ. Би хэд хоногийн өмнө хот дотор үл таних нэг монгол залуу хүнтэй япон хэлээр ярилцсан юм. Тэрээр ахлах ангийн сурагч бөгөөд Япон Улсад очиж үзээгүй хэр нь япон хэлээр чөлөөтэй ярьж байсан нь гайхшрал төрүүлж, Монгол-Японы төвд япон хэл суралцаж буйг нь сонсоод, тус төв нь хоёр орны харилцааны ирээдүйг авч явах боловсон хүчнийг бэлтгэх чухал тулгуур болж байгаа гэдгийг мэдэрсэн билээ.

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь цаашид ч Монгол Улсын хөгжил болон Япон, Монголын харилцааг бэхжүүлэх үйлсэд улам их хувь нэмэр оруулахыг хүсэн ерөөж байна.

*Япон Улсаас Монгол Улсад суугаа  
Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд Игавахара Масарү*



## МЭНДЧИЛГЭЭ



МУИС-ийн Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь манай улсын ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг бэлтгэж, хоёр орны эдийн засгийн түншлэлийн гэрээг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн ба хоёр улсын эрдэмтэд, мэргэжилтнүүд, бизнес эрхлэгчдийг холбож, Монгол Японы хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх чиглэлээр ажиллах үүргээ нэр төртэй хэрэгжүүлж ирсэн бөгөөд цаашид ч улам эрчимжүүлэх зорилготой ажиллаж байна.

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны үр өгөөжийг улам сайжруулах зорилгоор Хамтран зохицуулах хороо чармайн ажиллаж ирснийг тэмдэглэх нь зүйтэй.

Энэ ялдамд Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг байнга дэмжиж ирсэн Япон Улсын ЭСЯ, ЖАЙКА, “Япон сан”, Монгол Улсын Боловсрол Шинжлэх ухааны яам, Сангийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам болон бусад байгууллага, хүмүүст МУИС-ийн хамт олны өмнөөс талархал илэрхийлье.

МУИС-ийн хамт олон тус төвийн үйл ажиллагааг тогтвортой, найдвартай, үр өгөөжтэй авч явахын тулд Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн сургалт, судалгааны ажилд хамтран оролцож, хүчээ нэгтгэн ажиллаж, хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргахад хүчин чармайлт гаргаж ажиллах болно.

Та бүхэнд сайн сайхныг хүсье.

*МУИС-ийн захирал Д.Бадарч*





## МЭНДЧИЛГЭЭ



Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн төслийн 2-р шатны төсөл эхэлснээс хойш бараг дөрвөн жилийн хугацаа өнгөрчээ. Төсөл хэрэгжих хугацаанд Монгол-Японы хөгжлийн төвийн хамт олны хичээл зүтгэлийн үрээр коронавирусын цар тахлын нөлөөнд хамгийн их өртсөн хувийн хэвшлийн салбарынханд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа тасралтгүй хэрэгжиж байсанд чин сэтгэлээсээ талархаж байна.

2023 онд Монгол, Япон орны хооронд зорчигч тээврийн хөдөлгөөн бүрэн сэргэснээр Монгол-Японы хөгжлийн төвийн гол үйл ажиллагаа болох бизнесийн сургалт, бизнесийн солилцоо, хүний нөөцийн карьер хөгжлийг дэмжих үйл ажиллагаа эрчимжиж, өргөн цар хүрээтэй үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Тухайлбал, гадаадад хүний нөөц илгээхтэй холбоотойгоор Ибараки мужтай хамтран зохион байгуулсан “Ибараки мужийн хөдөлмөр эрхлэлтийн семинар”, бизнесийн сургалтыг амжилттай дүүргэсэн компанийн төлөөллүүдийн Япон дахь сургалт, Монгол-Японы бизнес форум, Япон фестиваль зэрэг томоохон арга хэмжээнүүд, мөн Монголын стартап компаниудын Япон дахь pitch event зэргийг зохион байгуулахад Монгол-Японы хөгжлийн төв чухал үүрэгтэй оролцсон юм.

2024 оны 3-р сард Монгол-Японы хөгжлийн төв нь ЖАЙКА, Монгол Улсын Засгийн газар, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Японд сургууль төгсөгчдийн нийгэмлэг (JUGAMO)-тэй хамтран Азийн хамгийн том хүнс, хүнс үйлдвэрлэлийн үзэсгэлэн болох “FOODEX JAPAN 2024”-д анх удаа Монголын павильоныг гаргахад дэмжлэг үзүүлсэн бөгөөд уг үзэсгэлэнд Монголын хүнсний салбарын таван аж ахуйн нэгж оролцсон юм. Үзэсгэлэнд оролцсон компаниудад үзэсгэлэнд хэрхэн оролцох, бизнесийн яриа хэлэлцээр хэрхэн хийх талаар болон маркетинг, экспортын чиглэлээр техникийн дэмжлэг үзүүлсэн. Цаашид ч FOODEX JAPAN зэрэг үзэсгэлэнд оролцох үйл ажиллагааг дэмжиж ажилласнаар Монгол, Японы хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн бизнесийн хамтын ажиллагаа улам бүр өргөжин тэлнэ гэж найдаж байна.

Монгол-Японы хөгжлийн төв болон ЖАЙКА-ийн хамтын үйл ажиллагааг байнга дэмжиж, хамтран ажилладаг та бүхэнд талархал илэрхийлье. Одоо хэрэгжиж буй төсөл дуусахад жил хүрэхгүй хугацаа үлдсэн хэдий ч Монгол-Японы хөгжлийн төв нь цаашид ч хоёр орны бизнесийн харилцаа болон харилцан ойлголцлын гүүр болон үйл ажиллагаагаа явуулахад ЖАЙКА-ийн зүгээс бүх талаар дэмжиж хамтран ажиллах болно.

Та бүхэнд амжилт хүсье.

*ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга  
Танака Шиничи*



## МЭНДЧИЛГЭЭ



Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь /цаашид Монгол-Японы төв гэх/ 2002 онд үүсгэн байгуулагдсанаас хойш Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжил, Монгол-Япон хоёр орны харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах олон тооны хүний нөөцийг бэлтгэж ирсэн билээ. Түүнчлэн Монгол улсад япон хэлний боловсролыг түгээн дэлгэрүүлэхийн төлөө хичээнгүйлэн зүтгэсээр ирсэн. Энэхүү мэндчилгээгээр дамжуулан Ц.Даваадорж захиралтай тус төвийн хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Япон сан нь тус төвийн үйл ажиллагааны үндсэн 4 багана болох бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, япон хэлний боловсролыг түгээн дэлгэрүүлэх, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, Монголын хүний нөөцийг дэмжих зорилго бүхий үйл ажиллагаануудаас япон хэлний боловсрол болон харилцаа хамтын ажиллагааны салбартай хамтран ажилласаар ирсэн билээ.

2002 оноос өнөөг хүртэл Япон сангийн япон хэлний мэргэжилтэн багшийг томилон ажиллуулж, улмаар 2012 оны 4 сараас эхлэн тус төвтэй хамтран “Япон сангийн хэлний төв” төслийн хүрээнд “Япон сангийн япон хэлний сургалт”-ыг зохион явуулсаар байна. Япон сангийн япон хэлний сургалт нь “Япон хэлийг ашиглан юуг хэрхэн чаддаг болох вэ?” буюу “Асуудал шийдвэрлэх чадвар”, харилцагчийнхаа соёлыг ойлгож хүндэтгэх буюу “Өөр бусдын соёлыг ойлгох чадвар”-ыг хөгжүүлэхийг гол зорилгоо болгосон “Япон сангийн япон хэлний боловсролын стандартад” тулгуурлан явагддаг. Мөн энэхүү сургалтад Япон сангаас боловсруулан гаргасан “Марүгото япон хэл ба соёл” сурах бичгийг ашиглан япон хэлний анхан шатнаас дунд шат хүртэлх түвшний сургалтуудыг зохион явуулсаар ирлээ. Монгол-Японы төв нь япон хэлний өндөр мэдлэгтэй дээд түвшний сурагчдад зориулсан сургалт, зуны улиралд хүүхдэд зориулсан япон хэлний сургалт зэрэг Монгол улсад япон хэлийг сонирхон суралцаж буй нийт суралцагчдад хүртээмжтэйгээр, тэдний хэрэгцээ шаардлагад нийцүүлж, Монгол дахь япон хэлний боловсролын орчин нөхцөлд тохируулан төрөл бүрийн сургалтуудыг бэлтгэн явуулсаар байна. Япон сангийн япон хэлний сургалтыг зохион байгуулж эхэлснээс хойш эдүгээ 10 гаруй жил өнгөрч буй бөгөөд энэ хугацаанд цар тахлын нөхцөл байдал зэргээс үүдэн сургалтуудыг цахим хэлбэрт шилжүүлэх, сургалтад багшилж буй боловсон хүчнийг илүү чадваржуулах зэргээр тухайн үеийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад уялдуулан уян хатан байдлаар хандаж хичээнгүйлэн ажилласаар ирсэн билээ. Энэ хугацаанд хуримтлуулж ирсэн туршлага, ноу-хаугаа бүрэн дүүрэн ашиглаж, цаашид ч гэсэн үр дүн бүхий чанартай сургалтуудыг зохион явуулахыг зорин ажилласай хэмээн хүсэж байна.

Япон сангийн хэлний төв нь япон хэлний сургалтаас гадна Японд жилийн туршид тогтмол болдог баяр ёслол, үйл ажиллагааг танилцуулах зорилго бүхий соёлын сургалт, япон хэл соёлтой холбоотой олон төрлийн ном, сурах бичгээр баялаг номын сангийн үйл ажиллагааг явуулахад ч мөн хамтран ажилладаг. Цаашлаад сүүлийн жилүүдэд ажлын байран дээрх япон хэлний мэдлэгийн хэрэгцээ ихсэхийн хэрээр “Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт”, “Бизнесийн япон хэлний сургалт” зэрэг шинэ сургалтуудыг зохион байгуулж үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлсээр байна.



Мөн Монгол дахь япон хэлний боловсролыг улам бүр хөгжүүлэхийг зорьж, Япон сангаас томилогдон ажиллаж буй япон хэлний мэргэжилтэнтэй хамтран ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалтыг ч гэсэн амжилттай зохион явуулсаар байна. Үүний дээр 2019 оноос хэрэгжиж буй “Тусгай ур чадвартай ажиллах хүч”-ний тогтолцоогоор Япон улсад ажиллаж амьдрах хүсэлтэй иргэдэд зориулан бэлтгэн гаргасан “Иродори: Хэрэглээний япон хэл” сурах бичгийг ашигласан заах аргын сургалтыг амжилттай зохион байгуулж байна.

Япон сан нь цаашид ч гэсэн Монгол-Японы төвтэй хамтран үйл ажиллагаагаа өргөжүүлж, олон монгол хүмүүст япон хэл соёлтой танилцах, суралцах боломжийг олгохоор хичээн ажиллах болно. Монгол-Японы төв нь цаашид ч гэсэн япон хэлний боловсрол, япон соёлыг түгээн дэлгэрүүлэх гол байгууллага болж, хоёр улсын гүүр болох хүний нөөцийг улам бүр хөгжүүлэхийн төлөө хичээн ажиллахыг чин сэтгэлээс хүсэн ерөөе.

*Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Япон сан  
Япон хэлний 1-р хэлтсийн дарга Ёцүя Томоаки*





## МЭНДЧИЛГЭЭ



2023 он нь, ЖАЙКА-аас хэрэгжүүлж буй 5 жилийн хамтын ажиллагааны “Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх болон Монгол-Японы бизнесийн хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх” төслийн 4 дэх жил нь болж байна. “Ковид-19”-ын нөлөө намжиж, Монгол-Японы төв нь хэвийн үйл ажиллагаандаа орж, Япон болон Монгол улсын хоорондын хамтын ажиллагаа ч улам нэмэгдэж, төсөл маань ч төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна.

Миний бие 2023 оны 6 дугаар сарын сүүлчээр томилогдон ирээд, энэ төвийн нэг гишүүн болсон билээ. Монгол улсын нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжил болон өөрчлөлтийг өөрийн биеэр мэдэрч байна. Эдгээр өөрчлөлттэй харилцан уялдаатай ажиллахын тулд бид цаашдаа төвийн үйл ажиллагааг тогтмол сайжруулахын сацуу хэд хэдэн санаачилгыг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

Юуны өмнө, Монгол-Японы төв дээрх төслийн хүрээнд Япон улсын орон нутгийн засаг захиргаа, албан байгууллага, их дээд сургууль зэрэг хамтын ажиллагааг дэмжиж, цаашлаад түлхэц өгч, Япон улсын их дээд сургуулиудыг оюутнуудад таниулах, Монгол улсын хүний нөөцийг Япон улсын компаниудад ажиллуулах, хоёр улсын бизнесийн хамтын үйл ажиллагаа зэрэгт дэмжлэг үзүүлэх тал дээр илүү идэвхтэй ажиллахыг хүсэж байна.

Мөн, Монгол Япон улсын харилцаанаас гадна гуравдагч орны компаниудтай хамтын ажиллагааг өргөжүүлэхээр төлөвлөж байна. Тодруулбал, Монгол-Японы төвтэй адил 9 орон дахь 10 Япон төвтэй хамтын ажиллагаа хийхээр зорьж байна. Тухайлбал, Киргиз, Казакстан, Узбекистан зэрэг Төв Азийн орнууд, Вьетнам, Камбож зэрэг Зүүн өмнөд Азийн орнуудад үйл ажиллагаагаа явуулж буй Япон төвүүдээр дамжуулан, эдгээр улсуудын компаниудыг Монгол дахь компаниудтай холбох ажлыг дэмжин ажилламаар байна. Энэ нь Монгол компаниудад өөрсдийн чадвар, чадамжаа нотлон харуулах боломжийг олгоно гэдэгт итгэж байна.

Дээр дурдсанчлан, ЖАЙКА-гийн Япон төвийн төсөл нь олон оронд хэрэгжиж байгаа бөгөөд нийтлэг үндсэн санаа нь “Япон төв 2.0 санаачилга” дор урагшилж байна. Энэ нь, Япон төвийг бизнесийн хамтын ажиллагааны төв болгон, Япон болон Монгол компаниудыг голчлон бизнес эрхлэгчид, дэмжлэг үзүүлэгч байгууллага, судалгааны хүрээлэнгүүд зэрэг холбогдох Япон улсын бүхий л байгууллагуудыг хооронд нь холбох үндсэн талбар болох зорилго юм.

Монгол-Япон төвийн хувьд ч мөн адил Монгол дахь харилцаа холбооны суурь болсон, одоог хүртэлх хүчин чармайлтаа улам ахиулж, хүн бүрийн итгэлийг хүлээсэн, тэр итгэлийг даахуйц өсөн дэвжсэн төв болохыг зорьж байгаа тул цаашдаа ч та бүхнийг тусалж, дэмжинэ гэдэгт итгэлтэй байна.

*Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Ерөнхий зөвлөх  
(ЖАЙКА-ийн мэргэжилтэн) Изаки Хироши*

# БИЗНЕСИЙН СУРГАЛТЫН ТАСАГ





## 1. 2023 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН БИЗНЕСИЙН СУРГАЛТ, СЕМИНАРЫН ТАЙЛАН

Бизнесийн сургалтын тасаг нь бизнесийн төрөл бүрийн сургалт, семинар, зөвлөгөөг Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын дэмжлэгтэйгээр Монголын бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулж байна. 2023 онд корона вирус нөхцөл байдал намжиж эдийн засгийн сэргэлт ирсэнийг мэдэгдүүлэхүйц жил болж өнгөрлөө. Эдийн засгийн сэргэлтийн нөлөөгөөр сургалтад хамрагсад болон Япон улсаас Монголд үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр ирж буй бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдэж байна.

Бизнесийн үндсэн сургалтыг Удирдлагын ангид 6 сэдвээр, Менежерийн ангид 4 сэдвээр тус тус 2 удаа явагдаж нийт 20 удаа, бизнесийн суурь мэдлэгийн сургалтыг 8 сэдвээр 9 удаа, ахисан түвшний сургалтыг Улаанбаатар хотод 10 сэдвээр 11 удаа, Завхан аймагт 2 сэдвээр 2 удаа, бизнесийн нээлттэй семинарыг 4 сэдвээр 4 удаа, ажлын байран дээрх сургалтыг 18 компани дээр 35 удаа амжилттай зохион байгууллаа. 2023 оны нийт сургалтад 3,310 хүн хамрагдсан байна. Монгол-Японы төвийн бизнесийн сургалтуудыг арвин туршлагатай япон, монгол багш нар удирдан явуулж, бизнест бодитоор тус болохуйц мэдлэг олгодгоороо давуу талтай. Суралцагчдын 95-ээс дээш хувь нь сургалтыг өндрөөр үнэлэн, сургалтаас сурсан, мэдсэнээ ажлын байран дээрээ хэрэгжүүлж байна.

### 1. Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын хэрэгжилт

#### 1) Танхимын сургалт “Бизнесийн сургалт”

1. Бизнесийн сургалтын тасгийн **үндсэн сургалт** болох “Жижиг, дунд аж ахуйн нэгжийн менежментийг сайжруулах оношилгоо зааварчилгаа, шинжилгээ” сэдэвт бизнесийн практик сургалтыг суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн жилд хоёр удаа (намар, өвлийн элсэлт) зохион байгуулдаг. Тус сургалтын зорилго нь зах зээлийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр болохуйц хүний нөөцийг хөгжүүлж, Монголын аж ахуйн нэгжийг хөгжүүлэх, цаашлаад Монгол улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад оршино.

Бизнесийн үндсэн сургалтын суралцагчдыг удирдлагын болон менежерийн гэсэн хоёр ангид элсүүлэн, стратегийн менежмент, маркетинг, санхүүгийн удирдлага, хүний нөөцийн удирдлага гэсэн менежментийн үндсэн 4 сэдвээр зохион байгуулдаг бөгөөд удирдлагын ангид удиртгал болгож “Япон маягийн менежмент”, “Конплаенс” сэдэвт хоёр сургалтыг нэмэлтээр орж байна.



Зураг 1-1. Бизнесийн үндсэн сургалтын Удирдлагын анги  
Стратегийн менежмент сургалтын явцаас





*Зураг 1-2. Бизнесийн үндсэн сургалтын  
Менежерийн ангийн сургалтын явцаас*

Энэ жил бизнесийн үндсэн сургалтыг хавар, намар 2 удаа бүрэн танхимаар амжилттай зохион байгуулж, 4 ангид нийт 127 компани, аж ахуйн нэгжийн нийт 138 удирдах ажилтан, менежер суралцаж төгссөн байна.

Өмнөх жилүүдийн адил онол, практик хосолсон хэлбэрээр явагдсан ба суралцагчид тус тусын компанийн жишээ болон тулгамдаж буй асуудлаар санал бодлоо чөлөөтэй солилцож, зөвхөн мэргэжилтэн багшаас суралцах төдийгүй харилцан суралцах нөхцөл бүрдсэн сургалт болж өндөрлөлөө. Түүнчлэн жил ирэх тусам суралцагчдын түвшин нэмэгдэж байгааг Япон мэргэжилтэн багш нар онцолж байсан юм.

Мөн энэ хичээлийн жилээс эхлэн Менежерийн ангийн “Стратегийн менежмент”, “Хүний нөөцийн менежмент” хичээлийг үндэсний сургагч багш хариуцан удирдан явуулсан нь уг сургалтын нэгэн онцлог байлаа. Үндэсний сургагч багш буюу Монгол багш нар сургалтыг удирдаж орохын нэгэн давуу тал нь сургалт орчуулгагүй байдгаараа ажлын талбарт байнга сорилттой тулгарч байдаг менежерүүдэд зориулан олон талын агуулгыг багтаах боломжтой болж байгаа юм.

Монгол-Японы төв нь үндсэн сургалтаас гадна суралцагчдын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн танхимаар ахисан түвшний болон суурь мэдлэгийн сургалтыг зохион байгуулдаг. Мөн танхимын бус сургалт болох ажлын байран дээрх сургалт болон загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөрийн дагуу төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулдаг.

**2. Ахисан түвшний сургалтыг** “Менежментийн симуляци”, “Дэлгүүрийн удирдлага”, “Хүний нөөцийн удирдлага”, “Санхүүгийн удирдлага”, “KPI ба чадамжийн удирдлага”, “Эксэлээр бизнесийн шинжилгээ хийх нь”, “Үйлдвэрлэлийн удирдлага” сэдвүүд болон шинээр “Global Value Chain”, “Бизнес төлөвлөгөө”, “Үзэсгэлэн яармагт хэрхэн амжилттай оролцох вэ” сэдвийн сургалтуудыг танхимаар зохион байгуулж, нийт 335 хүн хамрагдсан байна. Мөн энэ жил Завхан аймагт Стратегийн менежмент, Хүний нөөцийн удирдлага сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан нь онцлогтой байлаа.



Зураг 2. Ахисан түвшиний сургалтын явцаас



Зураг 3. “Санхүүгийн удирдлага” сэдэвт ахисан түвшиний сургалтын явц

Монгол-Японы төвийн бизнесийн сургалтыг бизнесийн бодит хэрэгцээнд нийцсэн агуулгаар, арвин туршлагатай япон болон монгол багш нар заадаг. Сургалтын дараах судалгаагаар суралцагчдын 94% нь сургалтыг өндрөөр үнэлсэн байна.

3. **Бизнесийн суурь мэдлэгийн сургалтыг** 2016 оноос эхлэн зохион байгуулж байна. 2017 оноос эхлэн бямба гарагт зохион байгуулдаг болсноор илүү олон компанийн ажилтнууд амралтын нэг өдрөө менежментэд суралцан үр өгөөжтэй өнгөрөөх боломжийг бүрдүүлж өгсөн юм.

Энэ жилийн хувьд суурь мэдлэгийн сургалтуудын ойлголт, үр дүнг нэмэгдүүлэхийг зорьж доорх сэдвүүдээр бүрэн танхимаар зохион байгуулсан юм. Үүнд “Хүний нөөцийн менежмент” “Дэлгүүрийн удирдлага”, “5S хөдөлгөөн”, “Санхүүгийн удирдлага”, “Үйлдвэрлэлийн удирдлага”, “Төслийн менежмент” “Стратегийн менежмент” “Япон маягийн менежментийг монгол удирдахуйн ухаантай хослуулах нь” сэдвээр амжилттай зохион байгууллаа. Санхүүгийн удирдлага сэдвээр 2 удаа бусад сэдвүүдээр тус бүр 1 удаа зохион байгуулсан бөгөөд нийт 9 удаагийн 8 сэдвээр суурь мэдлэгийн сургалт зохион байгууллаа.



Зураг 4. “Хүний нөөцийн удирдлага” сэдэвт бизнесийн суурь мэдлэгийн сургалт



Зураг 5. “Дэлгүүрийн удирдлага” сэдэвт бизнесийн суурь мэдлэгийн сургалт





## 2. Ажлын байран дээрх сургалт” болон “Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөр

Монголын компаниудад бизнесийн орчны өөрчлөлт, өрсөлдөөн нэмэгдэж байгаатай уялдан зөвхөн удирдах албан тушаалтнаа хөгжүүлээд зогсохгүй байгууллагын стратегид үндэслэн компанийг бүх талаар нь бэхжүүлэх, нийт ажилтнуудын мэдлэг, ур чадварыг ахиулахыг чухалчилж байна. Иймээс байгууллагын удирдах албан тушаалтныг сонгон, гаднын сургалтад хамруулахын зэрэгцээ компани дотроо нэг ойлголттой болохыг зорилгоо болгон олон төрлийн сургалтыг идэвхтэй зохион байгуулдаг болжээ.



Зураг 6. Apollo building service ХХК дахь “5S-хөдөлгөөн” сэдэвт сургалтын үеэр сэдэвт цахим сургалтын явц

Энэ эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тус төв нь аж ахуйн нэгжүүдийн менежментийн үр дүн, бүтээмжийг сайжруулах, хүний нөөцийн менежмент болон сургалт хөгжлийн системийг бий болгох зорилгоор ажлын байран дээрх сургалт, загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж монгол компаниудын оновчтой удирдлага, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд түлхүү анхааран ажиллаж байна.

Тус төв нь ЖАЙКА-ийн мэргэжилтэн болон үндэсний сургагч багш нар байгууллагын хүсэлтийн дагуу, компанид тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилготойгоор ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж ирсэн билээ. 2023 онд давхардсан тоогоор 20 компанид 39 удаа сургалт орж, нийт 872 хүн хамрагдсан байна. 2023 оны хувьд Байгалийн чулуун хийц ХХК-11 удаа, МЯК ХХК-7 удаа, ENC групп-3 удаа, Түмэн Шувуут ХХК-3 удаа г.м. нэг компани дээр олон давтамжтай, системтэйгээр, хоорондоо уялдаа холбоотой сургалтуудыг орсон нь илүү онцлогтой байлаа. Сургалтын өмнө багш болон байгууллагатайгаа урьдчилсан уулзалтыг шаардлагатай тохиолдолд заавал хийж, агуулга, сургалтын хэрэгцээ хүсэлтийг сонссоны дагуу зохион байгуулсан тул сургалтын дундаж сэтгэл ханамж өмнөх оныхоос 4 орчим хувиар өсч 97% үзүүлэлттэй гарсан.



Зураг 7. Байгалийн чулуун хийц ХХК дахь сургалтын явц



“Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөр”-т 2022-2023 оны хичээлийн жилийн хамрагдагч 2 компани хөтөлбөртөө үргэлжлүүлэн хамрагдаж, 1 компани шинээр нэмэгдсэнээр нийт 3 компанид тус тусын хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт, зөвлөгөөг шат дараатайгаар зохион явууллаа.



Зураг 8. Премиум Палас ХХК дахь “Манлайлал” сургалтын явц

Тус хөтөлбөрт хамрагдаж буй компаниудад нийт компанийн түвшний стратеги тодорхойлох, түүнтэй уялдсан нэгжийн стратеги болон хүний нөөц хөгжүүлэлт, ялангуяа компанийн гол цөм болох дунд түвшний удирдах ажилтны сургалт, хөгжүүлэлт хэмээх агуулгаар голчлон сургалт, зөвлөгөө зохион байгуулж байна. Эдгээр агуулга нь манай орны ихэнх компани, аж ахуйн нэгжүүдэд нэн шаардлагатай, тулгамдаж буй асуудлын нэг юм болов уу хэмээн ажиглагдаж байна.

### 3. Япон дахь дадлага сургалт

2023 оны 10 сард Японы Китакюүшү хотод дадлага сургалтыг зохион байгуулж, бизнесийн үндсэн сургалтын 16 төгсөгч, үндэсний сургагч 4 багш, Монгол-Японы төвийн 2 мэргэжилтэн гээд нийт 22 хүн хамрагдлаа.

Энэхүү дадлага сургалтад бизнесийн үндсэн сургалтаар суралцсан агуулгыг япон компаниуд хэрхэн хэрэгжүүлж байгаа бодит байдалтай танилцах, япон маягийн менежментийн үндэс болох кайзэн хэрэгжүүлсэнээр ямар үр дүнд хүрч болохыг таниулах зорилгоор 2003 оноос өдийг хүртэл зохион байгуулж ирсэн.



Зураг 9. Тойота Кюүшү Моторс компани дээрх айлчлалын үеэр

Энэ удаагийн дадлага сургалтын удирдагч багшаар Кансай их сургуулийн Гото Кэнта профессор ажилласан бөгөөд онолын түвшинд тайлбарлан, зааж өгч байсан нь, харсанаа онолын түвшинд ойлгосон маш ашиг тустай сургалт болсон юм. Тоёота Кюүшү Моторс ХК, Мацүшита Коносүкэ маркетингийн сургууль, Китакюүшү хотын Такамияа байгалийн музей зэрэг 12 байгууллагаар айлчиллаа.

Мөн тус сургалтад Монгол-Японы төвийн үндэсний сургагч багш нарыг чадавхжуулах болон туршлага солилцох зорилготойгоор 4 багш хамрагдсан бөгөөд багш нарын зүгээс компаниудын айлчлалын дараа дүгнэлт хийж, багш суралцагчид хоорондоо туршлага солилцсон үр дүнтэй сургалт болж өндөрлөлөө.



## БИЗНЕСИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

График 1. 2002-2023 оны бизнесийн сургалт, үйл ажиллагааны нийт оролцогчдын тоо





График 2. 2018-2023 оны бизнесийн сургалтын чанарын үзүүлэлт







**Хүснэгт 1: Үндсэн сургалт Удирдлагын анги 22 дахь элсэлт**

№	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Япон маягийн менежмент	2023.03.13-14	Жижиг дунд аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан	<ul style="list-style-type: none"> <li>• Удирдагч ямар байх ёстой вэ?</li> <li>• Захирлын албан тушаалын талаарх тогтсон ойлголтоо өөрчлөх</li> <li>• Корона вирусийн хямралаар Япон хүмүүсийн ойлгосон 3 зүйлс</li> <li>• Менежментийн 3 суурь</li> </ul>	Ямамото Нобүтанэ	39
2	Комплаенс	2023.03.16-17		<ul style="list-style-type: none"> <li>• Компанийн засаглалын ач холбогдол</li> <li>• Компанийн засаглалын зарчим</li> <li>• Компанийн засаглалыг бий болгох</li> <li>• Компанийн засаглал яагаад чухал вэ?</li> <li>• Компанийн хөрөнгийн эх үүсвэрийн талаар</li> <li>• ESG хөрөнгө оруулалтын үед компанийг хэрхэн үнэлж, шалгах вэ?</li> </ul>	Фүжimoto Казүхиса	
3	Стратегийн менежмент	2023.03.20-25		<ul style="list-style-type: none"> <li>• Компанийн дээд түвшний зорилт ба бизнесийн орчин (SWOT), компанийн тогтвортой хөгжлийн хүчин зүйл</li> <li>• BSC-ын байр суурь тус бүрээр SWOT шинжилгээнд тулгуурласан стратегийн менежмент, бизнес домэйн, STP, PLC, PPM</li> <li>• Стратегийн менежменттэй уялдсан бизнесийн стратеги</li> <li>• Стратегийн менежмент ба KPI-д суурилсан компанийн гүйцэтгэлийн удирдлага</li> <li>• Жижиг дунд бизнесийн стратеги менежментийн жишээ</li> </ul>	Кавагүчи Шиничиро	
4	Хүний нөөцийн удирдлага	2023.04.17-22		<ul style="list-style-type: none"> <li>• Хүний нөөцийн талаарх асуудлуудыг ойлгох нь <ul style="list-style-type: none"> <li>-Хүний нөөцийн асуудлууд</li> <li>-Төлөвлөгөөт эдийн засаг ба зах зээлийн эдийн засаг дахь хүний нөөцийн удирдлага</li> </ul> </li> <li>• Менежментийн стратеги ба хүний нөөцийн стратеги <ul style="list-style-type: none"> <li>-Байгууллагын чадавхид шинжилгээ хийх нь</li> </ul> </li> <li>• Гарах хаалганы стратеги <ul style="list-style-type: none"> <li>-Ажлаас гаралт болон тогтвор суурьшил</li> </ul> </li> <li>• Хүний нөөцийн зураглалыг тодорхой болгох, байгууллагын бүтцийн загварчлал</li> <li>• Сонгон шалгаруулалт <ul style="list-style-type: none"> <li>-Сонгон шалгаруулалтын стратеги</li> <li>-Ажлын зар</li> </ul> </li> <li>• Ур чадвар хөгжүүлэлт ба байгууллагын хөгжил</li> <li>• Хүний нөөцийн суурь тогтолцоо</li> </ul>	Добаши Хаяато	
5	Маркетинг	2023.05.15-20		<ul style="list-style-type: none"> <li>• Бизнесийн орчны хувьсал өөрчлөлт</li> <li>• Маркетингийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага</li> <li>• Байгууллага дахь маркетингийн ач холбогдол</li> <li>• STP стратеги -Маркетингийн стратегийн гол цөм болсон сегментчилэл (Segmentation), Зорилтот зах зээл (Targeting), Үнэ цэнийг байршуулах (Positioning)</li> <li>• Маркетингийн хольц (4P)</li> <li>• Үйлчилгээний маркетинг - Маркетингийн хольц дээр нэмэгдэх 3 хүчин зүйлс: Хүн, биет нотолгоо, процесс</li> <li>• Дижитал маркетинг - Хөгжин шинэчлэгдэж буй интернэтийг ашиглан худалдаа явуулах, мобайл ашигласан шинэ бизнес</li> <li>• Зах зээлийн орчны шинжилгээнд үндэслэн маркетингийн стратеги боловсруулах нь</li> </ul>	Үэхигаши Кожи, Ч.Батбаатар	



6	Санхүүгийн удирдлага	2023.06.05-10		<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн тайлан болон санхүүгийн шинжилгээ</li> <li>• Санхүүгийн шинжилгээний аргачлалууд</li> <li>• Санхүүгийн тайлангийн алдааг илрүүлэх нь</li> <li>• Удирдлагын нягтлан бодох бүртгэл</li> <li>• Менежментийг сайжруулах санхүүгийн шинжилгээ</li> <li>• Бизнес төлөвлөгөө болон компанийн ерөнхий зураглал</li> </ul>	Такэгүчи Ёшихиро	
---	----------------------	---------------	--	---	------------------	--

## Хүснэгт 2: Үндсэн сургалт Менежерийн анги 22 дахь элсэлт

№	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Стратегийн менежмент	2023.03.27-31	Жижиг дунд аж ахуйн нэгжийн дунд шатны	<ul style="list-style-type: none"> <li>• Компанийн дээд түвшний зорилт ба бизнесийн орчин (SWOT), компанийн тогтвортой хөгжлийн хүчин зүйл</li> <li>• BSC-ын байр суурь тус бүрээр SWOT шинжилгээнд тулгуурласан стратегийн менежмент, бизнес домэйн, STP, PLC, PPM</li> <li>• KPI-д суурилсан гүйцэтгэлийн удирдлагын стратеги</li> <li>• Стратегийн менежменттэй уялдсан бизнесийн стратеги</li> </ul>	Кавагүчи Шиничиро	32
2	Хүний нөөцийн удирдлага	2023.04.24-28		<ul style="list-style-type: none"> <li>• Ажлаас гаралтын бүтэц</li> <li>• Хүний нөөцийн удирдлагын систем</li> <li>• Хүний нөөцийн хөгжүүлэлт</li> <li>-Шинэ ажилтны чиглүүлэх сургалт</li> <li>-Ур чадвар хөгжүүлэх гол утга учир</li> <li>-Ажлын байран дээрх сургалт</li> <li>-Ажлын байрнаас гадуурх сургалт</li> <li>• Карьер хөгжүүлэлт</li> <li>-Карьер хөгжилд хүргэх албан тушаалын томилгоо</li> <li>• Харилцааны ур чадвар</li> <li>• Зөвшилцлийн үндсэн дээрх шийдвэр гаргалт</li> <li>• Манлайлал</li> <li>• Байгууллагын менежмент</li> <li>-Байгууллагын соёл</li> <li>-Байгууллагын шинэчлэл</li> <li>• Хүний нөөцийнүнэлгээ ба эргэх холбоо</li> </ul>	Добаши Хаяато	
3	Санхүүгийн удирдлага	2023.05.08-12		<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн шийдвэр гаргалт (Санхүүгийн богино хугацааны шийдвэр гаргалт, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, Санхүүгийн урт хугацааны шийдвэр гаргалт)</li> <li>• Санхүүгийн шинжилгээ (Санхүүгийн тайлан, түүний бүтэц, уялдаа холбоо, хөрөнгийн эргэц, ашиглалт/ашигт ажиллагаа/төлбөрийн чадвар/бүтээмжийн шинжилгээ)</li> <li>• Зардал, үйлдвэрлэл, ашгийн хамаарлын шинжилгээ (Хугарлын цэг/зорилтот ашиг/хамгаалалтын зааг/Борлуулалтын хольц ба зардал, үйлдвэрлэл, ашгийн хамаарал/зардлын бүтэц ба хөшүүргийн шинжилгээ)</li> </ul>	Ц.Баянмөнх	



4	Маркетинг	2023.05.22-26		<ul style="list-style-type: none"> <li>• Бизнесийн орчны хувьсал өөрчлөлт</li> <li>• Маркетингийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага</li> <li>• Байгууллагад маркетингийн гүйцэтгэх үүрэг</li> <li>• STP стратеги -Маркетингийн стратегийн гол цөм болсон сегментчилэл (Segmentation), Зорилтот зах зээл (Targeting), Үнэ цэнийг байршуулах (Positioning)</li> <li>• Маркетингийн хольц (4P)</li> <li>• Үйлчилгээний маркетинг - Маркетингийн хольц дээр нэмэгдэх 3 хүчин зүйлс Хүн, биет нотолгоо, процесс</li> <li>• Дижитал маркетинг - Хөгжин шинэчлэгдэж буй интернэтийг ашиглан худалдаа явуулах, мобайл ашигласан шинэ бизнес</li> <li>• Бүтээгдэхүүний конус (Product Cone) -г ашиглан бүтээгдэхүүний төлөвлөгөө боловсруулах нь</li> </ul>	Үэхигаши Кожи, Ч.Батбаатар	
---	-----------	---------------	--	--	----------------------------------	--

### Хүснэгт 3: Үндсэн сургалт Удирдлагын анги 23 дахь элсэлт

№	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Япон маягийн менежмент	2023.09.11-12	Жижиг дунд аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан дунд аж ахуйн нэгжийн удирдах албан	<ul style="list-style-type: none"> <li>• Бизнесийн орчны өөрчлөлт</li> <li>-Тодорхойгүй (VUCA) цаг үе</li> <li>-Тогтвортой хөгжлийн зорилт(SDG)-ын дэлхий дахин дахь оролдлого</li> <li>• Япон менежментийн онцлог</li> <li>-Компанийн удирдлагын үүрэг хариуцлага, Бизнесийн философи</li> <li>-Хэрэглэгчээ дээдлэх зарчим, Байгууллагын соёл ба манлайлал</li> <li>-Бизнесийн стратеги Хүний нөөцийн хөгжил</li> </ul>	Дэгүчи Саторү	35
2	Комплаенс	2023.09.13-14		<ul style="list-style-type: none"> <li>• Яагаад компанийн засаглал чухал вэ?</li> <li>• Комплаенс ба Компанийн засаглалын сүүлийн үеийн чиг хандлага</li> <li>• Компанийн засаглалыг сайжруулах арга зам</li> </ul>	Фүжimoto Казүхиса	
3	Стратегийн менежмент	2023.09.18-23		<ul style="list-style-type: none"> <li>• Компанийн дээд түвшний зорилт ба бизнесийн орчин (SWOT), компанийн тогтвортой хөгжлийн хүчин зүйл</li> <li>• BSC-ын байр суурь тус бүрээр SWOT шинжилгээнд тулгуурласан стратегийн менежмент, бизнес домэйн, STP, PLC, PPM</li> <li>• Стратегийн менежменттэй уялдсан бизнесийн стратеги</li> <li>• Стратегийн менежмент ба KPI-д суурилсан компанийн гүйцэтгэлийн удирдлага</li> <li>• Жижиг дунд бизнесийн стратеги менежментийн жишээ</li> </ul>	Кавагүчи Шиничиро	
4	Маркетинг	2023.10.09-14		<ul style="list-style-type: none"> <li>• Маркетинг гэж юу вэ?, Маркетинг ба брэндинг</li> <li>• Маркетингийн үйл ажиллагааны ерөнхий дүр зураг</li> <li>• Зах зээлийн судалгаа, STP шинжилгээ</li> <li>• Үйлчлүүлэгч(Persona)-ийн маркетинг, 4P/4C</li> <li>• Дижитал маркетинг гэж юу вэ?</li> <li>• Гурвалсан мэдээллийн хэрэгсэл</li> <li>• Хэрэглэгчийн аяллын зураглал</li> <li>• Олны танил хүн(influencer) ашигласан маркетинг</li> <li>• Инбаунд контент маркетинг</li> <li>• KGI/KPI дизайн/өгөгдлийн шинжилгээ</li> <li>• Мэдээллийн систем/өгөгдлийн бааз</li> </ul>	Огисо Хисаши	



5	Хүний нөөцийн удирдлага	2023.11.06-11		<ul style="list-style-type: none"> <li>• Хүний нөөцийн тулгамдаж буй асуудлууд, гарах хаалганы бодлого</li> <li>• Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, зах зээлийн эдийн засаг</li> <li>• Стратегийн менежмент ба хүний нөөцийн стратеги</li> <li>• Байгууллагын бүтэц</li> <li>• Ажилтны дүр зургийг тодорхой болгох, сонгон шалгаруулалт</li> <li>• Дасан зохицох хөтөлбөр</li> <li>• Ур чадварыг хөгжүүлэх</li> <li>• Байгууллагын соёл</li> <li>• Хүний нөөцийн суурь тогтолцоо, эргэх холбоо</li> </ul>	Ямазаки Кёоко	
6	Санхүүгийн удирдлага	2023.11.20-25		<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн тайлан болон санхүүгийн шинжилгээ</li> <li>• Санхүүгийн шинжилгээний аргачлалууд</li> <li>• Санхүүгийн тайлангийн алдааг илрүүлэх нь</li> <li>• Удирдлагын нягтлан бодох бүртгэл</li> <li>• Менежментийг сайжруулах санхүүгийн шинжилгээ</li> <li>• Бизнес төлөвлөгөө болон компанийн ерөнхий зураглал</li> </ul>	Такэгүчи Ёшихиро	

#### Хүснэгт 4: Үндсэн сургалт Менежерийн анги 23 дахь элсэлт

№	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Стратегийн менежмент	2023.09.25-29	Жижиг дунд аж ахуйн нэгжийн дунд шатны албан тушаалтан	<ul style="list-style-type: none"> <li>• Компанийн дээд түвшний зорилт ба бизнесийн орчин (SWOT), компанийн тогтвортой хөгжлийн хүчин зүйл</li> <li>• BSC-ын байр суурь тус бүрээр SWOT шинжилгээнд тулгуурласан стратегийн менежмент, бизнес домэйн, STP, PLC, PPM</li> <li>• KPI-д суурилсан гүйцэтгэлийн удирдлагын стратеги</li> <li>• Стратегийн менежменттэй уялдан бизнесийн стратеги</li> </ul>	Н.Батдэлгэр	32
2	Маркетинг	2023.10.16-20		<ul style="list-style-type: none"> <li>• Маркетинг гэж юу вэ?, Маркетинг ба брэндинг</li> <li>• Маркетингийн үйл ажиллагааны ерөнхий дүр зураг</li> <li>• Зах зээлийн судалгаа, STP шинжилгээ</li> <li>• Үйлчлүүлэгч(Persona)-ийн маркетинг, 4P/4C</li> <li>• Дижитал маркетинг гэж юу вэ?</li> <li>• Гурвалсан мэдээллийн хэрэгсэл</li> <li>• Хэрэглэгчийн аялын зураглал</li> <li>• Олны танил хүн(influencer) ашигласан маркетинг</li> <li>• Инбаунд контент маркетинг</li> <li>• KGI/KPI дизайн/өгөгдлийн шинжилгээ</li> <li>• Мэдээллийн систем/өгөгдлийн бааз</li> </ul>	Огисо Хисаши	
3	Хүний нөөцийн удирдлага	2023.11.13-17		<ul style="list-style-type: none"> <li>• Өөрийн компанийн хүний нөөцийн менежментийн тулгамдсан асуудлаа тодорхойлох</li> <li>• Хүний нөөцийн менежментийн өөрчлөлт</li> <li>• Хүний нөөцийн менежмент гэж юу вэ?</li> <li>• Байгууллагын соёл ба хүний нөөцийн менежментийн уялдаа холбоо</li> <li>• Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт</li> <li>• Хүний нөөцийн сонгон шалгаруулалт</li> <li>• Хөдөлмөрийн харилцааны үндсэн асуудлууд /хөдөлмөрийн тухай хуулийн гол анхаарах зүйлүүд/ ХАБЭА</li> <li>• Гүйцэтгэлийн менежмент</li> <li>• Цалин хөлс, урамшуулал, нийгмийн халамж</li> <li>• Сургалт хөгжил</li> </ul>	Д.Дашмаа	



			<ul style="list-style-type: none"> <li>• Ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх</li> <li>• Мэдээлэл солилцоог сайжруулах</li> <li>• Ажлаас гаралтын менежмент</li> <li>• Өөрийгөө таних</li> <li>• Манлайлал</li> <li>• Сайжруулах ур чадвар /харилцаа, хандлага, сонсох, бусдын оронд өөрийгөө тавих, EQ, коучинг /</li> </ul>		
4	Санхүүгийн удирдлага	2023.11.27-12.01	<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн шийдвэр гаргалт (Санхүүгийн богино хугацааны шийдвэр гаргалт, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, Санхүүгийн урт хугацааны шийдвэр гаргалт)</li> <li>• Санхүүгийн шинжилгээ (Санхүүгийн тайлан, түүний бүтэц, уялдаа холбоо, хөрөнгийн эргэц, ашиглалт/ашигт ажиллагаа/төлбөрийн чадвар/бүтээмжийн шинжилгээ)</li> <li>• Зардал, үйлдвэрлэл, ашгийн хамаарлын шинжилгээ (Хугарлын цэг/зорилтот ашиг/хамгаалалтын зааг/Борлуулалтын хольц ба зардал, үйлдвэрлэл, ашгийн хамаарал/зардлын бүтэц ба хөшүүргийн шинжилгээ)</li> </ul>	Ц.Баянмөнх	

### Хүснэгт 5: Суурь мэдлэгийн сургалт

№	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Хүний нөөцийн менежмент	2023.02.03	Компанийн шинэ ажилтан, гарааны бизнес эрхлэгчид	<ul style="list-style-type: none"> <li>• Хүний нөөцийн менежментийн талаар суурь ойлголт</li> <li>• Хүний нөөцийн менежментийн үндсэн функцууд               <ul style="list-style-type: none"> <li>- төлөвлөлт,</li> <li>- бүрдүүлэлт,</li> <li>- сонгон шалгаруулалт</li> <li>- үнэлгээ</li> <li>- сургалт хөгжил</li> </ul> </li> <li>• Ажлын байрны манлайлал, идэвхжүүлэлт</li> </ul>	Д.Дашмаа	36
2	Дэлгүүрийн удирдлага	2023.03.03		<ul style="list-style-type: none"> <li>• Дэлгүүрийн ангилал, төрөл</li> <li>• Дэлгүүрийн байгууламж               <ul style="list-style-type: none"> <li>- Гадаад орчны төлөвлөлт</li> <li>- Худалдааны талбайн төлөвлөлт</li> </ul> </li> <li>• Барааны удирдлага               <ul style="list-style-type: none"> <li>- Мерчиндайзинг</li> <li>- Бараа өрөлт</li> <li>- Барааны хаяглалт</li> </ul> </li> </ul>	Ж.Гансүх	41
3	5S хөдөлгөөнийг хэрэгжүүлэх нь	2023.04.15		<ul style="list-style-type: none"> <li>• 5S-ийг хэрэгжүүлэх нь /Сэри-Сэитон-Сэисоо-Сэйкэцү-Шицүкэ/ /Үргүй зардлыг арилгах, Чанарын удирдлага, 5S/</li> <li>• PDCA циклийг хэрэгжүүлэх нь/Төлөвлөх-Хэрэгжүүлэх-Шалгах-Сайжруулах/</li> <li>• 5 удаа яагаад шинжилгээ</li> </ul>	Д.Долгормаа	39





			<ul style="list-style-type: none"> <li>• Хоорэнсоо /Мэдээлэх-Холбогдох-Зөвлөлдөх/</li> </ul>		
4	Санхүүгийн удирдлага	2023.05.06	<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн удирдлага, түүний ач холбогдол</li> <li>• Санхүүгийн менежер хүний гаргах гол шийдвэрүүд</li> <li>• Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт</li> <li>• Хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шийдвэр гаргах үе шатууд</li> <li>• Төслийн мөнгөн гүйлгээг тооцох нь</li> <li>• Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн хэрэглээ</li> <li>• Төслийн үнэлгээний аргууд</li> <li>• Капиталын өртгийн тооцоолол</li> <li>• Хөрөнгө оруулалтын төслүүдээс ашигтайг сонгох нь</li> <li>• Тоёотагийн үйлдвэрлэлийн удирдлагын арга барил</li> <li>• Тоёотагийн 7 муда</li> <li>• Стандарт ажлын зааварчилгаа</li> <li>• Кайзэн</li> <li>• Загасны ясан диаграм</li> <li>• Чанарын долоон арга</li> <li>• VSM ба үнэ цэнийн урсгалын зураглал</li> <li>• TPM ба засварын нэгдсэн удирдлага</li> </ul>	Б.Данаасүрэн	27
5	Үйлдвэрлэлийн удирдлага	2023.05.13	<ul style="list-style-type: none"> <li>• Төслийн тухай үндсэн ойлголт</li> <li>• Төслийн үе шатууд</li> <li>• Төслийн удирдлага арга, техник</li> <li>• Төслийн эрсдэлийн удирдлага</li> </ul>	Н.Батчулуун	38
6	Төслийн менежмент	2023.06.17	<ul style="list-style-type: none"> <li>• Өнөөгийн бизнесийн орчин (Нөлөөлөл, технологийн дэвшил)</li> <li>• Менежментийн үндэс <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллага, менежмент, менежер</li> <li>- Төлөвлөлт, зохион байгуулалт</li> <li>- Манлайлал, хяналт</li> </ul> </li> <li>• Стратегийн менежмент <ul style="list-style-type: none"> <li>- Нөхцөл байдлын шинжилгээ</li> <li>- Стратеги боловсруулах</li> <li>- Стратеги хэрэгжүүлэх</li> <li>- Стратегийн хэрэгжилтийг үнэлэх</li> </ul> </li> </ul>	Б.Мөнхцог	27
7	Стратегийн менежмент	2023.09.16	<ul style="list-style-type: none"> <li>• Менежментийн зорилгын тухай үндсэн ойлголт</li> <li>• Япон маягийн менежментийн онцлог</li> <li>• Үйлдвэрлэлийн пирамид ба 5S-ийн тухай суурь ойлголт</li> <li>• Монгол маягийн менежментийн онцлог</li> <li>• Ашгийг бүтээгч хүнээ сайжруулах нь</li> <li>• Япон маягийн менежментийг хэрэгжүүлэхэд гарсан алдаа, онооны туршлагаас суралцах нь</li> </ul>	Д.Энх-Отгон	30
8	Япон маягийн менежментийг монгол удирдахуйн ухаантай хослуулах нь	2023.10.21		Ж.Хишигжаргал	37



9	Санхүүгийн удирдлага	2023.11.18		<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн удирдлага, түүний ач холбогдол</li> <li>• Санхүүгийн менежер хүний гаргах гол шийдвэрүүд</li> <li>• Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт</li> <li>• Хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шийдвэр гаргах үе шагууд</li> <li>• Төслийн мөнгөн гүйлгээг тооцох нь</li> <li>• Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн хэрэглээ</li> <li>• Төслийн үнэлгээний аргууд</li> <li>• Капиталын өртгийн тооцоолол</li> <li>• Хөрөнгө оруулалтын төслүүдээс ашигтайг сонгох нь</li> </ul>	Б.Данаасүрэн	23
						298

**Хүснэгт 6: Ахисан түвшний сургалт**

№	Хичээлийн нэр	Хугацаа	Оролцогч	Агуулга	Багшийн нэр	Хүний тоо
1	Менежментийн симуляци	2023.01.16-18	Аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан, менежер, бизнес эрхлэгчид, ЖДҮ захирал, дунд шатны удирдах албан тушаалтнууд	<ul style="list-style-type: none"> <li>• Пивоны тоглоом</li> <li>• Нийлүүлэлтийн сүлжээ</li> <li>• Бараа материалын нөөцийн хэмжээг оновчлох</li> <li>• Нийлүүлэлтийн сүлжээний холбогдох асуудлуудыг ойлгох</li> <li>• BG21 Симуляцийн тоглоом</li> <li>• Бараа материалын захиалгын оновчлол</li> <li>• Шийдвэр гаргалт (Програмчлагдсан, програмчлагдаагүй)</li> <li>• Санхүүгийн тайлангуудын уялдаа холбоо (Анхлан суралцагчдад зориулсан)</li> </ul>	Н.Батдэлгэр	22
2	Дэлгүүрийн удирдлага	2023.01.23-27	Дэлгүүр, үйлчилгээний газрын үйл ажиллагаа эрхлэгч, удирдах албан тушаалтан, менежер зохион байгуулагч	<ul style="list-style-type: none"> <li>• Бараа өрөлт</li> <li>• Бараа өрөлтийг сайжруулах зөвлөгөө <ul style="list-style-type: none"> <li>• Хэрэглэгчийн удирдлага</li> </ul> </li> <li>• Customer Journey Map</li> <li>• Хүний нөөцийн хөгжил <ul style="list-style-type: none"> <li>• Шинэ ажилтныг чиглүүлэх сургалт</li> </ul> </li> <li>• Борлуулалтын ажилтныг чиглүүлэх сургалт</li> <li>• Дэлгүүрийн даргыг чиглүүлэх сургалт</li> <li>• Борлуулалтыг идэвхжүүлэх</li> <li>• POP, зар сурталчилгаа</li> </ul>	Үэхигаши Кожиган	40
3	Хүний нөөцийн удирдлага	2023.04.03-07	Компанийн удирдах түвшний албан тушаалтан болон хүний нөөцийн менежер	<ul style="list-style-type: none"> <li>• Стратегийн менежмент ба хүний нөөцийн стратегийн уялдаа</li> <li>• Хүний нөөцийн суурь тогтолцоог бүрдүүлэх нь</li> <li>• Хүний нөөцийн үнэлгээ</li> <li>• Хүний нөөцийн хөгжил</li> <li>• Манлайлал ба байгууллагын хөгжил</li> </ul>	Ямазаки Кёоко	41



4	Завхан аймгийн Улиастай хот дахь сургалт	Стратегийн менежмент 2023.05.08-11	Улиастай хотын ЖДҮ-ийн удирдах албан тушаалтнууд	<ul style="list-style-type: none"> <li>Компанийн дээд түвшний зорилт, бизнесийн орчин, стратегийн менежмент</li> <li>Бизнес домэйн, бизнес модел, STP, PLC, PPM</li> <li>Өсөлт болон диверсификацийн стратеги Өрсөлдөөний давуу талын стратеги</li> <li>Өрсөлдөөнд эзлэх байр сууриарх стратеги</li> </ul>	Н.Батдэлгэр	15
		Хүний нөөцийн удирдлага 2023.05.22-25		<ul style="list-style-type: none"> <li>Хүний нөөцийн удирдлагын систем ба нөхцөл байдлыг тодорхойлох</li> <li>Мотивацижуулалт</li> <li>Ажилтны сургалт хөгжил</li> <li>Дунд шатны удирдах ажилтны хүний нөөцийн үүрэг</li> </ul>	Д.Дашмаа	15
5	Санхүүгийн удирдлага	2023.06.12-16	Компанийн удирдах албан тушаалтан, нягтлан бодогч, санхүүч	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн тайлангууд</li> <li>CFM (Мөнгөн урсгалын менежмент)</li> <li>Өртөг тооцох</li> <li>Санхүүгийн шинжилгээ</li> <li>Хугарлын цэгийн шинжилгээ: <ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн тайлан ба санхүүгийн шинжилгээ</li> </ul> </li> <li>Санхүүгийн НББ ба Удирдлагын НББ</li> <li>Үйл ажиллагаагаа сайжруулахад санхүүгийн шинжилгээг хэрэглэх нь: <ul style="list-style-type: none"> <li>Бизнес төлөвлөгөө ба компанийн ерөнхий зураглал</li> <li>Бизнес төлөвлөгөө боловсруулах аргачлал</li> </ul> </li> </ul>	Такэгүчи Ёшихиро	26
6	KPI ба Чадамжийн удирдлага	2023.06.19-23	KPI-ийг хэрэгжүүлж буй байгууллагын удирдах албан тушаалтан, хүний нөөцийн менежер, бизнесийн зөвлөхүүд	<ul style="list-style-type: none"> <li>Хүний нөөцийг болон байгууллагыг үр дүнтэй удирдаж, ажиллуулах KPI-ийн удирдлага</li> <li>Японы компаниудын KPI-ийн удирдлагын жишээ</li> <li>Менежментийг харагдахуйц болгох арга хэрэгсэл болох KPI-ийн удирдлага</li> <li>KPI-ийг хэрэгжүүлж буй Монгол компанийн жишээ</li> <li>KPI болон чадамжийн гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдсан цалин, урамшууллын дизайн</li> </ul>	Кавагүчи Шиничиро	36
7	Эксэлээр бизнесийн шинжилгээ хийх нь	2023.06.26-28	Байгууллагын удирдах албан тушаалтан, менежер, нягтлан бодогч	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн загварчлалын үндсэн техник</li> <li>Ашгийг таамаглах загвар боловсруулах</li> <li>Санхүүгийн тайланг ашигласан санхүүгийн загвар</li> <li>Санхүүгийн загварыг боловсруулах</li> <li>Хугарлын цэгийн шинжилгээ</li> <li>Компанийн үнэ цэнийн үнэлгээний аргазүй</li> <li>Компанийн үнэ цэнийн үнэлгээний загвар боловсруулах</li> </ul>	Н.Батдэлгэр	34



8	Global Value Chain	2023.08.21-25	Үйлдвэрийн салбар, цаашид бараа бүтээгдэхүүнээ экспортлохоор зорьж буй бизнес эрхлэгчид, олон улсын эдийн засаг сонирхож буй хүмүүс	<ul style="list-style-type: none"> <li>• Япон болон Зүүн Азийн үйлдвэржилтийн туршлагаас суралцах нь</li> <li>• Дэлхийн эдийн засгийн ба дэлхийн үнэ цэнийн гинжин хэлхээ</li> <li>• Дэлхийн эдийн засаг доторх Монгол улс</li> <li>• Аж үйлдвэрийн онцлогийг ойлгох нь</li> <li>• Бизнес ба тогтвортой байдал</li> </ul>	Гото Кэнта	23
9	Бизнес төлөвлөгөө	2023.09.13-15	Бизнес эрхлэгчид болон шинээр бизнес эрхлэхээр зэхэж буй хүмүүс	<ul style="list-style-type: none"> <li>• Бизнес төлөвлөгөөний ач холбогдол ба зорилго</li> <li>• Яагаад бизнес төлөвлөгөө хэрэгтэй вэ?</li> <li>• Бизнес төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг</li> <li>• Бизнесийн тойм агуулга ба алсын хараа</li> <li>• Зах зээл ба өрсөлдөөний шинжилгээ</li> <li>• Хэрэглэгчийн хэрэгцээг тодорхойлох</li> <li>• Ашгийн бүтцийг ойлгох</li> <li>• Санхүүгийн төлөвлөгөө ба төсвийн төсөл</li> </ul>	Дэгүчи Сагору	31
10	Үзэсгэлэн яармагт хэрхэн амжилттай оролцох вэ?	2023.10.09-13	Гадны зах зээлд бараа бүтээгдэхүүнээ экспортлохоор төлөвлөж буй болон олон улсын үзэсгэлэн яармагт оролцохоор төлөвлөж буй компанийн удирдах албан тушаалтан, менежер, үйлдвэрлэгчид, худалдаа аж үйлдвэрийн танхимуудын гадаад зах зээл хариуцсан мэргэжилтнүүд	<ul style="list-style-type: none"> <li>• FoodExpo</li> <li>• Үзэсгэлэн яармагт оролцохоос эхлээд бүтээгдэхүүн борлуулж эхлэх хүртэлх үйл явц болон үр дүнтэй ажиллах арга</li> <li>• Зорилгот зах зээлийн судалгаа</li> <li>• Зах зээлийн бүтэц, борлуулалтын сувгийн шинжилгээ</li> <li>• Өөрийн бүтээгдэхүүний байршуулалт, бизнес төлөвлөгөө, боломжит түншээ тодорхойлох</li> <li>• Бараа бүтээгдэхүүнээ амжилттай танилцуулах арга</li> <li>• 5 шатлалт маркетингийн арга</li> <li>• Үзэсгэлэн яармагт оролцох, оролцсоны дараа бараа бүтээгдэхүүнээ борлуулах хүртэл шаардлагатай check point</li> </ul>	Хиракава Масаказү	19
11	Үйлдвэрлэлийн удирдлага	2023.12.04-08	Үйлдвэрлэлийн салбарт бизнес эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагын удирдах албан тушаалтан, менежер	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлдвэрлэлийн удирдлагын ерөнхий ойлголт</li> <li>• Чанарын удирдлага</li> <li>• Дамжлагын сайжруулалт</li> <li>• QC-н 7 арга хэрэгсэл /Чанарын удирдлагын/</li> <li>• Аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент</li> <li>• 5S үйл ажиллагаа хэрэгжилт</li> <li>• Менежментийн ур чадварыг сайжруулах</li> <li>• Хүний нөөцийн сургалт, хөгжил</li> </ul>	Такаяасү Мицүхарү	35
						337



### Хүснэгт 7: Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөр

	№	Компанийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Хөтөлбөрийн агуулга	Хугацаа
2023-2024 он	1	Premium Palace ХХК	Зочид буудал, ресторан	<ul style="list-style-type: none"> <li>Ажилтнуудын сэтгэл ханамжийг тогтмол үнэлэх замаар сэтгэл ханамжийг тогтоох, сайжруулах</li> <li>Нийт компанийн түвшний стратеги тодорхойлох</li> </ul>	2023.04-2024.06
	2	Caffe bene Mongolia ХХК	Кафе, хүнс үйлдвэрлэл	<ul style="list-style-type: none"> <li>Хүний нөөцийн тогтолцоо сайжруулах, ажилтнуудын сэтгэл ханамжийг тогтмол үнэлэх замаар сэтгэл ханамжийг тогтоох, сайжруулах</li> <li>Үйлдвэрлэлийн удирдлагын сайжруулалт</li> </ul>	2023.11 - 2024.06
	3	Top donj ХХК	Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа	<ul style="list-style-type: none"> <li>Стратегийн зорилгоо тодорхойлох, бизнесийн орчны шинжилгээ</li> <li>SWOT-д суурилсан нийт компанийн түвшний стратеги тодорхойлох, түүнтэй уялдсан CSF, SGK1, KPI тодорхойлох, хэлтэс, баг, хувь хүний KPI-д буулгах</li> </ul>	2023.09-2024.06

### Хүснэгт 8: Ажлын байран дээрх сургалт

№	Компанийн нэр	Сургалтын нэр	Хугацаа	Багшийн нэр	Оролцогчдын тоо
1	СБД-ийн 2-р цэцэрлэг	5S хөдөлгөөн	2023.01.28	Д.Долгормаа	16
2	Байгалийн чулуун хийц ХХК	5S хөдөлгөөн-зөвлөгөө	2023.1.19	Д.Долгормаа	8
3	Байгалийн чулуун хийц ХХК	Хүний нөөцийн менежмент	2023.2.9,3.16,4.14,5.13,8.7,8.25,11.28,12.19	Д.Дашмаа	154
4	Шинжлэх ухааны академи	Хүний нөөцийн менежмент	2023.12.16,17	Д.Дашмаа	16
5	Байгалийн чулуун хийц ХХК	Стратегийн менежмент	2032.3.23,24	Кавагүчи Шиничиро	12
6	И Эн Си групп ХХК	KPI	2023.3.30	Кавагүчи Шиничиро	4
7	Apollo building service	5S хөдөлгөөн	2023.4.25-27	Д.Долгормаа	58
8	Жүр Үр ХХК	Хүний нөөцийг хөгжүүлэх байгууллагын соёл ба төслийн менежмент	2023.4.26	Ониши Ёшифүми	50
9	И Эн Си групп ХХК	Хүний нөөцийн менежмент	2023.4.27	Добаши Хаяато	5
10	И Эн Си групп ХХК	5S хөдөлгөөн	2023.5.2	Д.Долгормаа	21
11	Байгалийн чулуун хийц ХХК	Тоёота удирдлагын аргачлал	2023.5.3	Н.Батчулуун	24
12	Скай Трэйдинг ХХК	Дэлгүүрийн удирдлага	2023.5.8	Ж.Гансүх	30
13	Түмэн Шувуут ХК	5S хөдөлгөөн	2023.5.13	Д.Долгормаа	138





14	Абтэма ХХК	5S хөдөлгөөн	2023.5.30	Д.Долгормаа	21
15	Абиго ХХК	Хүний нөөцийн менежмент	2023.6.8	Д.Дашмаа	13
16	Премиум Палас ХХК	KPI	2023.6.23	Кавагүчи Шиничиро	18
17	МЯК ХХК	Хүний нөөцийн менежмент	2023.6.30,10.27,12.12	Д.Дашмаа	23
18	Бяцхан Монгол цэцэрлэг	5S хөдөлгөөн	2023.8.28	Д.Долгормаа	40
19	MSL	KPI	2023.09.19,20	Кавагүчи Шиничиро	18
20	Хаанзаа Сервис ХХК	Манлайлал, Хүний нөөцийн менежмент	2023.09.25, 11.03,11.30,12.15	Д.Дашмаа	30
21	Титан Грид ХХК	5S хөдөлгөөн	2023.09.25	Д.Долгормаа	22
22	МЯК ХХК	Стратегийн менежмент	2023.10.18,11.09,11.23,12.21	Н.Батдэлгэр	19
23	МСМ ГРУПП ХХК	5S хөдөлгөөн	2023.11.28,12.05, 12.07,12.12	Д.Долгормаа	66
24	Жагар Интернэйшнл ХХК	Дэлгүүрийн удирдлага	2023.12.15	Ж.Гансүх	18
25	Платинум Ланд ХХК	Конплаенс	2023.12.14	С.Санасэр	7
					831

### Хүснэгт 9: Тусгай сургалт, бизнесийн нээлттэй семинар

№	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Багш	Хамрагдсан хүний тоо
1	Карьер дизайн	2023.4.8	Ямазаки Кёоко	76
2	Хүний нөөцийг хөгжүүлэх байгууллагын соёл болон төслийн гүйцэтгэх үүрэг	2023.4.22	Ониши Ёшифүми	51
3	Япон маягийн найрсаг үйлчилгээ	2023.5.20	Үэхигаши Кожи	123
4	Карьер дизайн	2023.11.11	Ямазаки Кёоко Д.Дашмаа	70
<b>Нийт</b>				320

### Хүснэгт 10: Япон дахь дадлага сургалтын суралцагчид

#### 1. Бизнесийн үндсэн сургалт төгсөгчид

№	Нэр	Албан тушаал	Байгууллагын нэр
1	Т.Ариунжаргал	Гүйцэтгэх захирал	Арга хийц од ХХК
2	П.Цолмон	Үйл ажиллагаа эрхэлсэн захирал	Битумина Монголиа ХХК
3	М.Гантөмөр	Гүйцэтгэх Захирал	АРД ТАВИЛГА ХХК
4	Д.Сумьяацэцэг	Захирал	ВИНТЕР ГАРДЕН ХХК
5	Г.Гантуяа	Үүсгэн байгуулагч, Санхүү албаны дарга	"Жи энд Жи Интернэйшнл" ХХК
6	Д.Хишигдэлгэр	Гүйцэтгэх захирал	РТТ ХХК
7	Ч.Оюунчимэг	Захирал	Дөмөнэрдэнэ ХХК
8	А.Эрдэнэтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Говьхангай мебель ХХК
9	Л.Эрдэнэчимэг	Захирал	EZ Leather craft LLC
10	Б.Заяа	Санхүүгийн албаны дарга	Интерсайнс ХХК
11	Ц.Батбаатар	Дэд захирал	7010 ХХК
12	Т.Батбаяр	Захирал	Хурговь ХХК
13	Б.Оюунчимэг	Гүйцэтгэх захирал	Монсүү ХХК
14	Б.Ганзам	Гүйцэтгэх захирал	Вигафит Дистрибушн ХХК

#### 2. 2021 оны Загвар аж ахуйн нэгж



№	Нэр	Албан тушаал	Байгууллагын нэр
15	Х.Болормаа	Гүйцэтгэх захирал	Урбан брэнд ХХК
16	Б.Баясгалан	Гүйцэтгэх захирал	Диасис Монголиа ХХК

### 3. Үндэсний сургагч багш

№	Нэр	Албан тушаал	Байгууллагын нэр
17	Д.Дашмаа	Үндэсний сургагч багш	Монгол-Японы төв
18	Н.Батдэлгэр	Үндэсний сургагч багш	Монгол-Японы төв
19	Ж.Гансүх	Үндэсний сургагч багш	Монгол-Японы төв
20	Б.Мөнхцог	Үндэсний сургагч багш	Монгол-Японы төв

### 4. Монгол-Японы төв

№	Нэр	Албан тушаал	Байгууллагын нэр
21	Э.Сүх-Эрдэнэ	Ерөнхий удирдлагын тасгийн ахлах мэргэжилтэн	Монгол-Японы төв
22	Б.Эрдэнэсайхан	Бизнесийн сургалтын тасгийн мэргэжилтэн	Монгол-Японы төв

## II. МОНГОЛ-ЯПОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН БИЗНЕСИЙН ХАМТЫН АЖИЛГААГ ДЭМЖИХ АЖИЛ

### 1. Бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа илүү өргөжин илүү олон төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаа.


Бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа нь 7 дах жилээ үдэх гэж байна. Энэ жил үйл ажиллагаа хэвийн байдалдаа орон үйлчлүүлэгчдийн тоо тогтворжсон хандлагатай байна. Бизнесийн хамтын ажиллагааны чиглэлээр төвөөр үйлчлүүлэгчдийн тоо монгол, япон гээд өмнөх ковидын үеийн онуудтай харьцуулахад харьцангуй өсөж, 245 гаруй хүн үйлчлүүлсэн байна. Монгол Японы хоорондын бизнесийн хамтын ажиллагаа эрчимжиж илүү олон ажил гүйцэтгэн, нийт 16 төрлийн үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэлээ. Мөн түүнчлэн гадаадаас ажиллах хүч авах ажлын талаарх лавлагааны тоо ч өмнөх онтой харьцуулахад өссөн байна. Хоёр улсын хооронд бизнес болон хүн хоорондын харилцаа эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд цаашид ч илүү их өргөжин бусад Япон төвтэй хамтарсан ажил тэлэх боломжтой харагдаж байна. Энэ жилийн онцлох ажлуудын нэг анх удаа матчинг ажил бодитоор хэрэгжүүлээ. Үүнд Монгол-Японы төвийн бизнесийн үндсэн сургалт төгсөгч “Абико” компанийн Казакийн зах зээл дээр гарахыг хүссэн хүсэлтийн дагуу, Казак-Япон төвтэй холбогдон, Казак-Япон төв, “Абико” компанитай гэрээ байгуулан цаашид Казак-Япон төв “Абико” ХХК-г Казакийн холбогдох компаниудад танилцуулахаар гэрээ байгуулав. Ингэснээр цаашид бусад япон төвүүдтэйгээ хамтран ажиллах ажил нэмэгдэх хандлагатай байна.

Бизнесийн хамтын ажиллагааны хүрээнд мэдээллийн түгээлт, таниулах хэмжих үзүүлэлтийг уулзсан үйлчлүүлэгчдийн тоогоор<sup>1</sup> илэрхийлдэг.

<sup>1</sup> Энд дурдагдаж буй уулзалт гэдэг нь танхимаар эсвэл цахимаар гэсэн 2 хэлбэрээр, зөвлөгөө болон лавлагаанд хариулан, гэрээт ажлын төлөвлөлт, зохион байгуулалттай холбоотой хийсэн хурлын тоо



График 3. 2017-2023 онд хийсэн уулзалтын тоон харьцуулалт



Дээрх график дээр харагдаж байгаагаар 2023 онд үйлчлүүлэгчдийн тоо өмнөх онтой дүйцэж үйл ажиллагаа тогтвортой явагдаж байна. 2023 оны хувьд Жайка-гийн өвсний үндэс төсөл, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны төсөл болон бусад захиалгат төрийн төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаа. Доорх хүснэгтэнд нийт гүйцэтгэсэн үйл ажиллагааг оруулав.

**Хүснэгт 11. 2023 онд зохион байгуулсан үйл ажиллагаа**

№	Үйл ажиллагааны нэр	
1	<b>Жайка-тай холбоотой төслүүд (төлбөртэй)</b>	Хоккайдо муж “Токачи • Юнитранд” компани Өвсний үндэс төсөл / Улаанбаатар хот
		Замын орчин, хот байгуулалтын төв Хиймэл оюун ухаан, IoT технологиор хангах автобусны үйл ажиллагааг сайжруулах төсөл
		Watanabe Pipe Co., Ltd. (хөдөө аж ахуй)
		Төслийн техник, эдийн засгийн үндэслэл суурь судалгаа
		Ибараки муж гадаад ажилчдыг дэмжих төв (цахим семинар)
		Орикон консалтинг компани (Нүүрс төрөгчийн ялгарал багатай нийгэмийг бий болгох хот хоорондын хамтын ажиллагааны төсөл)
		ICT Бизнес тур
2	<b>Жайка-тай холбоотой төслүүд (төлбөргүй)</b>	Аэронэкст компани (Шинэ үеийн ухаалаг тээвэрлэлт Монголд бүтээгдэхүүн танилцуулах симпозиум)
		MONJA 2023
		Монгол-Япон Бизнес Форум
3	<b>Хувийн хэвшил хамтын ажиллагаа төсөл (төлбөртэй)</b>	Эрүүл мэндийн салбарт экспортыг хөгжүүлэх зорилгоор гадаад дахь бизнес эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн matching семинар
		Номан ХК (Франчайзын гэрээ орчуулга бэлтгэл, зөвлөх үйлчилгээ)
		Монгол дахь Японы худалдаа аж үйлдвэрийн холбоо (НР хийх үйлчилгээ)



		Шизоака муж “Озава тэнт” компани (Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хадгалах майхан хэлбэрийн зоорийн туршилт судалгаа) Тоу граут
4	<b>Бусад төрийн төсөлүүд (төлбөртэй)</b>	Байгал орчны яам, Нүүрс төрөгчийн ялгарал багатай нийгэмийг бий болгох хот хоорондын хамтын ажиллагааны төсөл Улаанбаатар хот, Саппоро хот Япон улсын элчин сайдын яам, Ока&Вауаг хуулийн ферм (Хуулийн семинар)
5	<b>Matching</b>	Монгол • Япон төвийн төгсөгч компани “Абико”ХХК-г Казак • Япон төвтэй холбох ажлыг зохион байгуулав.

Төлбөртэйгөөр үйлчилгээ үзүүлдэг Япон төвийн Бизнесийн хамтын ажиллагааны орлого өнгөрсөн жилүүдээс хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан. Эдгээр үр дүн нь Бизнесийн хамтын ажиллагааг тогтвортой хийсэн таниулан сурталчлах үйл ажиллагаа, үйлчилгээний чанарын сайжруулалт зэрэг олон шалтгааныг нийлүүлсэн үр дүн юм. Бизнесийн хамтын ажиллагааг дэмжих ажил цаашид Монгол-Японы бизнесийн хамтын ажиллагаа үүсгэх орчинг тогтмол бий болгох, төрийн төслүүдээс гадна хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйл ажиллагаагаа тогтворжуулах. Мөн бусад Япон төвүүдтэй хамтарсан үйл ажиллагаа явуулах гэсэн төлөвлөгөөтэй байна.

## 2. “Монгол-японы бизнес форум 2023”-ыг амжилттай зохион байгууллаа.

2023 оны 8 сарын 18-нд Монгол - Японы Бизнес Форумыг ЖАЙКА, Монгол-Японы Хүний төв, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ), JUGAMO хамтран МҮХАҮТ Их танхимд зохион байгууллаа.

Энэ удаагийн бизнес форумд Монгол, Японы экспорт, худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих асуудал, Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ), Мэдээлэл, харилцаа холбоо, цахим технологи, нээлттэй инновац зэрэг сэдвүүдээр Монгол, Японы хувийн хэвшлийн төлөөллүүд танилцуулга хийж, хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд форумд Японы талаас 100 орчим, Монголын 300 гаруй төлөөлөгч оролцлоо.

Форум зохион байгуулагчдын илтгэлийн үеэр Монгол- Японы төвийн ЖАЙКА-с томилогдон ирсэн мэргэжилтэн Накамүра Ко “Япон компанийн Монгол дахь үйл ажиллагааны боломжууд” сэдвийн хүрээнд илтгэл тавьсан.



Зураг 10-1. Бизнес форумын үеэр





Зураг 10-2. Бизнес форумын үеэр

### III. ОНЦЛОХ МЭДЭЭ

#### 1. Жайка-ийн хувийн хэвшлийн хамтын ажиллагааны төслийн хэрэгжилтийн жишээ

2023 оны 9-р сард ЖАЙКА-ийн хувийн хэвшлийн хамтын ажиллагааны төслийн дагуу хэрэгжүүлж буй “Жижиг дунд бизнес, тогтвортой хөгжлийг дэмжих төсөл”-ийн “Эрэлтийн судалгаа”-нд шалгарсан Японы “Аэронэкт” компани нь уг төслийг Монгол улсад хариуцаж ажиллахаар болсон бөгөөд хүргэлтийн дроны талаар танилцуулах семинарыг зохион байгууллаа. 11-р сард уг төслийн хүрээнд дрон ашиглан Улаанбаатар хотод Улсын хоёрдугаар эмнэлгээс АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг хүртэлх 10 км тойрог замд цус сэлбэлтэд ашиглах цусыг зөөвөрлөн хүргэсэн. Бага температурт, дрон нисэхэд хэцүү нөхцөлд туршилтын нислэг амжилттай болж өндөрлөсөн бөгөөд цаашид Монголд бизнесээ эхлүүлэхээр ажиллаж байна.

2022 оны 5-р сард Японы Аэронэкт компанийн төлөөлөгч Монголд ирж, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвтэй танилцан, бизнесийн хамтын ажиллагааг дэмжих ажилтай танилцсанаар уг төсөл эхэлсэн. Бизнесийн хамтын ажиллагааг дэмжих ажлын хүрээнд бид сонирхож буй хувь хүн болон байгууллагуудад “Монгол дахь бизнесийн удирдлагын чиглүүлэх сургалт” явуулсан. Үүний дараа хариуцсан хүмүүстэй холбогдож, суурь судалгааг хэрэгжүүлсэний үр дүнд 2022 онд “Жижиг дунд бизнес, тогтвортой хөгжлийг дэмжих төсөл”-д хамрагдахаар бүртгүүлсэн. Төслийн талаар нийтэд зарлахаас өмнө Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс хэд хэдэн удаа зөвлөмж, туслалцаа үзүүлснээр төсөлд амжилттай шалгарсан.

“Жижиг дунд бизнес, тогтвортой хөгжлийг дэмжих төсөл” нь энгийн хөрөнгө оруулалт бус ЖАЙКА-ийн дэмжлэг үзүүлж ажилладаг улс орнуудад тулгамдаж буй асуудлыг шийдэхэд технологи болон үйлчилгээгээрээ тусалж чадах Япон компаниудыг



дэмжих зорилготой төсөл юм. Энэ нь ЖАЙКА-ийн бизнесийн хөгжлийг дэмжих төсөл болно.

Бизнесийн хамтын ажиллагааг дэмжих ажлын хүрээнд Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн хувьд “Монгол дахь бизнесийн удирдлагын чиглүүлэх сургалт”-ыг хариуцан хэрэгжүүлсэн. Сургалт аль болох олон хүнд хүрч, дээрхтэй адил жишээнүүдийг улам нэмэгдүүлээсэн гэж хүсэж байна.



Зураг 11-1. Хүргэлтийн дрон



Зураг 11-2. Хүргэлтийн дроны талаар танилцуулах семинарын үеэр

## 2. Бизнесийн ахисан түвшний сургалт Завхан аймагт анх удаа амжилттай зохион байгууллаа

2020 оноос бизнесийн сургалтуудыг цахимаар зохион байгуулж ирснээс хойш хөдөө орон нутгаас хамрагдах хүмүүсийн тоо нэмэгдэсээр байгаа билээ. Энэ удаа 2019 оны бизнесийн үндсэн сургалтын төгсөгч Загасан нүд-Загастай ХХК-ийн захиалгаар Завхан аймгийн Улиастай хотод үйл ажиллагаа явуулж буй компани, аж ахуйн нэгжийн удирдлагуудад 2 сэдвээр ахисан түвшний сургалт зохион байгууллаа.

Эхний сургалт болох “Стратегийн менежмент” сэдвийг Монгол-Японы төвийн үндэсний сургагч багш Н.Батдэлгэр заасан юм. Үргэлжлүүлэн “Хүний нөөцийн менежмент” сургалтыг үндэсний сургагч багш Д.Дашмаа удирдан явуулсан бөгөөд



яагаад хүний нөөцийн менежмент чухал болох, хүний нөөцийн үндсэн функцууд болон удирдах ажилтны манлайлал, байгууллагын соёл гэсэн агуулгаар 4 өдрийн турш онол болон багийн ажлыг хослуулан заалаа.

Тус сургалтад 9 компанийн 16 хүн хамрагдаж менежментийн олон ур чадваруудыг эзэмшихээс гадна Завхан аймгийг хөгжүүлэх, цаашдын хамтын ажиллагааны талаар сургалтын явцад санал солилцож байлаа.



Зураг 12. Завхан аймаг дахь “Хүний нөөцийн менежмент” сургалтын явц



Зураг 13. Завхан аймаг дахь сургалтад хамрагдсан суралцагчид

### 3. “Global value chain” сэдэвт ахисан түвшний шинэ сэдэв нэмэгдлээ.

Сургалтыг Кансай их сургуулийн эдийн засгийн факультетийн профессор Гото Кэнта багш удирдан явуулсан бөгөөд шинэ агуулга, шинэ багштай онцгой сургалт болж өндөрлөлөө.

Энэхүү сургалтаар глобал эдийн засгийн динамик болон үнэ цэнийн гинжин хэлхээ, бизнес ба тогтвортой байдал, Япон болон Зүүн Азийн үйлдвэржилтийн туршлагаас суралцах, аж үйлдвэрийн онцлогийг ойлгох нь зэрэг сэдвүүдийн хүрээнд дэлхийн хөгжлийн чиг хандлага, эдийн засгийн интеграци, бизнесийн боломж болон сорилтуудын талаарх ойлголтуудыг өгч Монгол улс цаашид ямар чиглэлээр аж үйлдвэр хөгжүүлэх талаар бүгд санал бодлоо солилцсон онцлог сургалт байлаа.

Энэ удаагийн сургалт нь урьд өмнө явагдаж байгаагүй шинэ сэдэв байсан гэдэг утгаараа оролцогчдын хүлээлт өндөр байсан бөгөөд агуулгын хувьд баялаг мөн сонирхолтой байсан учир тэрхүү хүлээлтэд нь нийцсэн, үр өгөөжтэй сургалт болсон гэдэгт итгэлтэй байна.





Зураг 14. Сургалтыг удирдан явуулсан Гото Кэнта багш



Зураг 15. “Global Value Chain” сургалтын явц

#### 4. “ICT/digital Business Study Tour in Mongolia” зохион байгуулав.

Жайкагийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн (ICT) салбарыг дэмжих үйл ажиллагаанн хүрээнд ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран 2023 оны 6 сарын 5-11-ний өдрүүдэд “ICT Tour” бизнес аяллыг зохион байгууллаа. Энэхүү аялалд Монголын зах зээлд гарахаар сонирхож буй Японы жижиг дунд компани, холбоод, их дээд сургууль, коосэн сургуулийн төлөөлөл 19 компани оролцов.

Уг бизнес аялал “ICT EXPO 2023”-т оролцон Монголын IT салбарын өнөөгийн нөхцөл байдал болоод цаашдын зорилготой танилцаж бизнесийн хамтрагчаа олон, холбоо тогтоож яриа хэлэлцээр хийх, “DX Cup Mongolia” тэмцээний илтгэлийн шатыг үзэж сонирхох, Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Япон Коосэн сургуулиудаар зочлон технологийн салбарын ирээдүйн хүний нөөцтэй танилцах, мэдээлэл технологийн салбарын компаниудаар зочлон харилцан туршлага, санал солилцох зэрэг хөтөлбөртэй зохион байгуулав. Түүнчлэн аяллын хүрээнд 2 орны бизнес эрхлэгчдийг холбох зорилгоор Монголын арилжааны банктай хамтран “Business networking event” зохион байгуулж Монголын компани, аж ахуйн нэгжийн захирал удирдлагууд оролцлоо. Үүнээс гадна тус аялалд хамрагдсан 4 компанийн төлөөлөл Монголын их дээд сургуулиудад IT чиглэлээр суралцаж буй оюутнуудад чиглэсэн “Ажлын байрны өдөрлөг”-ийг Монгол-Японы төв дээр зохион байгуулж, нийт 162 оюутан залуус хамрагдан хэрэгцээт мэдээллээ авлаа.

Энэ удаагийн бизнес аялалд оролцсон Япон улсын төлөөллийн зүгээс “Монголын талаарх сэтгэгдэл өөрчлөгдөж, бизнес, хүний нөөц хөгжүүлэлтийн талаар харилцан ашигтай ажиллах боломжийг олж харсан чухал ач холбогдолтой аялал байлаа”, “Үнэхээр гайхалтай байлаа”, “Монголын талаар мэдээлэлтэй боллоо” гэх мэт сэтгэгдлүүд ирсэн юм.

Монгол-Японы төв нь цаашид энэ салбарын болон бусад салбарын бизнес аяллыг 2 орны хамтын ажиллагааг өргөжүүлэн тэлэх, хөгжүүлэх зорилгоор зохион байгуулах зорилготой байна.



Зураг 16. Монгол-Японы төв дээр явагдсан “Ажлын байрны өдөрлөг”-ийн явц



Зураг 17. Монголын компаниудаар зочилж танилцаж буй явц

#### IV. ТӨГСӨГЧДИЙН ДУУ ХООЛОЙ

### 1. Бүгд сурах эрмэлзэлтэй хүмүүс нэг анги болон суралцах нь юу юунаас ч илүү чухал юм байна гэдгийг өөрийн биеэр мэдэрсэн гайхамшигтай 3 сар байлаа.



Зураг 18. Б.Санчо

Боловсрол бол бүх зүйлийн түлхүүр гэж би хувьдаа ойлгодог учир үргэлж шинийг суралцах зүйлд цаг хугацаагаа зарцуулдаг. Олон газар сурч байснаас энэ удаагийн сургалт бусад сургалтуудаас бүх тал дээр шилдэг нь байж чадсан. Суралцахад мэдээж анги танхим, сургалтын хөтөлбөр болон багш гээд олон зүйлс нөлөөлдөг бол энэ удаад ангийн хамт олон маш ихээр нөлөөлсөн сургалт болж чадсан. Мэдээж сургалтын хөтөлбөр, багш, анги танхим зэрэг нь хамгийн сайн байсан.

Төрийн бус байгууллага ажиллуулдаг байхдаа хүүхдүүдэд сургалт ордог төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байх үедээ хүнд юм заана гэдэг тийм ч амархан зүйл биш гэдгийг ойлгосон. Тэгтэл Монгол-Японы төв үүнийг маш сайн хэрэгжүүлж байсан бөгөөд ямар насны, ямар боловсрол хүмүүжилтэй байсан хамаагүй өөрийн хичээлийн хөтөлбөрт тухайн хүнийг нэгэн жигд оролцуулж сургалтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулж байсан нь миний гайхширлыг төрүүлсэн.

Өмнө сургах явцад ангийн хамт олон ийм чухал байсныг би сайн мэдээгүй явжээ. Бүгд сурах эрмэлзэлтэй хүмүүс нэг анги болон суралцах нь юу юунаас ч илүү чухал юм байна гэдгийг өөрийн биеэр мэдэрсэн гайхамшигтай 3 сар байлаа.

Сургалтаас хойш миний хувьд аливаа зүйлсийг олон ургалч үзлээр харж бүх зүйлийг даван туулах эрч хүч, мэдлэгийг олж авсандаа баяртай байгаа.

**Бизнесийн үндсэн сургалтын 23 дахь элсэлтийн Удирдлагын ангийн төгсөгч “Жэй Си Дэко Монголиа ХХК” компанийн борлуулалт хариуцсан захирал Б.Санчо**





## 2. 12 хоногийн турш бүхнийг мэдэгч, бүхний чадагч, гайхамшигтай, шидтэй хүнтэй уулзсан мэт, сэтгэл дүүрэх мэдрэмжийг авсан



Зураг 19. Д.Хишигдэлгэр

Миний бие Монгол-Япон Төвийн Бизнесийн сургалтын идэвхитэй суралцагч, жижиг компанийн удирдах ажилтан билээ. 2016 онд тус төвийн Менежерийн ангийг төгссөн. Бизнесийн тухай бүх үндсэн ойлголтоо энэхүү төвийн сургалтуудаас олж аваад, өөрөө цааш уншиж, судлаад, өөрийн ажилдаа хэрэгжүүлдэг.

Монгол-Япон Төвийн төгсөгчдөөс Япон улсад дадлага сургалтанд явуулна гэдэг зарыг 2023 онд хараад, шалгаруулалтанд нь тэнцэж, 22 хүний бүрэлдэхүүнд багтсан. Кюүшү аралын Китакюүшү хотын ЖАЙКА-гийн сургалтын төвд байршиж, 12 хоногийн турш Кансай Их Сургуулийн профессор Гото Кэнтагийн удирдлага доор олон япон компаниуд, музейд зочилж, тэднээс суралцлаа.

Зочилсон компаниудынхаа талаар семинар зохион байгуулж, бид хоорондоо ярилцаж, Гото Кэнта профессор онолын түвшинд тайлбарлан, зааж өгч байсан нь, харсанаа онолын түвшинд ойлгосон маш ашиг тустай сургалт байлаа.

Би Японы компаниудаас дараах зүйлсийг суралцах, өөрийн биеэр үзэж, туршлагажих зорилготой явлаа:

1. *Бизнес эрхлэх орчин нь хууль, эрх зүйн хүрээндээ явагддаг, зах зээлийн хууль нь үйлчилдэг орны компаниудын үйл ажиллагааг бодитоор харах. Миний хувьд “Япон систем” хэрхэн ажилладаг вэ гэдэг асуулт юм.*
2. *Энэхүү систем доторх тоглогч компаниудын удирдагч, манлайлагч нарыг яаж ажилладагийг харах;*
3. *Энэ “Япон систем”-д тоглож буй компаниуд (market players) ямар засаглалаар, ямар менежмент, зарчимаар ажиллаж буйг харах.*

Дээрх гурван асуултандаа олсон хариугаа та бүхэнтэйгээ хуваалцахад:

1. Бид янз бүрийн чиглэлийн, төрөл бүрийн хэмжээтэй компаниудын, олон түвшиний ажилтануудтай уулзаж, тэдний сургалтанд суралцаж, танилцуулгыг сонссон.

Компанийн үүсгэн байгуулагч, захирал, менежер, өв залгамжлагч, корпорацийн музейн тайлбарлагч, орон нутгийн удирдах ажилтан, компанийн энгийн ажилтан, төрийн бус байгууллага, холбооны ажилтан гээд маш олон төрлийн хүмүүстэй уулзсан.

Эдгээр бүх хүмүүст байгаа нийтлэг нэг шинж нь тэд бүгд, “манай компани, манай байгууллага, манай хотын зорилго юу вэ, манай компани ямар зарчим, философитой ажилладаг вэ, бид юуны төлөө ажиллаж байгаа вэ” гэдгээ бүх түвшиндээ мэдэж байв.



“Бидний ажил, ажлын маань үр дүн Япон улсад, Япон системд шууд нөлөөлдөг, Япон улсыг амжилттай эсвэл уналттай байх нь над шиг олон сая хүнээс хамаардаг” гэдгээ ухамсарласан байлаа. Өөрөөр хэлбэл, Япон системийн үндэс нь “хариуцлага-надаас-эхэлнэ” гэсэн ухамсар дээр тогтож буйг ойлгов.

2. Удирдах ажилтны тухай миний дотор хоёр зөрчилдөөн оршдог байлаа.

Монголд маань компанийн захирал, менежер гэхээр дараах төсөөлөлийг нийтлэг ойлгож, хэвлэл мэдээлэлээр сурталчилдаг: Костюм өмссөн, даргын том том модон хүнд мебельтэй, эсвэл тансаг өрөөнд суусан, хааяа ажилдаа ирдэг, сул чөлөөтэй цаг ихтэй, ажлын нарийн ширийн детальд тэр бүр оролцдоггүй, оролцох ч ёсгүй, оролцвол багийн бусад гишүүд гайхдаг. Тэд ихэмсэг, хүрэшгүй байх ёстой ч юм шиг төсөөлөл миний оюун ухаанд яагаад ч юм суучихжээ.

Гэтэл жижиг компанийн удирдах ажилтан миний бодит амьдрал дээрх нийтлэг төсөөлөлөөс тэс өөр: ажлын хувцастайгаа үргэлж нааш цааш гүйсэн, бүхий л жижиг, том гэлтгүй асуудалуудад оролцдог, бүхий л түвшиний ажлуудыг өөрөө гардан гүйцэтгэдэг, хийж буй ажилдаа дуртай учраас өдөржин, шөнөжин ажлаа бодож явдаг, эгэл жирийн байхыг хүсдэг гэх мэт.

Дээрх хоёр зөрчилдөөнөөс (нэг талаас нийгмийн төсөөлөл, нөгөө талаас миний бодит амьдрал хоёрын зөрүү) болоод “ингэх нь буруу юм болов уу”, “ингэх ёсгүй юм болов уу”, “би л ганцаараа ийм юм болов уу”, “бусад компаниуд өөрөөр хийгээд байна даа”, “бусад маань яаж хийдэг юм болдоо” гэх мэт эргэлзээ, асуултууд төрдөг байлаа.

Гэтэл Япон компаниудын захирал, менежерүүд, ажилтнуудтай уулзаад, тэд өөрсдийн ажлын туршлага, ажлын аргаа яриад, тэдэнд тулгардаг асуудлуудыг нь сонсоод эхэлтэл, надад “Яг над шиг юмаа”, “Надад яг ийм асуудал бас тулгардаг шүү дээ”, “Энийгээ яг ингэж шийдэх хэрэгтэй юм” гэх мэт бодолууд хөврөж эхлэв. Өөртэйгөө ижил төрлийн жаргалтай, зовлонтой хүмүүсийг анх удаа, бөөнд нь сонсоод, хүмүүс намайг гэнэт ойлгож эхэлж байгаа юм шиг мэдрэмж төрөв. Гэнэт “би ганцаараа биш юм байна”, “би зөв замаар явж байгаа юм байна”, “өөрийнхөөрөө байж, ажилдаа дуртай байж, өдөржин, шөнөжин ажлаа бодож, дурлаж ажиллаж болдог юм байна”, “том, жижиг гэхгүйгээр бүхий л ажил хэрэгтээ зүрх сэтгэлээсээ хандаж, оролцох ёстой юм байна” гэх мэт бодол төрсөн.

Мөн бидний асуусан маш энгийн асуултуудаас (“Та гэрээгээ дуусахад мөнгөө яаж шийдсэн бэ?”, “Та компанийг тань үүсгэсэн эгчтэйгээ хэрхэн яаж ойлголцдог вэ?” “Та идеалист хүн үү?”) эхлээд төвөгтэй хүнд асуултуудад (“Компанийн стратегиа глобал түвшинд хэрхэн хэрэгжүүлдэг вэ?”, “Оюуны өмчөө Хятадын зах зээл дээр яаж хамгаалдаг вэ?”) уулзсан захирал бүр илэн далангүй хариулсан нь бидэнд маш том туршлагажих боломж байлаа.

Асуултууддаа хариугаа аваад, 12 хоногийн турш бүхнийг мэдэгч, бүхний чадагч, гайхамшигтай, шидтэй хүнтэй уулзсан мэт, сэтгэл дүүрэх мэдрэмжийг авсан.



Япон компаниудын удирдах ажилтанууд ямар энгийн, ажилсаг, даруу хүмүүс байдаг юм бэ гэж бодов. Удирдагч, манлайлагч нар нь ажилдаа хайртай, дуртай байдаг юм байна гэдгийг ойлгов.

3. Компанийн засаглал, менежмент дээр ойлгосон зүйл маань маш товчхон:

Тэд хэлсэн, бичсэн юмаа яг хэрэгжүүлдэг юм байна. Хэлсэн, бичсэн зүйлс нь үнэн юм байна.

Ийнхүү Япон улсын ард түмэний тэтгэлэгээр, ЖАЙКА, Монгол-Японы төвийн сургалтанд хамрагдаад өөртөө итгэх итгэлээ нэмэгдүүлээд ирсэн маань хамгийн том амжилт байлаа.

Бичих зүйл үүнээс ч их бий.

Бидний очсон Китаюшү болон бусад хотуудын удирдлага, иргэд нийлж байгаль орчины аймшигтай бохирдолоо хэрхэн арилгасан тухай, хүн амын хөгширөлттөйгөө хэрхэн зохицож буй тухай, хүний эрхийн сэдэв бол бизнестэй хамаатай тухай гээд бусад сонирхолтой сэдвээсээ бичсэнгүй.

Улс бүр, хот бүр, компани бүр, ажилтан бүрт өөрт нь асуудал бэрхшээл тулгарч байгааг бид харж байв. Гэвч тэд асуудлаа шийдэж, бэрхшээлээ давна гэсэн итгэл, үнэмшилтэйгээр ажиллаж, амьдарч буйг нь хараад бахархах сэтгэл төрсөн.

ЖАЙКА-гийн Кюүшү дэхь сургалтын төв, оюутаны байранд байршиж байсан маань Германд байсан оюутан үе, оюутны байрыг маань санагдуулаад, сайхан байв.

Бидний байршиж байсан Китаюшү хот маань Япондоо “хөдөөний хот” буюу нам тайван, цэвэрхэн, стрессгүй хот байсан нь утаатай, дуу чимээтэй, стресстэй Улаанбаатараас ирсэн бидэнд маш их таалагдаж, суралцангаа амарч буй мэт сайхан санагдаж байв. Аравдугаар сард цаг агаар дулаахан, ногооноороо, оройдоо бороо шивэрч орох нь бүр ч таатай.

Суралцагч бид аз жаргалтай 12 хоногийг хамтдаа өнгөрөөж, их зүйлийг сурч, мэдээд, эрч хүчтэйгээр эргэн Монголдоо ирсэн билээ.

***Бизнесийн үндсэн сургалтын 14 дахь элсэлтийн Менежерийн ангийн төгсөгч***

***2023 оны Япон дахь дадлага сургалтын оролцогч***

***РТТ ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Хишигдэлгэр***

# ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТАСАГ







## I. ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТ, СЕМИНАРЫН ТАЙЛАН

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв /цаашид Монгол-Японы төв гэх/-ийн Япон хэлний сургалтын тасаг нь 2012 оны 4 сараас Япон сангийн япон хэлний боловсролын стандартад /цаашид JF стандарт гэх/ нийцүүлсэн япон хэлний сургалтыг зохион байгуулж эхлээд энэ онд 11 дэх жилээ үдлээ. Сургалтад багшилж буй багш нар нь “Нэгж хичээлийн хөтөлбөрийн хэлэлцүүлэг”, “Сургалт дууссаны дараах тайлангийн хурал”, “Хичээлийн явцын тэмдэглэл”, “Япон хэлний сургалтын тасгийн багш нарт зориулсан заах аргын сургалт семинар” зэргээр дамжуулан сургалтын агуулга болон заах аргын чанарыг хадгалах, сайжруулахад тасралтгүй анхааран ажилладаг билээ.

2023 онд ковид-19 цар тахлын нөлөө багассантай холбогдуулан япон хэлний сургалтуудаа жилийн туршид танхимаар зохион байгуулж чадсан. Гэрээт ажлын хувьд, энэ онд ч мөн адил “Тусгай ур чадварын тогтолцоо”-той холбоотой ажлуудыг үргэлжлүүлэн хийснээс гадна Японы Кёото их сургуулийн iUP хөтөлбөрт тэнцсэн оюутанд зориулсан япон хэлний сургалт, мөн Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалтуудыг амжилттай зохион байгууллаа.

### 1. Япон хэлний сургалтын талаар

Япон хэлний сургалт нь дээр дурдсан JF стандартын дагуу явагдаж байгаа болно. Энэхүү тайлан мэдээ нь 2023 оны 2 сараас 5 сарын хооронд явагдсан хаврын сургалт болон 5 сараас 7 сарын хооронд явагдсан зуны сургалтын эхний хагас, 7 сараас 8 сарын хооронд явагдсан зуны сургалтын сүүлийн хагас, 9 сараас 12 сарын хооронд явагдсан намрын сургалт /сургалт дуусах хугацаа 2024 оны 1 сар/-уудын тайлан болно. Хавар намар явагддаг сургалтуудад суралцагчдын түвшинд тохирсон “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт”-ууд болон “11-13 насны хүүхдэд зориулсан Марүгото япон хэлний сургалт” “Япон хэлний багш нарт зориулсан япон хэлний заах аргын сургалт”-ыг явуулж байна. Дээрх сургалтуудын агуулга болон үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтээс харна уу. Хавар болон намрын сургалт нь 4 сар орчим үргэлжилдэг ба “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1”/анхан шат/-ээс “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-6” /дунд шат/ хүртэл явагддаг. Энэ жилийн “Япон хэлний заах аргын сургалт” нь хавар болон намар “Япон хэлний сургалтад япон сангийн япон хэлний боловсролын стандартыг ашиглан анхан шатны япон хэлийг хэрхэн заах вэ” сэдвээр явагдсан. Зуны сургалтын эхний болон сүүлийн хагаст “Анхан шатны түргэвчилсэн сургалт”-ыг нийт 4 удаа, “8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалт”-ыг 1 удаа тус тус зохион байгууллаа. Энэ жил “Япон хэлтэй хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт /нийт 13 удаагийн 33 цаг/-ыг онцсайн үнэлгээтэйгээр, мөн намрын улиралд дундаас дээш шатны мэдлэгтэй суралцагчдад зориулж “Бизнесийн япон хэлний сургалтууд”-ыг амжилттай зохион байгуулсан. Сургалтад японы хөрөнгө оруулалттай байгууллага, компанийн ажилтнууд





болон бизнесийн япон хэлийг өдөр тутамдаа ашигладаг хүмүүс төдийгүй, өөрийн япон хэлний чадварыг сайжруулах зорилготой хүмүүс хамрагдсан.

## 2. Хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны талаар

2023 онд хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны хувьд, 11 сард “Япон хэлний боловсролын симпозиум” болон “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 29 дэх удаагийн тэмцээн” зохион байгуулагдсан. Түүнээс гадна “Монголын япон хэлний сургалт, судалгааны холбооны ээлжит хурал” зэрэг олон төрлийн үйл ажиллагааг Япон улсын Элчин Сайдын Яам, Монголын япон хэлний багш нарын холбоо болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

## 2023 онд япон хэлний сургалтын тасгаас зохион байгуулсан үйл ажиллагаа

### Хүснэгт 12. Хавар, зун, намрын сургалтууд

Эх сурвалж: Монгол-Японы төв, Япон хэлний сургалтын тасгийн сар бүрийн тайлан

№	Сургалтын нэр	Хугацаа	Агуулга	Багш	Сурагчдын тоо
1	Хүүхдэд зориулсан марүгото япон хэлний анхан шатны сургалт /11-13 нас, А1 түвшин/	2023/02/07-2023/05/11	Япон хэлийг анхлан суралцаж буй 11-13 насны хүүхдүүдэд зориулсан, Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон-А1, рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт.	Г.Ариунболор, Күрияма Томоюки	9
2	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1А анги /А1 түвшин/	2023/02/06-2023/05/22	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Ц.Онон, О.Булган, Сато Кэйичи	26
3	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1В анги /А1 түвшин/	2023/02/06-2023/05/22	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Ц.Онон, О.Булган, Сато Кэйичи	26



4	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2А анги /А2 түвшний эхний шат/	2023/02/06-2023/05/22	А1 түвшний япон хэлийг эзэмшсэн суралцагчдад зориулсан дараагийн А2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-1 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Г.Ариунболор, П.Алтанбулаг, Д.Золзаяа, Күрияма Томоюки	17
5	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2В анги /А2 түвшний эхний шат/	2023/02/06-2023/05/22	А1 түвшний япон хэлийг эзэмшсэн суралцагчдад зориулсан дараагийн А2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-1 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Г.Ариунболор, П.Алтанбулаг, Д.Золзаяа, Күрияма Томоюки	23
6	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3А анги /А2 түвшний дунд шат/	2023/02/06-2023/05/22	А2 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, дараагийн шатны А2 түвшний дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-2 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Мөнхтуяа, Д.Золзаяа, Күрияма Томоюки	17
7	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3В анги /А2 түвшний дунд шат/	2023/02/06-2023/05/22	А2 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, дараагийн шатны А2 түвшний дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-2 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Мөнхтуяа, Д.Золзаяа, Күрияма Томоюки	17



8	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-4 /A2 түвшний төгсгөлийн шат-V1 түвшний эхний шат/	2023/02/07-2023/05/30	A2 түвшний дунд шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, A2 түвшний төгсгөлийн шат болон V1 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шочюүкюү A2/V1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	П.Марал, Икома Каорү	24
9	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5 /V1 түвшин/	2023/02/07-2023/05/23	V1 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан V1 түвшний дунд шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото чюүкюү-1 V1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Мөнхтуяа, Икома Каорү	10
10	Япон хэлний заах аргын сургалт /B2-C1 түвшин/	2023/02/09-2023/05/11	1) Хоёр дахь хэл эзэмшихүйн онол болон Япон сангийн япон хэлний боловсролын стандартыг ашигласан япон хэлний заах арга зүйн суурь ойлголтод суралцах 2) Анхан шатны япон хэлний нэгж хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад суралцаж, өөрийн боловсруулсан хөтөлбөрт үндэслэн жишиг хичээлийг заах	Цүрүта Ясүюки, Саго Кэйичи, Э.Эрдэнэцэцэг	12
11	Япон хэлтэй хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт *Шинэ сургалт	2023/04/24-2023/05/08	Япон жуулчдын хөтөч-тайлбарлагчаар ажиллах хүсэлтэй хүмүүст зориулан аяллын хөтчийн ноу-хау, ёс зүй, гадаад төрх байдал, хувцаслалт, мэдвэл зохих үг хэллэгийн талаарх ойлголтыг өгч, бодитоор хэрэглэхэд нь туслах зорилго бүхий сургалт бөгөөд лекц, бодит туршлага дээр үндэслэсэн яриа, хосоор болон багаар ажиллах дасгал даалгавар зэрэг онол, практик хослуулсан нийт 13 удаагийн 33 цагийн сургалт юм.	Зочин багш: Б.Багмөнх, Б.Гантулга Үндсэн багш: О.Булган, Э.Эрдэнэцэцэг, Г.Ариунболор, П.Марал, Б.Буманцэцэг	24
12	Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт-А анги /A1 түвшин/	2023/05/24-2023/07/06	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон A1 рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих чадваруудыг олгох сургалт юм.	Г.Ариунболор, П.Марал, Б.Буманцэцэг, Д.Золзаяа, Икома Каорү, Күрияма Томоюки, Саго Кэйичи	18



13	Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт-В анги /А1 түвшин/	2023/05/24-2023/07/06	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон А1 рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих чадваруудыг олгох сургалт юм.	Г.Ариунболор, П.Марал, Б.Буманцэцэг, Д.Золзаяа, Икома Каорү, Күрияма Томоюки, Сато Кэйичи	23
14	Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт-А анги /А1 түвшин/	2023/07/19-2023/08/29	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон А1 рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих чадваруудыг олгох сургалт юм.	Д.Золзаяа, Ц.Онон, О.Булган, Икома Каорү, Күрияма Томоюки	28
15	Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт-В анги /А1 түвшин/	2023/07/19-2023/08/29	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон А1 рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих чадваруудыг олгох сургалт юм.	Д.Золзаяа, Ц.Онон, О.Булган, Икома Каорү, Күрияма Томоюки	26
16	Хүүхдэд зориулсан япон хэлний анхан шатны сургалт /8-10 нас/	2023/07/20-2023/08/22	Япон хэлийг хөгжилтэйгөөр сурах хүсэлтэй 8-10 насны хүүхдүүдэд зориулсан сургалт. Мэндчилгээний үг хэллэг, өөрийгөө танилцуулах, гэр бүлээ танилцуулах, дуртай идэх уух зүйлээ хэлэх, өөрийн биеийн бүтэц, төрсөн өдөр, хобби, амралтын өдөр зэргийн талаар хэлж сурсан. Мөн хирагана үсгийг уншиж, бичиж сурсан. Катакана үсгээр өөрийн нэр болон улсын нэрийг уншиж, бичиж сурсан.	П.Марал, Г.Ариунболор, Күрияма Томоюки, Икома Каорү	25
17	Хүүхдэд зориулсан марүгото япон хэлний анхан шатны сургалт /11-13 нас, А1 түвшин/	2023/09/26-2023/12/21	Япон хэлийг анхлан суралцаж буй 11-13 насны хүүхдүүдэд зориулсан, Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон-А1, рикаи" сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт.	Г.Ариунболор, Күрияма Томоюки	15



18	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1А анги /А1 түвшин/	2023/09/25-2024/01/10	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Ц.Онон, Б.Буманцэцэг, Күрияма Томоюки	28
19	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1В анги /А1 түвшин/	2023/09/25-2024/01/10	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Ц.Онон, Б.Буманцэцэг, Күрияма Томоюки	28
20	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1С анги /А1 түвшин/	2023/09/25-2024/01/10	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото нюүмон-А1 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Г.Ариунболор, П.Марал, О.Булган, Икома Каорү	17
21	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2А анги /А2 түвшний эхний шат/	2023/09/25-2024/01/10	А1 түвшний япон хэлийг эзэмшсэн суралцагчдад зориулсан дараагийн А2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-1 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	П.Алтанбулаг, О.Булган, Сато Кэйичи	23
22	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2В анги /А2 түвшний эхний шат/	2023/09/25-2024/01/10	А1 түвшний япон хэлийг эзэмшсэн суралцагчдад зориулсан дараагийн А2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-1 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	П.Алтанбулаг, О.Булган, Сато Кэйичи	26





23	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3А /А2 түвшний дунд шат/	2023/09/25-2024/01/10	А2 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, дараагийн шатны А2 түвшний дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-2 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Золзаяа, Д.Мөнхтуяа, Икома Каорү	11
24	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3В /А2 түвшний дунд шат/	2023/09/25-2024/01/10	А2 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, дараагийн шатны А2 түвшний дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шокюү-2 А2 кацүдоо, рикаи" хэмээх 2 сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Золзаяа, Д.Мөнхтуяа, Икома Каорү	9
25	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-4 /А2 түвшний төгсгөлийн шат-В1 түвшний эхний шат/	2023/09/26-2024/01/23	А2 түвшний дунд шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, А2 түвшний төгсгөлийн шат болон В1 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото шочюүкюү А2/В1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Золзаяа, Күрияма Томоюки	12
26	Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5 /В1 түвшин/	2023/09/26-2024/01/16	В1 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан В1 түвшний дунд шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото чюүкюү-1 В1" сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Мөнхтуяа, Икома Каорү	15



27	Бизнесийн япон хэлний сургалт *Шинэ сургалт	2023/10/10- 2023/12/21	Дунд дээд түвшний япон хэл суралцагчдын бодит хэрэглээ, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулсан шинэ сургалт юм. Япон хүмүүстэй ажил хэргээ саадгүй явуулахад нь тус дөхөм болох үүднээс бизнесийн харилцаанд утсаар хэрхэн ярих, бичиг баримт хэрхэн боловсруулах, и-мэйл хэрхэн бичих талаар ойлголт өгөхийн тулд сургалтын агуулгыг ярих, бичих, илтгэх гэсэн 3 хэсэгт хуваан боловсруулсан.	Э.Эрдэнэцэцэг, Цүрүта Ясүюки	16
28	Япон хэлний заах аргын сургалт /B2-C1 түвшин/	2023/09/28- 2023/12/21	1) Хоёр дахь хэл эзэмшихүйн онол болон Япон сангийн япон хэлний боловсролын стандартыг ашигласан япон хэлний заах арга зүйн суурь ойлголтод суралцах 2) Анхан шатны япон хэлний нэгж хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад суралцаж, өөрийн боловсруулсан хөтөлбөрт үндэслэн жишиг хичээлийг заах	Цүрүта Ясүюки, Саго Кэйичи	12
					537

### Хүснэгт 13. Тусгай сургалт, семинарууд

№	Сургалтын нэр	Хугацаа	Агуулга	Багш болон хариуцсан ажилтан	Оролцогчдын тоо
1	ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалт-2023	2023/01/17- 2023/01/20	"Бие даан суралцахуй, ханз, JLPT" гэсэн сэдвийн хүрээнд ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулан заах аргын сургалтыг зохион байгуулж, Монгол орон даяар япон хэлний боловсролыг түгээн дэлгэрүүлэх, чанаржуулахад хувь нэмэр оруулахыг зорьсон. Үүний зэрэгцээ, ЕБС-ийн япон хэлний багш нарын харилцаа холбоог бэхжүүлэхэд хүчин чармайлт гаргасан. Сургалтын агуулга: Гадаад хэлний боловсрол дахь япон хэлний сургалт, суралцагчдын бие даан суралцахад чиглэсэн сургалтын арга барил, ханз үсэг болон JLPT шалгалтад бэлтгэх сургалт зэрэг	Багш: Цүрүта Ясүюки  Сургалт хариуцсан ажилтан: Д.Мөнхтуяа, Б.Буманцэцэг	30



2	Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт *Гэрээт сургалт	2023/04/04- 2023/06/29	Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Иродори хэрэглээний япон хэл" /A1 түвшний суурь шат/ сурах бичгийг ашиглан сургалтыг зохион байгуулав.	Д.Мөнхтуяа, П.Алтанбулаг, Д.Золзаяа, Сато Кэйичи	13
3	Кёото их сургуульд элсэн орохын өмнөх япон хэлний бэлтгэл сургалт-2023 *Гэрээт сургалт	2023/06/21- 2023/08/23	Кёото их сургуулийн iUP хөтөлбөрт элсэн орж буй оюутанд зориулсан гэрээт сургалт бөгөөд Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Марүгото Япон хэл ба соёл" /чюүкюү-2, B1/ болон "Минна но нихонго" /чюүкюү-2/ сурах бичгүүдийг ашиглан, суралцагчийн сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь хөгжүүлэхийг зорьсон.	Э.Эрдэнэцэцэг, Ц.Онон, Цүрүта Ясүюки, Күрияма Томоюки	1
4	Япон жуулчдад зориулсан монголын талаарх тайлбар лекц *Гэрээт сургалт	2023/9/27	Нью Жуулчин Турс ХХК-ийн хүсэлтээр "Япон залуучуудын мод тарих найрамдлын хөтөлбөр"-ийн 13 гишүүнд тус төвийн үйл ажиллагаа, Монголын талаарх тойм тайлбар, Монгол Япон хоёр орны соёлын онцлогийн талаар танилцуулга хийсэн.	О.Булган, Э.Эрдэнэцэцэг	13
5	Төвийн ажилтнуудад зориулсан япон хэлний анхан шатны сургалт	2023/05/29- 2023/06/09	Урд өмнө нь япон хэл сурч байгаагүй тус төвийн 5 ажилтанд зориулан хирагана үсгийг уншиж бичих, ажлын байранд өдөр тутамд хэрэглэгдэх хялбар мэндчилгээний үг хэллэг, өөрийгөө танилцуулах, гэр бүлээ танилцуулах үг хэллэгүүдийг заасан.	Д.Мөнхтуяа, Г.Ариунболор, П.Марал, Б.Буманцэцэг	5
6	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N4, N5 түвшин/ *Их засаг ОУИС-ийн хүсэлтээр	2023/2/3, 2/10, 2/17, 3/31	JLPT шалгалтын N4, N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	Д.Мөнхтуяа, П.Марал	58



7	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N5 түвшин/ *"BNM-MEIRAI" Гадаад хэлний сургалтын төвийн хүсэлтээр	2023/2/10	JLPT шалгалтын N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	Б.Буманцэцэг	24
8	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N3-N5 түвшин/	2023/05/09-2023/05/12	N3-N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	Г.Ариунболор, Д.Мөнхтуяа, Б.Буманцэцэг	19
9	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N1-N5 түвшин/	2023/06/05-2023/06/09	N1-N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	П.Марал, О.Булган, Г.Ариунболор, Д.Мөнхтуяа, Б.Буманцэцэг	60
10	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N1-N5 түвшин/	2023/10/23-2023/10/27	N1-N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	Э.Эрдэнэцэцэг, О.Булган, Г.Ариунболор, Д.Мөнхтуяа, Б.Буманцэцэг	68
11	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N1-N5 түвшин/	2023/11/20-2023/11/24	N1-N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	Э.Эрдэнэцэцэг, О.Булган, Д.Мөнхтуяа, Б.Буманцэцэг	107
12	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N4-N5 түвшин/ *"Номт наран" сургуулийн хүсэлтээр	2023/10/26	N4-N5 түвшний жишиг шалгалт /Хэлний мэдлэг-үсэг, үгийн сан, хэлний мэдлэг-дүрэм, уншиж ойлгох чадвар, сонсож ойлгох чадвар/	Э.Эрдэнэцэцэг, Д.Мөнхтуяа, П.Алтанбулаг, О.Булган, Б.Буманцэцэг, Адачи Юүки	124
13	Япон хэлний сургалтын тайлангийн хурал	2023/1/23	2022 оны намрын сургалтын тайлан хэлэлцүүлэг, 2023 оны хаврын сургалтын хуваарь нягтлах, мэдээлэл солилцох	Хурал хөтлөгч: П.Марал Хурлын тэмдэглэл хөтлөгч: Г.Ариунболор Хуралд оролцогчид: Сургалт хариуцсан багш нар	11



14	Япон хэлний сургалтын тайлангийн хурал	2023/6/7	2023 оны хаврын сургалтын тайлан хэлэлцүүлэг, 2023 оны зуны сургалтын хуваарь нягтлах, мэдээлэл солилцох	Хурал хөтлөгч: О.Булган Хурлын тэмдэглэл хөтлөгч: П.Алтанбулаг Хуралд оролцогчид: Сургалт хариуцсан багш нар	13
15	Япон хэлний сургалтын тайлангийн хурал	2023/9/7	2023 оны зуны сургалтын тайлан хэлэлцүүлэг, 2023 оны намрын сургалтын хуваарь нягтлах, мэдээлэл солилцох	Хурал хөтлөгч: Б.Буманцэцэг Хурлын тэмдэглэл хөтлөгч: Д.Мөнхтуяа Хуралд оролцогчид: Сургалт хариуцсан багш нар	11
16	2023 оны хаврын сургалтын өмнөх анги хуваарилах шалгалт	2023/01/11- 2023/02/06	Яриа, дүрэм хосолсон цогц сургалт 2-6-гийн элсэлтийн өмнөх анги хуваарилах шалгалт	Д.Мөнхтуяа, Г.Ариунболор, П.Марал, О.Булган	51
17	2023 оны намрын сургалтын өмнөх анги хуваарилах шалгалт	2023/09/06- 2023/09/22	Яриа, дүрэм хосолсон цогц сургалт 2-6-гийн элсэлтийн өмнөх анги хуваарилах шалгалт	Д.Мөнхтуяа, Г.Ариунболор, П.Марал, О.Булган	47
18	Япон хэлний сургалтын тасгийн багш нарт зориулсан заах аргын сургалт, семинар	2023/1/12, 1/26, 2/16, 3/2, 3/16, 3/30, 4/12, 4/26, 5/10, 9/21, 10/11, 10/25, 11/8, 11/22, 12/20 Нийт 15 удаа	Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Япон сангийн хэлний төвийн сургалт хариуцсан багш нарт зориулан япон хэлний боловсрол, заах аргын талаарх мэдлэгээ өргөжүүлэх, харилцан мэдээллээ хуваалцах зорилготой, сурч мэдсэн зүйлээ өөрийн хичээл сургалтад хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт юм.	Цүрүта Ясүюки	132
19	Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт /JFT-Basic/-ын удирдамж семинар	2023/2/15, 5/16, 8/1, 11/1	JFT-Basic шалгалтын талаарх ерөнхий тайлбар, тестийн зорилго, зорилтот хүмүүс, тестийн хэлбэр, компьютерийн дэлгэц дээрх зураглал, түүний бүтэц, түвшний үзүүлэлт, тестийн дүнг хэрхэн харах тухай тайлбар, тестийн ерөнхий загварыг танилцуулах, "Иродори онлайн сургалт"-ын талаарх товч танилцуулга, асуулт хариултын цаг гэсэн агуулгатайгаар зохион байгуулагдсан.	П.Алтанбулаг, О.Булган	94





20	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийг ашигласан заах аргын семинар	2023/6/14-6/16, 6/19, 6/20	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн агуулга, онцлог, заах аргын талаарх үндсэн ойлголтуудыг олгох сургалт. Сургалт нь загвар хичээлд оролцон, хичээлийн талаарх санал сэтгэгдлээ хуваалцах, суралцагчид өөрсдөө сурах бичгийг ашиглан хичээл зааж үзэх, заасан хичээлийнхээ талаар харилцан санал бодлоо солилцох, сургалтын талаарх ерөнхий дүгнэлт хийх гэсэн хэсгүүдээс бүтнэ.	Цүрүта Ясүюки, Сато Кэйичи, П.Алтанбулаг	16
21	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийг ашигласан заах аргын семинар	2023/9/13-9/15, 9/18, 9/19	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн агуулга, онцлог, заах аргын талаарх үндсэн ойлголтуудыг олгох сургалт юм. Сургалт нь загвар хичээлд оролцон, хичээлийн талаарх санал сэтгэгдлээ хуваалцах, суралцагчид өөрсдөө сурах бичгийг ашиглан хичээл зааж үзэх, заасан хичээлийнхээ талаар харилцан санал бодлоо солилцох, сургалтын талаарх ерөнхий дүгнэлт хийх гэсэн хэсгүүдээс бүтнэ.	Цүрүта Ясүюки, Курияма Томоюки, П.Алтанбулаг	16
22	"Иродори япон хэлний онлайн сургалт"-ын танилцуулах хичээл	2023/6/7, 10/23	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийг түгээн дэлгэрүүлэх, Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн /JFT-Basic/ шалгалтад тэнцэх Монгол суралцагчдын тоог нэмэгдүүлэхэд туслах зорилгоор "Иродори япон хэлний онлайн сургалтын"-ын талаарх ерөнхий ойлголт өгөх, хэрхэн хэрэглэх аргыг сурч, дасгал даалгавар дээр ажиллаж үзсэн.	П.Алтанбулаг	33
23	"Иродори" сурах бичгийн заах арга зүйн туршлага солилцох семинар  *Шинээр зохион байгуулсан үйл ажиллагаа	2023/2/4	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн онцлог, хэрэглэх аргын талаар товч танилцуулсны дараа, "Иродори" сурах бичгийг сургалтдаа амжилттай ашиглаж буй 4 багш өөрсдийн заах арга зүйн туршлага, ололт амжилт, хүндрэл бэрхшээлээсээ хуваалцсан.	Э.Эрдэнэцэцэг, О.Булган, Б.Буманцэцэг, Г.Ариунболор, Цүрүта Ясүюки	45



24	“Иродори” сурах бичгийн заах арга зүйн туршлага солилцох семинар	2023/12/9	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн ерөнхий бүтэц онцлог, хэрэглэх аргын талаар товч танилцуулсны дараа, сурах бичгийг сургалтдаа амжилттай ашиглаж буй 4 багш өөрсдийн заах арга зүйн туршлага, ололт амжилт, хүндрэл бэрхшээлээсээ хуваалцсан. Үйл ажиллагааны төгсгөлд "Иродори" сурах бичгийг JFT-Basic шалгалттай уялдуулан сургалтдаа хэрхэн үр дүнтэй ашиглах тухай зөвлөмжийг өгсөн.	Э.Эрдэнэцэцэг, П.Алтанбулаг, С.Амарбаясгалан, Цүрүта Ясүюки	40
25	“Иродори” сурах бичгийн 1 удаагийн танилцуулах хичээл  *Шинэ сургалт	2023/5/26, 11/9	"Иродори хэрэглээний япон хэл" /Суурь шат А1 түвшин/ сурах бичгийн 3-р хичээлээр дамжуулан сурах бичгийн онцлог, хэрэглэх арга барил, онлайн сургалттай хэрхэн хослуулан хэрэглэх талаарх ойлголтыг өгсөн.	П.Алтанбулаг	33
26	Япон улсад “Тусгай ур чадвартай” ажиллах хүч илгээх тогтолцооны талаарх мэдээлэл солилцох семинар  Зохион байгуулагч: Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Хамтран зохион байгуулагч: Япон сан, ЖАЙКА Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар Дэмжигч байгууллага: Япон Улсын Элчин Сайдын Яам	2023/3/15	“Тусгай ур чадвартай” ажиллах хүч илгээх тогтолцооны хүрээн дэх албан ёсны мэдээллийг эрх бүхий байгууллагуудын төлөөллөөр дамжуулан хүргэснээр тус тогтолцооны талаарх нэгдсэн ойлголтод хүрч, цаашид хамтран ажиллах боломжийг бий болгох. Япон улсад ажиллах хүний нөөцийг бэлтгэж буй ажиллах хүч илгээгч байгууллагууд, япон хэлний сургалтын төвүүдэд нэгдсэн нэг ойлголттойгоор үйл ажиллагаагаа явуулах, үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэх боломжийг олгох.	Зохион байгуулсан: Э.Эрдэнэцэцэг, П.Алтанбулаг, П.Марал, О.Булган, Б.Буманцэцэг	120
27	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө  /"Соёл эрдэм" дээд сургууль болон "Line Bridge" хэлний төвийн япон хэлний багш М.Мөнхцэцэг/	2023/2/8	"Иродори хэрэглээний япон хэл" сурах бичгийн онцлог, хэрэглэх арга, сурах бичгийг ашиглан сургалтын хөтөлбөрийг хэрхэн боловсруулах тухай, Иродори онлайн сургалтын талаар зөвлөгөө өгч ярилцсан.	Цүрүта Ясүюки, О.Булган	1



28	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө  /Gsonkei LLC-ийн дэргэдэх хэлний төвийн захирал Г.Ганболор, япон хэлний багш А.Мягмардорж, Б.Алтанхуяг/	2023/3/27	"Иродори хэрэглээний япон хэл" анхан шат-1, анхан шат-2 сурах бичгүүдийг ашиглан сургалтын хөтөлбөрийг хэрхэн боловсруулах, хэрхэн заах талаар болон бусад нэмэлт сургалтын хэрэглэгдэхүүнийг хэрхэн үр дүнтэй ашиглах талаар зөвлөгөө өгч ярилцсан.	Цүрүта Ясүюки, П.Алтанбулаг	3
29	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө  /Ховд аймгийн Ховд хот дахь "Их Алтайн номч" хэлний төвийн япон хэлний багш М.Оюунчимэг/	2023/11/2	Тус төвөөс зохион байгуулж буй "тусгай ур чадвар"-ын тогтолцоотой холбоотой үйл ажиллагаа, "Иродори хэрэглээний япон хэл" сурах бичиг, Япон сангийн тусламж хөтөлбөрүүдийн талаар танилцуулан, зөвлөгөө өгч ярилцсан.	П.Алтанбулаг	1
30	Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө  /"United Daimon" сургалтын төвийн менежер Р.Сосорбурам/	2023/12/6	Тус төвөөс зохион байгуулж буй "тусгай ур чадвар"-ын тогтолцоотой холбоотой үйл ажиллагаа, "Иродори хэрэглээний япон хэл" сурах бичиг, Япон сангийн тусламж хөтөлбөрүүдийн талаар танилцуулан, зөвлөгөө өгч ярилцсан.	П.Алтанбулаг	1
					1190

**Хүснэгт 14. Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан үйл ажиллагаа**

№	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Агуулга	Илтгэгч болон хариуцсан багш	Оролцогчдын тоо
1	<b>Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 111 дэх удаагийн хурал /Цахим хурал/</b>  /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2023/1/21	Илтгэлийн сэдэв: “Япон дахь гадаадын ур чадварын дадлагажигчдын өнөөгийн байдал - Азийн улс орнуудын ур чадварын дадлагажигчдын жишээн дээр”	Илтгэгч: Yin Moe Thet /Японы Азийн бизнесийн харилцааны нийгэмлэгийн япон хэлний багш/	16
2	<b>Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 112 дахь удаагийн хурал</b>  /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2023/2/11	Илтгэлийн сэдэв: 1) "Үлгэр домгийн хүүрнэл дэх соёлын тэмдэгтийг ойлгох нь - Гэрлэлттэй холбоотой үлгэр домгийн жишээн дээр" 2) "Дүрмийн тестийг боловсруулах тухай"	Илтгэгч: 1) Э.Тогтуун /МУИС-ийн япон хэлний багш/ 2) Б.Ундармаа /ШУТИС-ийн япон хэлний багш/	9
3	<b>Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 113 дахь удаагийн хурал /Цахим хурал/</b>	2023/3/18	Илтгэлийн сэдэв: "Хүүхдийн бие даан суралцах чадварыг хөгжүүлэх хичээлийн загвар"	Илтгэгч: Хонма Шёоко /Чиба их сургуулийн Олон улс судлал	18



	/Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/			тэнхимийн туслах профессор/	
4	<b>Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 114 дэх удаагийн хурал /Танхим болон цахим хосолсон хурал/</b>  /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2023/4/15	Илтгэлийн сэдэв: 1) ""Инженер технологийн дээд боловсрол" төслийн Коосэн сургалтын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний шинэчлэл" 2) "Олон хэл сурах зөвлөмж"	1) Б.Эрдэнэчулуун, Э.Сайнбилэг /ШУТИС-ийн япон хэлний багш/ 2) Цүрүта Ясүюки /Япон сангийн япон хэлний мэргэжилтэн/	18
5	<b>Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 115 дахь удаагийн хурал</b>  /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2023/5/20	Илтгэлийн сэдэв: "Монголын япон хэлний багш нарын холбооны 1 жилийн үйл ажиллагааны тайлан" /2022-2023 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны тайлан, асуулт хариулт/	Илтгэгч: Э.Батжаргал /Монголын япон хэлний багш нарын холбооны тэргүүн/	14
6	<b>Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 116 дахь удаагийн хурал</b>  /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2023/9/23	Илтгэлийн сэдэв: 1) "Японы сангийн хилийн чанад дахь япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалтад хамрагдсан талаарх тайлан" 2) ""Нихонго дэкирүмон" сурах бичгийн шинэчилсэн засварын талаар"	Илтгэгч: 1) Т.Энхпүрэв /"Эрдмийн ундраа" цогцолбор сургуулийн япон хэлний багш/, Ц.Цэцэгмаа /"Наран" сургуулийн япон хэлний багш/, М.Мөнхцэцэг /"Соёл эрдэм" дээд сургуулийн япон хэлний багш/, 2) Наканиши Рэйко /"Монгени" цогцолбор сургуулийн япон хэлний багш/	26
7	<b>Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 117 дахь удаагийн хурал</b>  /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2023/10/21	Илтгэлийн сэдэв: 1) "Япон хэлтэй хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалтыг хэрхэн боловсруулж хэрэгжүүлсэн тухай" 2) "7 дахь удаагийн ханзны наадам"-ын талаарх тайлан	Илтгэгч: 1) О.Булган /Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний багш/ 2) А.Амгалан /"Номт наран" сургуулийн япон хэлний багш/	13



8	<b>Монголын япон хэлний сургалт судалгааны холбооны 118 дахь удаагийн хурал</b>  /Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтарсан үйл ажиллагаа/	2023/12/16	Илтгэлийн сэдэв: 1) "Монгол оюутны япон хэлний байдлын айн хэлбэрийг эзэмших онцлог - Дунд шатны суралцагчдын хэрэглээний дүн шинжилгээний жишээгээр" 2) "Хятад ханзны тухай"	Илтгэгч: 1) О.Хулан /МУИС-ийн төгсөгч/, 2) Күрияма Томоюки /Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний багш/	15
9	<b>Япон хэлний боловсролын 15 дахь удаагийн симпозиум</b>  Зохион байгуулагч: Монголын япон хэлний багш нарын холбоо Хамтран зохион байгуулагч: Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Япон сан Дэмжигч: Япон улсын Элчин Сайдын Яам	2023/11/5	Симпозиумын сэдэв: “Харилцах ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн үгийн санг заах арга” Үндсэн илтгэлийн сэдэв: “Цахим хөмрөгт тулгуурлан үгийн санг заах арга” Workshop: “NLB ба Чүүнагоныг ашиглаж үзэцгээе”	Зочин илтгэгч: Мори Ацүши /Мүкоогава эмэгтэйчүүдийн их сургуулийн профессор/  Симпозиумын зохион байгуулах комисс	63
10	<b>7 дахь удаагийн ханзны наадам</b>  Зохион байгуулагч: Монголын япон хэлний багш нарын холбоо, "Номт наран" сургууль, "Эрдмийн ундраа" цогцолбор сургууль Хамтран зохион байгуулагч: Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, МУБИС, НХУС, Дорно дахины хэлний тэнхим Дэмжигч: Япон улсын Элчин Сайдын Яам	2023/10/14	Япон хэлний сургалт явуулж буй ЕБС-ийн дунд зохион байгуулдаг ханзны наадам бөгөөд сурагчид дунд болон ахлах ангийн сурагчдын ангиллаар багт хуваагдан, хоорондоо мэдлэг чадвараа сорьж уралдсан. Ханзны наадмын агуулга нь "ялгаатай ханзыг олох", "зурлагын тоонд тохирох ханзыг олох", "ханзны талаарх асуулт, хариулт", "Ханзны сүгөрөкү" гэсэн хэсгээс бүтсэн.	Шүүгч: Цүрүта Ясүюки, Күрияма Томоюки Туслах ажилтан: Адачи Юүки	140
11	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 29 дэх удаагийн тэмцээн"-ий 1-р шатны шалгаруулалт /Зохион бичлэг/	2023/10/28	Тэмцээнд оролцохоор зохион бичлэгээ ирүүлсэн ахлах ангийн 23 сурагчаас 16 сурагч, их дээд сургуулийн 17 оюутнаас 14 оюутан зохион бичлэгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн. Зохион бичлэгийн сэдэв: Ахлах ангийн ангилал: "Зүйр үг", оюутны ангилал: "Мөнгө"	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 29 дэх удаагийн тэмцээн"-ий зохион байгуулах комисс	40






12	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 29 дэх удаагийн тэмцээн"-ий 2-р шатны шалгаруулалт /Ярилцлагын шалгалт/	2023/11/4	Зохион бичлэгийн сонгон шалгаруулалтаас тунаж үлдсэн ахлах ангийн 16 сурагч, их дээд сургуулийн 14 оюутнаас ярилцлагын шалгалтыг авч, ахлах ангийн 10 сурагч, их дээд сургуулийн 9 оюутан төгсгөлийн шалгаруулалт болох илтгэлийн тэмцээнд оролцохоор болсон.	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 29 дэх удаагийн тэмцээн"-ий зохион байгуулах комисс	30
13	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 29 дэх удаагийн тэмцээн"-ий өмнөх бэлтгэл	2023/11/18	Тэмцээний өмнөх бэлтгэл	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 29 дэх удаагийн тэмцээн"-ий зохион байгуулах комисс	27
14	<b>"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 29 дэх удаагийн тэмцээн"</b>  /Хамтран зохион байгуулагч: Япон улсын элчин сайдын яам, Монголын япон хэлний багш нарын холбоо, ШУТИС-ийн гадаад хэлний институт, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Япон сан Дэмжигч: Монгол дахь япончуудын холбоо, Монгол Японы худалдааны танхим/	2023/11/19	Зохион бичлэг болон ярилцлагын шалгалтын дүнгээр тунаж үлдсэн ахлах ангийн 10 сурагч, их дээд сургуулийн 9 оюутан илтгэл тавьсан. Илтгэлийн сэдэв: Ахлах ангийн ангилал: "Зүйр үг", Оюутны ангилал: "Мөнгө"	"Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 29 дэх удаагийн тэмцээн"-ий зохион байгуулах комисс	145
574					



**Хүснэгт 15. Япон хэлний сургалтад хамрагдсан суралцагчдын тоо**

	2022 он	2023 он
Хаврын сургалт	161	205
Зуны сургалт	108	120
Намрын сургалт	180	212
Нийт	449	537


*График 4. Япон хэлний сургалтад хамрагдсан суралцагчдын тоо*



**Хүснэгт 16. Тусгай сургалтад хамрагдсан хүний тоо**

	2022 он	2023 он
Тусгай сургалт	1,903	1,190


*График 5. Тусгай сургалтад хамрагдсан суралцагчдын тоо*



**Хүснэгт 17. Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцсон**

	2022 он	2023 он
Хамтарсан үйл ажиллагаа	1,019	574

*График 6. Хамтарсан үйл ажиллагаанд хамрагдсан суралцагчдын тоо*





## II. ОНЦЛОХ МЭДЭЭ

### 1. “Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт” /Шинэ сургалт/

Монгол Улсын засгийн газраас аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарлаж Монгол улсыг зорин ирэх гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллахаа мэдэгдсэн. Ковид-19 цар тахлын нөлөөгөөр аялал жуулчлалын салбарт боловсон хүчний хомсдол үүссэн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан, аяллын хөтөч тайлбарлагч хийхийг хүсэж буй япон хэлний дунд болон ахисан түвшний мэдлэгтэй хүмүүст зориулан “Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт”-ыг 2023 оны 4 сарын 24-нөөс 5 сарын 8-ны хооронд нийт 13 удаа, 33 цагийн сургалтыг шинээр зохион байгууллаа. Сургалтад их дээд сургуулийн оюутан залуус, япон хэлний багш нар, залуу хөтөч тайлбарлагчдаас бүрдсэн нийт 24 суралцагч хамрагдсан юм.



Зураг 20. “Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт”

Сургалтын агуулгыг “танхим”, “дадлага” гэсэн 2 хэсэгт хуваан боловсруулсан бөгөөд танхимын хичээлийг лекц, багаар хамтран ажиллах, хэлэлцүүлэг, илтгэл гэсэн хэлбэрээр явуулав. Дадлага хичээлийг хот болон хөдөө гэсэн хэсэгт хуваан суралцагчид аюулгүй бөгөөд хуваарийн дагуу хөгжилтэйгөөр оролцох тал дээр анхааран зохион байгууллаа. Дадлага хичээлийн хүрээнд Монголын үндэсний музей, Сүхбаатарын талбай, Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, нүүдэлчин айлд зочлох, морь унах үеийн тайлбарыг япон хэлээр хүргэж, монгол, япон багш нараасаа зөвлөгөө авах байдлаар явагдсан юм.



Зураг 21. “Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт”

Сургалтын төгсгөлийн өдөр суралцагчид өөрсдийн сурч мэдсэн зүйлээ аялал жуулчлалын 6 компанийн төлөөлөлд танилцуулсан ба түүний дараа компаниудын төлөөлөлтэй чөлөөт уулзалт хийж ажлын байрны бүртгэл, заавар зөвлөмжийг авсан нь, суралцагчид цаашид сурсан зүйлээ бодитоор хэрэгжүүлэх боломжийг олгосон үр дүн бүхий үйл ажиллагаа болсон юм. Энэхүү чөлөөт уулзалттай холбоотойгоор аяллын



компанийн төлөөллүүдээс “Энэхүү сургалтыг зохион байгуулж байгаад баяртай байгаагаа илэрхийлээд цаашид ч гэсэн тогтмол зохион байгуулахыг хүсэж байна” гэсэн хүсэлтийг хүлээн авсан.

Сургалтын төгсгөлийн өдөр явуулсан санал асуулгад суралцагчид “Олон зүйлийг шинээр сурч, өнөөг хүртэл төдийлөн анзаарч байгаагүй зүйлээ ойлгож авахад тусалсан сайхан боломж байлаа”, “Хөтөч-тайлбарлагчийн ажлын явцад тохиолдох олон янзын үйл явдал, жуулчин зочинтой харилцах харилцааны ур чадвар зэрэг туршлагад үндэслэсэн мэдлэгийг олж авч чадсан”, “Энэхүү сургалтад хамрагдаад хөтөч-тайлбарлагчийн ажлын талаарх үзэл бодол 180 градус өөрчлөгдсөн бөгөөд үнэхээр олон төрлийн мэдлэг, мэдээллийг олж авлаа”, “Хямд үнэтэй төдийгүй маш чанартай сургалтыг зохион байгуулж өгсөнд баярлалаа. Олон мэдлэг, мэдээллийг олж авсан сургалт байлаа” хэмээн сэтгэгдэл өндөртэй төгссөн юм.

Бидний зүгээс суралцагчид энэхүү сургалтаар сурч мэдсэн зүйлээ ажлын талбарт бодитоор ашиглаж чадвал баяртай байх болно. Цаашид энэхүү сургалтаа тогтмол зохион байгуулахаар зорьж буй бөгөөд сургалтын агуулгыг илүү сайжруулж хөгжүүлэн ажиллах болно.

## 2. “Бизнесийн япон хэлний сургалт” /Шинэ сургалт/

Япон хэлний дунд болон ахисан түвшний суралцагчдад зориулсан тэдний япон хэлний бодит хэрэглээний чадварыг дэмжих зорилготойгоор "Бизнесийн япон хэлний сургалт"-ыг 2023 оны 10 сарын 10-наас 12 сарын 21-ний хооронд нийт 11 удаа, 22 цагийн сургалт болгон шинээр зохион байгууллаа. Сургалтад япон компанийн ажилтнууд, япон хэлний багш нар, япон хэлний мэдлэгээ дээшлүүлэх хүсэлтэй хүмүүсээс бүрдсэн нийт 16 суралцагч хамрагдсан юм. Сургалтын агуулгыг “ярих”, “бичих”, “илтгэх” гэсэн 3 хэсэгт хуваан боловсруулсан бөгөөд ярианы хэсэгт хүндэтгэлийн үг хэллэгийн ерөнхий бүтэц, бизнесийн харилцаанд хэрэглэгдэх хүндэтгэлийн үг хэллэгийн талаар, хүндэтгэлийн үг хэллэг ашиглан утсаар хэрхэн зөв ярих талаар, бизнесийн орчин дахь харилцааны ялгаатай байдлын тухай агуулгууд орсон. Бичих хэсэгт бизнесийн харилцаан дахь баримт бичиг болон и-мэйл-ийн ерөнхий бүтэц хэлбэрийг сурахын зэрэгцээ и-мэйл, тайлан зэргийг бодитоор бичиж, багшийн зүгээс засаж өгөх зэргээр илүү практик агуулгатай болгох тал дээр анхааран ажилласан юм. Илтгэх хэсэгт илтгэлийн агуулгыг нэгтгэх ерөнхий бүтцийн талаар ойлголттой болж, илтгэлээ сонсож буй хүнд ойлгомжтой байдлаар хүргэх үндсэн зааварчилгааг өгсөн бөгөөд сургалтын эцсийн үр дүнд болгож төгсгөлийн өдөр суралцагчид сонирхсон сэдвээр илтгэл тавьсан. Мөн энэ хэсэгт Япон зочин багшийн илтгэлийн цагийг оруулсан нь суралцагчдад ихэд таалагдсан юм. Энэ удаагийн сургалтын хувьд суралцагчдын хэрэгцээ шаардлага болон япон хэлний мэдлэг харилцан адилгүй байсан тул бүх суралцагчдын хэрэгцээнд нийцсэн агуулгаар сургалтыг зохион байгуулахад бэрхшээлтэй байлаа. Хичээлийн агуулгаас шалтгаалан зарим суралцагчдад хэцүү санагдсан агуулга байсныг үгүйсгэхгүй. Тиймээс бид цаашид сургалтын агуулгыг илүү сайжруулж, жил бүр зохион байгуулдаг сургалт болгон хөгжүүлэн ажиллах болно.

Сургалтын төгсгөлийн өдөр явуулсан санал асуулгад суралцагчид “Сурсан зүйлээ шууд ажилдаа хэрэглэх талаасаа маш хэрэгтэй сургалт байлаа”, “Өргөн хүрээний



мэдээллийг нэг дор, цэгцтэй, зөв зүйтэй хувилбар аргагүйтэй нь хамт сурч авсан”, “Үнэхээр үр өгөөжтэй сургалт байлаа. Сэтгэл хангалуун байна”, “Маш сайн сургалт байсан. Ажил дээр тулгардаг асуудлуудыг шийдэхэд тусалсан” хэмээн сэтгэгдэл өндөртэй дүгнэсэн юм.

Бидний зүгээс суралцагчид энэхүү сургалтаар сурч мэдсэн зүйлээ ажилдаа ямар нэгэн байдлаар бодитоор ашиглаж чадвал баяртай байх болно.

### **3. “Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”**

Тус төвийн япон хэлний сургалтын тасаг нь жил бүр JDS хөтөлбөрт тэнцсэн төрийн албан хаагчдад зориулан “Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”-ыг зохион байгуулдаг билээ. Энэ жилийн хувьд 4 сарын 4-нөөс 6 сарын 29-ний өдрийг дуустал 3 сарын хугацаанд 100 цагийн сургалтыг амжилттай зохион байгууллаа. Нийт 13 суралцагч хамрагдсан бөгөөд японы их сургуульд 2 жилийн хугацаатай өөрийн сонгосон мэргэжлээр магистрын хөтөлбөрт суралцах юм. Тэдний албан газар, ажил мэргэжлээс дурдваас: Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын референт, Үндэсний Статистикийн Хорооны Бодлого, хамтын ажиллагааны газрын, Хамтын ажиллагаа, тархаалтын хэлтсийн мэргэжилтэн, Улсын Их Хурлын Тамгын газрын Цахим парламент инновацын газрын мэдээлэл технологийн хэлтсийн шинжээч, Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх газрын ахлах мэргэжилтэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын мэргэжилтнүүд байв. Энэ удаа өмнөх жилийн адилаар "Иродори хэрэглээний япон хэл" /A1 түвшний суурь шат/ сурах бичгийг ашигласан. Сурах бичгийн тухайд японд ажиллаж амьдрах зорилготой гадаад хүмүүст зориулсан амьдралд хэрэглэгдэх бодит хэрэглээний япон хэлийг эзэмшүүлэх агуулгатай бөгөөд "Япон хэлээр дамжуулан хийж чадах зүйлс"-ийг нэмэгдүүлэхийг зорьдог. Суралцагчид маань япон хэлний хирагана, катакана цагаан толгойн үсгээс эхлэн, өөрийгөө танилцуулах, гэр бүлээ танилцуулах, өдөр тутмын амьдрал, дуртай болон дургүй зүйл /идэж чаддаггүй зүйл/, сонирхол, гэр болон ажил, хотоор зугаалах, дэлгүүрт худалдан авалт хийх, амралтын өдөр гэх мэт японы өдөр тутмын амьдралын янз бүрийн нөхцөл байдалд хэрэглэгдэх бодит хэрэглээний япон хэлийг сурсан юм. Сургалтын ерөнхий хөтөлбөр өнгөрсөн жилийн адил 3 хичээл тутамд давтлагын цагийг оруулж, сургалтын явцад болон төгсөлтийн өдөр японы соёлтой танилцах хичээлийг зохион байгуулсан. Соёлын хичээлийн хүрээнд “Бийрэн бичлэг” хийсэн бөгөөд суралцагчид анх удаа бийр барин ханз үсэг бичиж, “Анхаарлаа төвлөрүүлэн ханз үсэг бичих үнэхээр гоё байлаа”, “Бийрээр ханз бичвэл илүү сайн цээжилж чадах юм шиг байна” гэх мэт сэтгэгдлүүд үлдээсэн байлаа.

Мөн сургалтын хүрээнд “Япон хүнтэй ярилцъя” японоор харилцан ярих арга хэмжээг 2 удаа зохион байгуулав. Энэхүү арга хэмжээний тухай төгсөлтийн анкет дээр “Хичээл заадаг багшаас өөр япон хүмүүстэй анх удаа ярьж үзлээ. Үнэхээр хөгжилтэй байлаа”, “Сайн ярьдаг болохын тулд илүү хичээх хэрэгтэйгээ ойлголоо” гэсэн сэтгэгдлүүдийг бичсэн байв. Энэ жилийн тухайд сургалт хариуцсан багш нарын багаас хэд хэдэн шинэлэг санаачилгыг хэрэгжүүлэхийг зорилоо. Жишээ нь сурах бичигтэй адил





агуулгатай онлайн сургалтын вэбсайтыг шинэ үг заахад ашиглах, улмаар суралцагч хичээлдээ ирээгүй тохиолдолд вэбсайтыг ашиглан бие даан хийж ирэхийг уриалав. Түүнээс гадна Япон сан болон NHK телевизээс хамтран бүтээсэн “ひきだすにほんご Hikidasu nihongo” веб сайтыг ашиглан японд очоод шууд хэрэглэх боломжтой стратегүүдээс хичээлд нэмэлтээр оруулан туршиж үзлээ.



Зураг 22. “Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”

Суралцагчид маань Японы их дээд сургуульд суралцах нь шийдэгдсэн хүмүүс учраас суралцах дур сонирхол өндөртэй, хичээл заахад урамтай анги хамт олон байсан. Тиймээс ч бүгд идэвхийлэн суралцаж, амжилттай төгсөж чадсан юм. Одоо суралцагчид маань Японы их дээд сургуульд амжилттай суралцаж байгаа бөгөөд төгсөж ирээд сурч мэдсэн зүйлээ ажил мэргэжилдээ хэрэгжүүлэн ажиллана хэмээн найдаж байна.

Бид суралцагчдынхаа япон хэлийг шамдан сурах их үйлсийн анхны суурийг тавьж хувь нэмэр оруулсандаа баяртай байна. Цаашид суралцагчдынхаа япон хэл сурах их үйлсэд болон ажил үйлсэд нь өндөр амжилтыг хүсэн ерөөе.

#### 4. “Кёото их сургуульд элсэн орохын өмнөх япон хэлний бэлтгэл сургалт-2023”

Энэхүү сургалт нь Кёото их сургуулийн олон улсын бакалаврын хөтөлбөр /Kyoto University International Undergraduate Program (Kyoto iUP)/-т тэнцсэн оюутанд зориулан тухайн оюутны хөтөлбөрт тэнцсэн цаг үеэс Японд очиж суралцах хүртэлх хугацаанд явуулж буй япон хэлний бэлтгэл сургалт бөгөөд тухайн суралцагчийн япон хэлний мэдлэгийг 1 түвшнээр ахиулж, бакалаврын хөтөлбөртөө хэлний бэрхшээлгүй суралцаж чадахуйц мэдлэгийг олгох зорилготой сургалт юм. Сургалтыг Кёото их сургуулийн хүсэлтээр энэ жил 4 дэх удаагаа зохион байгуулсан бөгөөд тус их сургуулийн хүсэлтэд нийцүүлэн сургалтын хөтөлбөр, материалыг боловсруулан, 2023 оны 6 сарын 21-ний өдрөөс 8 сарын 23-ны өдрийг дуустал 7 хоногт 3 удаа, 1 удаад 3 цагаар, нийт 75 цагийн сургалтыг амжилттай зохион байгуулав. Сургалтын үндсэн сурах бичгээр "Марүгото Япон хэл ба соёл" /дунд шат-2, B1/, нэмэлт сурах бичгээр "Минна но нихонго" /дунд шат-2/-ыг ашигласан бөгөөд гэрийн даалгавар, бие даалтын ажлыг google classroom ашиглан явуулсан юм. Сургалтад хамрагдсан 1 суралцагчийн хувьд суралцах хүсэл эрмэлзэл өндөр, хичээлийн оролцоо хандлага маш сайн байсны дээр бүхий л даалгавар, дасгал ажлыг хичээнгүйлэн гүйцэтгэж байсан нь үнэхээр сайшаалтай байлаа. Хичээлийн



агуулгыг ойлгон хүлээн авах чадвар болон сурсан зүйлээ хэрэгжүүлэх чадвар өндөр байсан бөгөөд ангид заасан зүйлийг шууд хэрэгжүүлж чаддаг байв. Давтлага, бие даалт болон хичээлийн өмнөх урьдчилсан бэлтгэл зэрэг гэрээр бие даан хийх ажлуудыг цаг тухайд нь идэвх чармайлттай хийж, хугацаанаас нь өмнө идэвхийлэн хийж хураалгадаг байв. Тэрхүү хичээл зүтгэлийн үр дүнд онц сайн дүнтэйгээр амжилттай төгссөн юм.

Харин сургалт эхлэх үеийн суралцагчийн япон хэлний чадвар өндөр байсан ч тэрхүү чадвараа хэрэглээ болгож гаргах туршлага багатай байв. Гэсэн хэдий ч "Марүгото Япон хэл ба соёл" /дунд шат-2, В1/ сурах бичиг ашигласан сургалтаар дамжуулан, хэлний чадвараа бодит хэрэглээ болгох дасгалыг түлхүү ажиллуулснаар, суралцагчийн бодит хэрэглээний стратеги, яриа болон эх бичгийн бүтэц найруулга мэдэгдэхүйц сайжирч, дүрмийн алдаа ч багасаж ирсэн юм. Мөн япон хэлний сургалтын зэрэгцээ, цаашид Япон улсад сурахад нь тус нэмэр болохуйц мэдээ мэдээлэл, тухайлбал Японы оюутны амьдралын талаар, судалгаа шинжилгээний талаар танилцуулах зэргээр нэмэлт мэдээлэл өгч байсан юм. Суралцагчийн хувьд Япон улсад намраас эхлэн суралцах бэлтгэл сургалтад хамрагдан япон хэлний мэдлэгээ улам ахиулж, цаашдын мэргэжлийн боловсрол, эрдэм шинжилгээний ажилдаа томоохон амжилт гаргана хэмээн найдаж байна. Кёото их сургуулийн хүсэлтийн дагуу явуулж буй энэхүү гэрээт сургалтын хувьд бид цаашид ч гэсэн хөтөлбөрт тэнцсэн оюутнуудын япон хэлний түвшинд тохируулсан сургалтын хөтөлбөр, материалыг боловсруулах, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтыг амжилттай зохион байгуулахын төлөө хичээн ажиллах болно.



Зураг 23. “Кёото их сургуульд элсэн орохын өмнөх япон хэлний бэлтгэл сургалт-2023”

## 5. “Тусгай ур чадварын тогтолцоо” гэрээт ажлын хүрээнд

Монгол-Японы төв болон Япон сан нь 2019 оноос эхлэн “Тусгай ур чадвартай ажилтан тогтолцоо”-г сурталчлан таниулах, ялангуяа тус тогтолцоотой хамаарах Монгол дахь япон хэлний боловсролыг дэмжин ажиллахаар гэрээ байгуулан ажиллаж байгаа билээ. Гэрээт ажлын хэрэгжилтийн хүрээнд дараах 3 гол чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

1. Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт /JFT-Basic/-тай хамаарах ажил
2. Япон хэлний багш нарыг дэмжих үйл ажиллагаа
3. Япон хэлний сургалтын төв болон Япон улс руу ажилтан илгээгч байгууллагад



хандсан судалгаа, зөвлөгөө

Нэн тэргүүнд JFT-Basic шалгалтыг олон нийтэд таниулж, шалгалтад хамрагдах болон улмаар түүнд тэнцсэн хүмүүсийн тоог нэмэгдүүлэхийн тулд JFT-Basic шалгалтын хуваарийг тогтмол мэдээлэх зэрэг тус шалгалттай холбоотой мэдээллийг хүргэж ажиллалаа. Үүнд JFT-Basic шалгалтын хүрээнд дараах үйл ажиллагааг явуулав.

### 1. JFT-Basic шалгалтын удирдамж семинар

Монголд явагдаж буй JFT-Basic шалгалтын өмнө тус шалгалтын талаарх удирдамж семинарыг 4 удаа танхимаар зохион байгуулж нийт 94 хүнд мэдээлэл хүргэж ажиллав. Тус семинарт JFT-Basic шалгалт гэж ямар шалгалт болох, шалгалтын бүртгэл, шалгалт өгөх аргачлалыг нарийвчлан тайлбарлахаас гадна жишиг асуултын дагуу дасгал ажиллаж, шалгалтын бэлтгэлд ашиглах сурах бичиг болон “Иродори япон хэлний онлайн курс” платформыг танилцуулав.



Зураг 24. JFT-Basic шалгалтын удирдамж семинар

### 2. “Иродори япон хэлний онлайн курс”-ийн танилцуулах хичээл

JFT-Basic шалгалтад тэнцсэн хүмүүсийн тоо болон тус шалгалтын цар хүрээг тэлэх зорилгоор “Иродори япон хэлний онлайн курс”-ийн танилцуулах хичээлийг 2 удаа зохион байгуулав. Тус хичээлд оролцсоноор компьютер ашиглан онлайн курст бүртгэл үүсгэн бодитоор дасгал ажиллангаа “Иродори: Хэрэглээний япон хэл” сурах бичиг болон онлайн курсийн онцлог болон давуу талыг танин мэдсэн юм. Энэхүү хичээл нь цаашид бие даан суралцахад түлхэц болно хэмээн найдаж байна.



Зураг 25. “Иродори япон хэлний онлайн курс”-ын танилцуулах хичээл

Япон хэлний багш нарыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд Япон сангийн япон хэлний мэргэжилтэн Цүрүта Ясүюкигийн удирдан явуулдаг багш нарт зориулсан заах арга зүйн семинарыг мөн зохион байгууллаа. Япон хэлний багш нарын чадварыг ахиулах зорилготой “Иродори” заах арга зүйн семинарыг 2 удаа танхимаар үнэ төлбөргүй зохион байгуулж, 32 багш оролцлоо. Мөн япон хэлний багш болон суралцагч нарт зориулсан “Иродори” сурах бичгийн нэг удаагийн танилцуулах хичээлийг 2 удаа зохион байгуулав. Улмаар 2 ба 12 сард нийт 2 удаа япон улсад ажиллаж амьдрахыг зорьж буй хүмүүст япон хэлний боловсрол олгодог гадаад хэлний сургалтын төвийн багш нарт зориулж “Иродори” сурах бичгийг ашиглаж буй туршлагаасаа хуваалцах, “Иродори” сурах





бичгийг сургалчлан таниулахад чиглэсэн “Иродори” заах арга зүйн туршлага солилцох семинар зохион байгуулав. Семинарт “Иродори” сурах бичгийн тойм танилцуулга, онцлогийг тайлбарлаж, тус сурах бичгийг сургалтдаа ашиглаж буй 4 байгууллагын япон хэлний багш нар илтгэл тавив. Илтгэгчдэд хандсан асуултаас үзэхэд “Иродори” сурах бичгийг тус тусын зорилгод нийцүүлэн хэрэглэж буй багш нар болон цаашид хэрэглэхээр төлөвлөж буй багш нар олширч байгаа нь тодорхой байв. Түүнчлэн гадаад хэлний сургалтын багш нар төдийгүй их сургуулийн багш нар оролцсон нь япон хэлний багш нар харилцан туршлага солилцох сайхан завшаан болж өгсөн юм. Семинарын илтгэгч, оролцогчдын дунд тус төвийн “Иродори” заах арга зүйн семинар болон Япон сангийн дэмжлэгээр япон улсад зохион байгуулсан семинарт хамрагдсан багш нар оролцож, заах аргын туршлага солилцон, тулгарч буй асуудлаа дэвшүүлэн ярилцсан юм. Энэ нь өнөөг хүртэл япон хэлний багш нарыг дэмжих ажлын хүрээнд хэрэгжиж ирсэн үйл ажиллагаа, ялангуяа “Иродори” заах арга зүйн семинарын үр дүн гэж дүгнэж болохуйц байна.

Эцэст нь япон хэлний сургалтын төв, Япон улс руу ажилтан илгээгч байгууллагад хандсан судалгаа, зөвлөгөөний ажлыг хийв. Монголд үйл ажиллагаа явуулж буй япон хэлний сургалтын төв, Япон улс руу ажилтан илгээгч байгууллагад хандсан судалгааг шинэчилж, япон хэлний боловсролын талаарх зөвлөгөө хүссэн 3 байгууллагад зөвлөх үйлчилгээг үзүүллээ. Япон хэлний боловсролын байгууллагын судалгааны жагсаалт дахь байгууллагуудад тусгай ур чадвартай ажилтан тогтолцоотой хамаарах япон хэлний боловсролын хүрээн дэх үйл ажиллагаа болон Япон сангийн төсөл хөтөлбөрийн дэмжлэгийн талаарх мэдээллийг цаг тухайд нь хүргэж ажиллав. Мөн зөвлөх үйлчилгээ болон бүртгэлтэй байгууллагуудад Япон сангийн төслийн талаарх мэдээлэл хүргэх явцад ковид-19-ийн нөлөөгөөр үйл ажиллагаагаа түр зогсоосон хэд хэдэн байгууллага үйл ажиллагаагаа дахин сэргээж буй талаар мэдэж авлаа. Тус судалгаанд үндэслэн эдгээр байгууллагуудад тулгарч буй асуудлыг мэдэж авсан нь үнэ цэнтэй мэдээлэл болсон юм. 2024 онд ч “Тусгай ур чадвартай ажилтан тогтолцоо”-г сонирхож буй япон хэл суралцагч болон япон хэлний багш нарт зориулж Монгол-Японы төвийн зүгээс хувь нэмрээ оруулахуйц үйл ажиллагаа зохион байгуулж, улам их мэдээлэл түгээх үйл ажиллагааг төлөвлөгөөндөө тусгахыг зорьж байна.



Зураг 26. “Иродори” сурах бичгийн заах арга зүйн сургалт болон туршлага солилцох семинар



### III. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ОНЦЛОХ МЭДЭЭ

#### 1. "ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалт-2023"

“ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалт”-ыг 2022 онд ковид-19 цар тахлын нөлөөгөөр цахимаар зохион байгуулж байсан бол 2023 онд танхимаар зохион байгууллаа. Энэ удаагийн сургалтын хугацааг хөдөө орон нутгаас оролцож буй багш нарын ачааллыг бодолцон хугацааг богиносгож, өдөрт 3 цаг /нийт 4 өдөр, 12 цаг/ болголоо. Тус сургалтад нийт 30 багш хамрагдсан бөгөөд Улаанбаатар хотоос 20 багш, хөдөө орон нутгаас 8 багш, тус төвөөс хүүхдийн сургалт хариуцаж буй 2 багш гэсэн бүрэлдэхүүнтэй байв. Сургалтын бүртгэлийг эхлэхийн өмнө ЕБС-ийн япон хэлний багш нарын “Benkyukai” фейсбүүк группээр дамжуулан сургалтаар юу сурах хүсэлтэй байгааг урьдчилан мэдэх зорилгоор анкет судалгааг явуулж, япон хэлний багш нарын хүсэл сонирхлыг ойлгож авсан юм.



Зураг 27. “ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалт 2023”

Энэ удаагийн сургалт нь “Гадаад хэлний сургалтын хүрээнд явуулж буй япон хэлний сургалт”, “Суралцагчдыг бие даасан суралцагч болгон хөгжүүлэх”, “Японы бага сургуулийн хичээлийн бичлэг үзэх, дүгнэлт хийх”, “Японы дунд сургуулийн хичээлийн бичлэг үзэх, дүгнэлт хийх”, “Ханзны тухай”, “Япон хэлний түвшин тогтоох шалгалтын тухай /JLPT/”, “Япон сангийн хөтөлбөрийн танилцуулга”, “Багаар ярилцах, суралцах”, “Бие даалтын ажил ба эргэн дүгнэх” гэсэн агуулгатай байлаа. Сургалтын явцад оролцогч багш нарын багийн хэлэлцүүлэг хөгжилтэйгөөр явагдаж байв. Сургалт маань 4 хоногийн богинохон хугацаатай байсан ч гэлээ маш үр дүнтэй сургалт болж чадсан нь багш нарын оролцоо болон сургалтын төгсөлтийн анкетаас мэдрэгдсэн. Анкет дээрх сэтгэгдэлд “Энэхүү сургалт маш сайхан байлаа” гэсэн талархлууд их байв. Мөн түүнчлэн “Миний хувьд мэдэхгүй зүйл олон байсан бөгөөд энэ удаагийн сургалтаар ашиглаж болохуйц олон зүйлийг сурч мэдэж чадлаа”, “Японы дунд сургуулийн хичээлийн бичлэг үзээд, хичээлийн дараалал болон ангийн уур амьсгал бүрдүүлэх гэх мэт санаа авуштай олон сайхан зүйлийг олж харлаа. Өөрийн хичээл бэлдэх арга, заах аргаа хэрхэн сайжруулах аргаа оллоо”, “Одоог хүртэл мэдэхгүй байсан зүйлийнхээ тухай маш их мэдлэг олж авч чадсан. Мөн хамтдаа суралцсан багш нарынхаа заах аргаас суралцсан үнэхээр сайхан сургалт боллоо” гэх мэт сэтгэгдлүүд бичигдсэн байсан юм. Энэхүү семинарт хөдөө орон нутгаас нийт 8 багш оролцсон бөгөөд тэдний замын зардал болон зочид буудлын зардлыг Япон сангаас 100% хариуцсан. Үүнийг багш нар талархалтайгаар хүлээн авч “Монголын ерөнхий боловсролын сургуулийн япон хэлний боловсролд үнэтэй хувь





нэмэр оруулж байгаад баяртай байна” хэмээн талархлын сэтгэгдлээ илэрхийлсэн билээ. 2023 он бол ковид-19-ийн дараах хамгийн анхны танхимаар явагдсан сургалт бөгөөд багш нар бие биенийхээ царайг харан, ажлын туршлага, бэрхшээл, хичээл зүтгэлийг мэдрэн, хамтдаа суралцсан нь үнэхээрийн баярлууштай үйл явдал болов. Цаашид ч гэсэн иймэрхүү маягийн оролцогч хоорондоо харилцан ярилцах боломжтой орчныг бүрдүүлж, улмаар харилцан бие биенийхээ заах аргын сайжруулалт зэргийг бодитоор үзэж болохуйц сургалтыг зохион байгуулах юм сан хэмээн хүсэж байна.

## 2. “15 дахь удаагийн япон хэлний боловсролын симпозиум”

2023 оны 11 сарын 5-ны Ням гарагт “15 дахь удаагийн япон хэлний боловсролын симпозиум” зохион байгуулагдлаа. Ерөнхий зохион байгуулагчаар Монголын япон хэлний багш нарын холбоо, хамтран зохион байгуулагчаар Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв болон Япон сан, дэмжигч байгууллагаар Монгол улс дахь Япон Улсын Элчин Сайдын Яам ажиллалаа. Симпозиумын сэдэв нь “Харилцах ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн үгийн санг заах арга” бөгөөд Мүкоогава эмэгтэйчүүдийн их сургуулийн профессор Мори Ацүши багш “Цахим хөмрөгт тулгуурлан үгийн санг заах арга” гэсэн сэдэвтэй үндсэн лекцийг уншиж, үргэлжлүүлэн “NLB ба Чүүнагоныг ашиглаж үзэцгээе” сэдвийн хүрээнд семинар зохион байгуулсан. Симпозиумд оролцогчдоос “Үгийн санг зөв ашиглаж, суралцагчдад ойлгомжтой жишээ өгүүлбэр, үг хэллэгээр заах нь хэчнээн чухал болохыг ойлголоо”, “Лекцийн сэдэв маш сонирхолтой, утга учиртай байлаа”, “Мори Ацүши багш маш чадварлаг бөгөөд ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарласан тул түүний ярианы чадвар гайхалтай сайн санагдсан” мөн “Япон хэлний судалгааны өнөөгийн байдал, үр дүнг танилцуулж, бодитоор ашиглах боломжтой симпозиум зохион байгуулж өгсөнд маш их баярлалаа. Цаашид ч ийм симпозиум зохион байгуулна гэж найдаж байна” гэх мэт олон эерэг сэтгэгдлүүд ирсэн байна.



Зураг 28. “15 дахь удаагийн япон хэлний боловсролын симпозиум”



### 3. “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 29 дэх удаагийн тэмцээн”

2023 оны 11 сарын 19-ний Ням гарагт “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 29 дэх удаагийн тэмцээн” амжилттай зохион байгуулагдлаа.

Хамтран зохион байгуулагч: Монгол дахь Япон Улсын Элчин Сайдын Яам  
Монголын япон хэлний багш нарын холбоо  
Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв  
ШУТИС Гадаад хэлний сургууль, Япон сан

Дэмжигч байгууллага: Монгол дахь Япончуудын холбоо ТББ  
Монгол Японы худалдааны танхим ТББ

Тэмцээнд “Ахлах ангийн сурагч” ангилалд 10 сурагч, “Их, дээд сургуулийн оюутан” ангилалд 9 оюутан оролцов. “Ахлах ангийн сурагч” ангиллын сурагчид “ことわざ” буюу “Зүйр үг” гэсэн сэдвээр, “Их, дээд сургуулийн оюутан” ангиллын оролцогчид “お金” буюу “Мөнгө” гэсэн сэдвийн дагуу тус бүр илтгэлээ тавилаа.

Ангилал тус бүрээс 4 оролцогч шагналт байранд шалгарсан бөгөөд энэ жилийн хувьд эхний байранд шалгарсан бүх оролцогчид Монгол дахь Япон Улсын Элчин сайдын яамнаас “JENESYS” буюу Япон орны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх солилцооны хөтөлбөрт хамрагдах эрхээр шагнагдлаа. Анкет судалгаанаас үзэхэд, оролцогчид “Япон хэл сураад 1 жил 6 сар болж байна. Ингээд уран илтгэлийн тэмцээнд орсон нь миний япон хэл сайжрахад маш их нөлөөллөө”, “Монголд япон хэлийг сонирхдог олон хүн байдгийг мэдсэн” зэрэг сэтгэгдлүүд бичсэн байв. Мөн хамтран зохион байгуулагчдын зүгээс “Зүйр үгийн тухай өөрийн бодлоо илэрхийлнэ гэдэг үнэхээрийн гайхалтай”, “Оюутнууд ахлах ангийн сурагчдаас илүү өргөн цар хүрээний өнцгөөс тус бүрийн онцлогийг гаргасан илтгэл тавьсан нь үнэхээр сайн байлаа” гэх зэрэг сэтгэгдлүүдийг үлдээсэн байлаа.



Зураг 29. “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 29 дэх удаагийн тэмцээн”





## IV. СУРАЛЦАГЧДЫН ДУУ ХООЛОЙ

### Сургалтын талаарх сэтгэгдэл

Сайн байна уу? Намайг Б.Энх-Оюун гэдэг. Би зуны амралтаараа хүүхдэд зориулсан япон хэлний сургалтад япон хэл сурахын тулд хамрагдсан. Хамгийн гоё байсан нь хичээлийг хөгжилтэй аргаар заасан нь гоё байсан. Тоглонгоо, дуу сурангаа япон үсэг уншиж чаддаг болсондоо баяртай байгаа. 2 япон дуу сурсан, хирагана үсэг үзсэн, японы соёлоос суралцсан. Одоо би гадуур явж байхдаа япон бичиг тааралдахаар уншдаг болсон, тэгэхээр аав ээж 2 их баярладаг, аав бүр алга ташдаг. Би том болохоороо япон хэлний гүнзгийрүүлсэн сургалтад сууна гэж бодож байгаа.



Зураг 30. “8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалт”  
Суралцагч Б.Энх-Оюун

**“8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний сургалт”**

**Суралцагч Б.Энх-Оюун**

\*\*\*\*\*

Сайн байцгаана уу?

Охиноо япон соёлтой танилцаж, япон хэлний үсэг уншиж бичиж чаддаг болохоос гадна сургуулиасаа өөр орчинд суралцаж шинэ зүйл мэдэрч, сураасай гэж бодсон учраас энэ сургалтыг сонгож суралцуулсан юм. Зуны амралтын хугацаагаа ашиглаад Япон хэлээр уншиж бичиж чаддаг болсондоо охин маань их баяртай байгаа, бас дараагийн шатандаа суралцахыг тэсэн ядан хүлээж байгаа. Манай гэр бүлийн хувьд хүүхдийнхээ энэ суралцах хүсэл эрмэлзлийг нь аль болох дэмжихийг хичээдэг.

Сургалтын хувьд хүүхдийг уйдааж залхаахгүй хөгжилтэй аргаар явагдсан нь их үр дүнтэй гэж бодож байна. Аливаа зүйлийг хүчээр биш, өөртөө хөгжилтэй хөнгөн аргаар суралцаж болдог гэдгийг охин маань ойлгож авсан байх аа.

**Суралцагчийн аав О.Баярхүү**

### Сургалтын талаарх сэтгэгдэл

Намайг Т.Сүндарь гэдэг. Миний өвөө Япон улсын Кэйо их сургуулийг төгсөж, хэсэг хугацаанд гэр бүлээрээ амьдарч байсан тухай маш хөгжилтэй дурсамжуудыг бас Япон орны хөгжлийн тухай гоё гоё зүйлсийг ярьж өгдөг байсан. Мөн одоо ч миний авга эгч, үеэлүүд маань тэнд амьдардаг. Тиймээс би япон орноор аялж, өвөөгийнхөө ярьж байсан тэр гоё зүйлүүдийг харах бас өвөөгийнхөө суралцаж байсан сургуульд сурч өвөө шигээ мундаг боловсролтой хүн болохыг хүсдэг. Япон хэл сурах нь миний хүсэл болохоор анх би бие даан суралцахыг оролдсон ч нэг л болж өгөхгүй байсан. Харин Монгол-Японы төв нь сургуультай маань ойрхон гэдгийг мэдсэнээр энэ төвд суралцахаар шийдсэн. Би манга цуврал болон анимэ-д дуртай. Тийм болохоор анх Монгол-Японы төвөөр үйлчлүүлэхэд номын сан нь маш их таалагдсан. Хичээлүүдээс



Зураг 31. “Хүүхдэд зориулсан маругото япон хэлний анхан шатны сургалт” Суралцагч Т.Сүндарь



маань япон соёлын танилцуулах хичээл үнэхээр сонирхолтой байсан. Шалгалт өгөөд сайн оноо авахад хөөрхөн бэлэг өгдөг нь урам өгдөг. Монгол-Японы төвийн багш нартаа миний хүсэл, мөрөөдлийг биелүүлэхэд тус болсонд баярлалаа.

Хичээж, хариуцлагатай суралцсаны үр дүнд ангидаа тэргүүний сурагчаар шалгарсан. Сургалтаа амжилттай төгсөж сертификатаа гардан авсан мөчийг би хэзээ ч мартаггүй. Мөн дараачийн шатанд явах боломжтой болсон болохоор маш их баяртай байгаа.

**“Хүүхдэд зориулсан маругото япон хэлний анхан шатны сургалт”**  
Суралцагч Т.Сүндарь

### Сургалтын талаарх сэтгэгдэл

Сайн байна уу? Би 7 сарын 19-ний өдрөөс анх Монгол-Японы төвд япон хэл сурахаар болсон. Тэгээд зуны түргэвчилсэн ангид амжилттай суралцаж төгссөн. Багш нарын зааж буй ур чадвар маш сайн байсан. Ойлгоход хялбар аргаар хурдан шуурхай системээр явж байгаа нь таалагдсан. Багш нар бүх хүүхдийн оролцоог чухалчилдаг, өдөр бүр гэрийн даалгавар өгдөг, заасан зүйлээ давтдаг нь намайг илүү сайн сурахад их нөлөө үзүүлсэн гэж бодож байна. Тэгээд Монгол-Японы төв болон бүх багш нартаа баярлалаа гэж хэлмээр байна. Сурах орчин маш тухтай гоё байсан.



Зураг 32. “Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт”  
Суралцагч Б.Солонго

**“Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт”**  
Суралцагч Б.Солонго

### Сургалтын талаарх сэтгэгдэл

Юуны өмнө Монгол-Японы төвд япон хэл сурахаар шийдсэн минь миний гаргасан хамгийн сайн шийдэл байсан гэж бодож байна. Анх япон хэлийг сурах зорилго минь тийм ч том байгаагүй учраас их хөнгөн хуумгай эхлүүлж байлаа. Харин сургалтад сууж эхэлсэн мөчөөс багш нарынхаа хичээнгүй зан чанарыг хараад, мөн ангийн нөхдийнхөө тууштай байдалд дасан өөрөө ч мөн адил хичээж эхэлсэн. Сургалтад суух хугацаанд can-do бөглөж, бяцхан ном хөтлөн юу юунаас илүү олон төрлийн жижиг өрсөлдөөн ойр ойрхон болж байсан учраас тэр хэмжээнд өөрийгөө дайчилсаар байсан юм. Энэ хугацаандаа яг юуг ойлгож авсан бэ гэвэл сурагчийн хичээл зүтгэл 1-т байдаг юм билээ. Багш нарын минь заах арга барил хэн ч өөлж чадахааргүй сайн. Гэхдээ би өөрөө ингэж хичээгээгүй бол, өөрөө ингэглээ тууштай байгаагүй бол үнэхээр сурч чадах байсан уу гэх асуулт намайг ийнхүү бодоход хүргэсэн юм. Эцэст нь гэхэд япон хэл сурах тусам япон явах зорилго минь, бодит байдлаас хол тасарсан мөрөөдөл бус төсөөлөлд буухаар санагдаж байна.



Зураг 33. “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1”  
Суралцагч А.Мичид

**“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1”** Суралцагч А.Мичид



## “Японы нийгэм, соёлын талаар илүү гүнзгий мэдлэгтэй боллоо”

Миний бие Монгол-Японы төвийн 2023 оны намрын япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц 2 түвшний сургалтад хамрагдсан бөгөөд япон хэлний мэдлэг нэмэгдсэн, зөв системтэйгээр суралцах талаар болон япон орны нийгэм, соёлын талаар олон зүйлийг сурч мэдсэн, үр өгөөжтэй сургалт байлаа.

JF стандартад тулгуурласан гарын авлага ашиглан “Сонсох, ярих, унших, бичих” чадваруудыг цогцоор нь заан, агуулгад тохирсон гэрийн даалгавар хийлгэн, мэдлэгээ бататгах жижиг тестүүд тухай бүр авдаг нь бусад сургалтаас илүү давуу талтай санагдсан. Мөн японы нийгэм, соёлын тухай суралцагчид баг багаараа илтгэл тавьж, японы соёлын талаар тусгайлан цаг гаргаж хичээл орсон нь япон хэлээр дамжуулан японы нийгэм, соёлын талаар илүү гүнзгий мэдлэг олгосон. О.Булган, Сато Кэийчи, П.Алтанбулаг багш нартаа япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц 2 түвшний бүхий л хичээлийг мэдлэг, ур чадвараа зориулан чин сэтгэлээсээ зааж сургасанд маш их баярлалаа. Түүнчлэн Монгол-Японы төвийн зүгээс суралцагч нарынхаа сургалтын тоног төхөөрөмж, хэрэгсэлд байнга санаа тавьж, цэвэр, аюулгүй орчинд сурах нөхцлөөр хангаж ажилласанд баярлалаа. Цаашдын ажил үйлсэд нь өндөр амжилт хүсье.



Зураг 34. “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2”  
Суралцагч Л.Оюун-Эрдэнэ

*“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2” Суралцагч Л.Оюун-Эрдэнэ*

## Сургалтын талаарх сэтгэгдэл

Намайг Б.Пүрэвдолгор гэдэг. Интерьер дизайны 3-р курсийн оюутан. Ахлах ангиасаа эхлээд Япон улс болон хэл соёлтой танилцаж, сонирхсоор ирсэн.

2023 оны намар Монгол-Японы төв дэх “Марүгото” сурах бичиг ашигласан “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3”-д хамрагдах хүртлээ бие даан судалж ирсэн. Тус сургалтад элссэнээр танхимаар суралцахын давуу тал, сургалтын онцлог, заах аргазүй зэрэг олон таалагдсан зүйл байсан бөгөөд тэдгээрээс дурдвал:

- Япон хэлийг тухайн орны түүх соёл, ёс суртахуун, зан заншил зэргээр дамжуулан анхлан суралцагчдад тохиромжтойгоор эзэмшүүлэх сурах бичгийн агуулгатай.
- Бодит амьдрал дээр өргөн ашиглагдах сэдвийн хүрээнд өдөр тутмын хэллэг хийгээд харилцан яриа болон сонсголын дасгалуудтай.
- Сургалт нь зөвхөн багш, суралцагч гэлтгүй суралцагчид хоорондоо сурсан мэдлэгээ ашиглан харилцан ярилцах боломж олгодог тул илүү үр дүнтэй.
- Суралцагчид хичээл бүрд өөрийгөө үнэлэн, явцаа шалгах нь хувь хүний бие даах чадварт эергээр нөлөөлдөг.
- Сурах бичгээс гадна амжилттай сурахад тус нэмэр болох унших, бичих материалуудаар баялаг.
- Суралцагчийг урамшуулан, ангийн уур амьсгал зэргийг дэмжих олон үйл ажиллагаатай.






- Ажил, хичээлийн хажуугаар суралцах боломжтой аажуу сургалттай.

Ийнхүү Монгол-Японы төвийн чадварлаг багш нартай “Марүгото” сургалтад хамрагдсандаа туйлын баяртай байна. Хэн бүхэнд нээлттэй энэхүү сургалтыг сонирхоод үзээрэй хэмээн хүсье.

*“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3” Суралцагч Б.Пүрэвдолгор*

### “Хэзээ нэг өдөр хэл нэмж сурна даа...”

Хамгийн хэцүү алхам, анхны алхам байдгийг мэдэх үү? Миний хүрээлэл дунд “Ямар нэгэн хэл сурмаар байна”, “Хэлээ сэргээж хармаар байна”, “Нэг л өдөр шинэ хэл сурна даа...” гэж хэлдэг хүмүүс цөөнгүй бий. 2022 оны хавар “Цогц сургалт-1”-дээ орохоос өмнө би ч мөн адил хүсэл мөрөөдлийнхөө урагш ямар нэгэн алхам хийлгүй, дотроо бодохоос цаашгүй байлаа. Тухайн үед ковид-19 цар тахал хүний амьдрал хэчнээн богино, хэчнээн хэврэг байж болохыг хатуу мэдрүүлсэн үе байсан учраас ч тэр үү, өөрт байгаа ганц амьдралдаа хүссэн зүйлээ биелүүлэхгүй өнгөрөөх нь хэчнээн харамсалтай гэж бодон анх япон хэл сурч эхэлсэн билээ.



*Зураг 35. “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-4” Суралцагч Г.Танан*

Монгол-Японы төвийн хашаа руу орох үед Монгол ард үлдэж, Япон угтаж байгаа мэт. Би өмнө нь Монгол-Японы төвийн номын сангаар тогтмол үйлчлүүлдэг байсан үе бий болохоор япон хэл сурахад хамгийн тохиромжтой сонголт нь зөвхөн энэ газар гэсэн итгэлтэйгээр суралцаж эхлээд өнөөдөр “Цогц сургалт-4”-өө төгсөөд “5”-даа орох цаг аль хэдийн болжээ. Энд бусад газар шиг гараа бадайртал ханз, кана бичиж, эхийг өгүүлбэр өгүүлбэрээр цээжлэхгүй. Ямар нэгэн зүйл хэтэрхий хэцүү бол хүн шантран, бууж өгөх нь гарцаагүй. Тиймээс ч олон жилийн туршлагатай, мэргэжлийн япон багш нар анхлан суралцагч болох бид бүхэнд тусгайлан “Марүгото” хөтөлбөрийг боловсруулсан нь энэхүү асуудлыг тойрон гарч чадсан юм шиг санагддаг. Учир нь мартагдаад алга болох бус, надтай хамт үлдэх бодит мэдлэгийг нэг л мэдэхэд олж авсан байдаг.

Би Японы утга зохиолд их сонирхолтой учраас маш олон хэл дундаас япон хэлийг сонгосон нь хэзээ нэгэн өдөр япон хэл дээр заавал ном уншдаг болно гэсэн хүслээс болсон хэрэг. Өнөөдөр өдөр тутмын амьдралдаа янз бүрийн япон вэбсайт, тоглоом, Youtube, Instagram, Tiktok зэрэг аппликэйшнүүдийн “japanese side” буюу япон хэсэгт нь хүмүүсийн сэтгэгдэл уншиж, бичиж чадаж байгааг бодохоор зорилгодоо улам ойртож байгаагаа ухаарч өөрийн эрхгүй баярладаг. Гэхдээ мэдээж хэрэг миний туулах зам одоогоор маш хол. Миний хувьд “Цогц сургалт-6”-аас цааш шат одоогоор байхгүй нь харамсмаар. Хэдий тийм ч Монгол-Японы төвийн маань сургалтууд дууссан ч гэсэн өнөөдөр би үргэлжлүүлэн бие даан суралцах бүрэн чадвартай болсон. Энэ бол манай найрсаг, халуун дотно, хамгийн гол нь шаардлага тавьж чаддаг, мэдлэг чадвараа дайчилж, сэтгэлээсээ ажилладаг багш нарын маань ач болон бидний суралцах орчин, халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэхээр ажилладаг Монгол-Японы төвийн ажилчин



бүрийн хувь нэмэр юм. Та бүхэндээ баярлалаа. Ирээдүйд эргэж ирэх боломж болгоныг тэсэн ядан хүлээж байна!

**“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-4” Суралцагч Г.Танан**

### **Сургалтын талаарх сэтгэгдэл**

Сайн байна уу? Намайг Мөнхгэрэл гэдэг. Би 4 жилийн өмнө япон хэл сурахаар шийдээд интернэтээс төрөл бүрийн мэдээлэл хайж үзэж, бие даан сурч эхэлсэн. Заавал зардал гаргахгүй, өөрөө сурчихна гээд л хичээсэн.

Харин дараа нь түвшнийг тодорхойлох хэрэгтэйгээ мэдээд JLPT шалгалтад бэлдэж, жишиг материал ажиллаж эхэлсэн. Оюутан болоод хичээл ихтэй болсон чинь япон хэлээ бэлдэхээ болиод тууштай сурахаа бүр л больчихсон. Өвлийн болон зуны амралтаараа бэлдэнэ гэсэн зорилго тавьчхаад л залхуурчихдаг. Бас яг яаж бэлдэхээ мэдэхгүй үе ч байдаг.

Харин энэ намар Монгол-Японы төвийн сургалтын талаар мэдсэн бөгөөд төлбөр нь тун боломжийн тул яваад үзэхээр шийдсэн. Энэ сургалтаар түвшин тогтоох шалгалтад бэлтгэх бус, бодитоор хэрэглэхэд зориулсан олон зүйл заадаг нь их таалагдсан. Би япон хоол, японы баярууд, хот гудамж гээд очно гэж бодож буй орныхоо талаар мэддэггүй байсан тул надад их хэрэг болсон.

Хамгийн гол нь харилцан яриаг сонсож ойлгох, өөрөө ярих дасгалууд байсан бөгөөд харилцан яриаг цааш үргэлжлүүлэхийн тулд сайн бодох хэрэгтэй болсон. Бичгийн шалгалтад бэлдэж оноо авахаараа өөрийгөө мундаг болчихлоо гэж боддог ч үнэн хэрэгтэй япон хүнтэй сайн ярьж чаддаггүй. Тиймээс энэ сургалт надад бүхий л чадвараа дээшлүүлэх хэрэгтэйг ойлгуулж цаашид суралцах ёстой зүйлийг минь чиглүүлж өгсөн.


**“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5” Суралцагч: М.Мөнхгэрэл**

### **Сургалтын талаарх сэтгэгдэл**

Конничива. Намайг Цэрэндолгор гэдэг. Эрх зүйч, Япон хэлний харилцаа мэргэжилтэй. Монголдоо их сургуулиа төгсөөд япон хэлний сургуулийн зуучлалын төвд бүртгүүлж байхдаа “Минна но нихонго” сурах бичгээр япон хэлийг анх сурч эхэлж байсан. Удалгүй Япон улсад хэлний сургууль, коллеж, их сургуулийн эхэн үе хүртэл суралцсан.

Монголдоо суурин ирээд эрх зүйч мэргэжлээрээ олон жил ажиллаж байгаа ч нэг ч гэсэн хүүхдэд япон улсад сурч мэдсэнээ хүргэх зорилгоор боловсролын салбарт ажиллахын тулд япон хэлний заах аргын сургалтыг зорьсон билээ. Сургалтыг анх өөрийн гадаад хэл сурч байх цаг үеийн багшийн арга барил, сурах бичиг гэж төсөөлж байснаас тэс өөр болохыг мэдэрч шимтэн суралцлаа.

Сургалтаар Монгол-Японы төвийн туршлагатай япон багш нараар гадаад хэл заах арга зүй, хоёрдогч хэл эзэмших онол, JF стандарт, гадаад хэлний сургалтын хөтөлбөр, “Марүгото” болон “Иродори” сурах бичгийн заах арга, бэлтгэл арга, тэдгээртэй



*Зураг 36. “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5”  
Суралцагч М.Мөнхгэрэл*



*Зураг 37. “Япон хэлний заах аргын сургалт”  
Б.Цэрэндолгор*



холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хэрхэн авах талаар сурч мэдэж авлаа. Мөн түүнчлэн JF стандартын дагуу боловсруулсан “Марүгото”, “Иродори” сурах бичгийн дадлага хичээлийг баг болон бэлдэж, заах аргын дадлага хийж, алдаа оноогоо дүгнүүлсэн нь маш том туршлага боллоо.

Эцэст нь дүгнэхэд гадаад хэлийг сурах нь цаг үе нийгмээ дагаад илүү ойлгомжтой, сонирхолтой, мөн түүнчлэн бодит болж байгаа юм байна. Япон хэлний боловсролын стандарт ч гэсэн түүнийг дагаад илүү боловсронгуй болсныг өөрийн биеэр мэдэрч суралцлаа. Миний хувьд “Иродори” сурах бичиг нь илүү олдоц сайтай, танхимаас онлайн хэлбэрт шилжихэд ч гэсэн төвөггүй санагдсан учраас цаашид энэхүү сурах бичигт суралцаж, энэхүү арга барилаараа япон хэл сонирхож буй хүүхэд багачуудын хүслийг илүү тод гэрэлтүүлэхэд нь Япон улсад талархаж явдгаа илэрхийлэх арга гэдэгт итгэлтэй болсон. Энэхүү сургалтыг жил болгон зохион байгуулдаг Монгол-Японы төвийн хамт олон болон Япон багш нартаа талархсанаа илэрхийлье.

*“Япон хэлний заах аргын сургалт” Б.Цэрэндолгор*

### Сургалтын талаарх сэтгэгдэл

Намайг Дорждамбын Баасандорж гэдэг. Миний бие 2022 оны JDS хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад тэнцэж, 2023 оны 4-6 сар хүртэл Монгол-Японы төвийн 3 сарын япон хэлний бэлтгэл сургалтад хамрагдах боломж олдсон юм. Анх удаа хирагана, катакана үсгүүдийг Д.Мөнхтуяа, Д.Золзаяа, П.Алтанбулаг, Сато Кэйичи багш нараар заалгаж, япон хэлний сууриа амжилттай тавьсандаа баяртай байна.

Бид 13-уулаа энэхүү сургалтад хамрагдсан бөгөөд тус төвийн чадварлаг, найрсаг багш нараас япон орны талаар, ялангуяа япончуудын соёл, албан болон албан бус харилцааны талаар их зүйлийг сурч мэдсэн.

Энэхүү сургалт нь япон сургалтын хэв маягаар “Can-do”, “Shadowing”, “Жижиг тест” гэх мэт сонирхолтой байдлаар явагдсан бөгөөд сургалтын явцад биднийг япон хүмүүстэй уулзуулж, ярилцах боломжоор хангаж байсан нь сайхан санагдсан. Мөн “Ханзаар хэн хамгийн гоё сайхан бичих вэ?” гэдэг тэмцээн их сонирхолтой байсан. Манай ангийн ОБЕГ-ын ахмад Д.Отгонболд маань “Аав, ээж” гэсэн ханзыг гайхалтай гоё бичиж, түрүүлж байсан нь сэтгэлд тод санагдаж байна. Цаашид япон оронд суралцах олон олон залуусын амьдралд энэ сургалт чухал нөлөө үзүүлсээр байх болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Энэхүү сургалтаас олж авсан зарим арга барилаа ажлын байран дээр ашиглах боломжтойг ч миний бие олж харсан. Тухайлбал, цагийн юм цагтаа, япончуудын онцгой баримталдаг “Цаг барих соёл”, хичээлд биечлэн суугаагүй бол ирцэд ямар ч шалтгаан нөлөөгүй зэрэг нь хатуу юм шиг атлаа маш чухал санагдаж байсан. Мөн “Иродори” сурах бичгийг онлайн болон хэвлэмэл хосолсон хэлбэрээр ашиглаад явах нь маш их өгөөжтэй байсан.



*Зураг 38. Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт"-ын суралцагч Д.Баасандорж*



Миний бие Японы Олон Улсын Их Сургуульд япон хэлний хичээлийг сонгон үргэлжлүүлэн суралцаж байгаа.

Ингээд нийт эрдэмтэн багш нартаа маш их баярлалаа гэж хэлмээр байна. Та бүгдийн ажилд өндрөөс өндөр амжилт хүсье.

*“Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”-ын суралцагч, Японы Олон Улсын Их Сургуулийн оюутан Д.Баасандорж*

### Сургалтын талаарх сэтгэгдэл

Сайн байна уу? Намайг Анударь гэдэг. МУИС-ийн төгсөгч, япон хэлний орчуулагч судлаач мэргэжилтэй. Одоо мэргэжлээрээ монголдоо ажиллаж байгаа. Гадаад хэлний багш гэлтгүй багш хүн бол насан туршдаа суралцах ёстой гэдгийг байнга ухамсарлаж явдаг. Иймээс Монгол-Японы төвөөс зохион байгуулдаг сургалт семинарт тасралтгүй суух юм сан гэж байнга мэдээ мэдээлэл, зарлалыг нь хүлээдэг болсон. Ингээд хүсэн хүлээсэн “Бизнесийн япон хэлний сургалт” зарлагдаж хамгийн түрүүнд бүртгүүлсэн.

Энэхүү сургалт нь ажил мэргэжлийн хүрээнд япон хэл ашигладаг хүмүүст маш үр өгөөжтэй, бодит мэдлэг болоод дадлага олгосон үр дүнтэй сургалт болсон гэж бодож байна. Монголд үйл ажиллагаа явуулдаг япон улстай холбоо хамаарал бүхий олон байгууллагын хүмүүстэй нэг ангид суралцаж, харилцан биеэсээ олон зүйлийг сурсандаа баяртай байгаа.

Сургалтын онцлогоос дурдвал:

- Богино хугацааны сургалт байсан боловч 11 удаа буюу 22 цагийн сургалтаар товч, цэгцтэй мэдлэгийг авч чадсан.
- Монгол, Япон багш ээлжлэн хичээлээ заасан.
- Ажлын бус цагаар хичээллэсэн учраас ажлаа орхигдуулах асуудал гараагүй.
- Сургалтын дундуур зочин багшийн илтгэлийг сонсох боломж олгосон гэх мэт олон давуу тал байсан.

Бизнес болон ажлын хүрээнд япон хэл ашигладаг танилууд, найз нөхдөө дараагийн ээлжийн сургалтад заавал суугаарай гэж зөвлөх болно.

Эцэст нь япон маягийн үйл ажиллагаа, сургалт, мэдээлэл авах боломжийг олгодог тус төвийн багш, ажилчид, нийт хамт олонд баярласан талархсанаа илэрхийлье.

*“Бизнесийн япон хэлний сургалт” Суралцагч У.Анударь*



Зураг 39. “Бизнесийн япон хэлний сургалт” Суралцагч У.Анударь





## Сургалтын талаарх сэтгэгдэл

Юуны өмнө хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалтыг зохион байгуулсан Монгол-Японы төвийн хамт олонд талархаж буйгаа илэрхийлье. Энэхүү сургалт миний хувьд нэгэн том өөрчлөлтийг авчирсан юм. Эх орондоо ирээд япон хэлээ ашиглахгүй удаад мартах вий гээд айж байсан надад цагаа олсон, яг тохирсон сургалт байсан. Сургалтдаа сууж эхлээд л аялал жуулчлал гэдэг салбарт эргэлт буцалтгүй орохоор шийдсэн. Тиймдээ ч сургалтаа төгсөөд шууд ажлын байртай болсондоо баяртай байна. Монголынхоо түүх, соёлыг илүү дэлгэрэнгүй суралцаж, түүнийгээ гаднаас ирэх жуулчин зочинд хэрхэн тайлбарлаж, оновчтой бөгөөд зөвөөр, ээргээр хүргэхээс гадна өөр бусад олон талын мэдлэгтэй байх нь ямар чухал болохыг суралцсан, үр өгөөжтэй 14 хоног байсан. Нас үл харгалзан өөрсдийн мэдлэгээ бусадтай хуваалцаж, бусдаасаа суралцах тэмүүлэлтэй 24 хүн, багш нарынхаа ачаар нэг баг болон амжилттай суралцаж чадсан гэж боддог.

Япон улсад суралцаж, ажиллаж амьдарч байхдаа ч ашиглаж байгаагүй япон хэлээ Монголдоо ирээд ашиглаад, илүү их суралцаад явж байна. Хэлийг бол сурч дуусдаггүй юм шиг санагдаад байгаа. Учир нь хөтөч хүний хувьд зөвхөн түүх соёл, зан заншил яриад явах биш аялагчдынхаа аюулгүй байдал, аяллын явцад анхаарах зүйлс, аялах газрууд руугаа явах зам, алхах гишгэх газар, тэр ч бүү хэл идэх хоол, уух ус, бие засах газрыг нь хөтөч хийж тайлбарладаг учир байнгын судалсаар, суралцсаар явдаг. Аяллын явцад мэдэхгүй, чадахгүй зүйлс тохиолдоход хэцүү, уйлмаар санагдах үеүд байдаг ч дуртай юмандаа хүчтэй гэдэг шиг шантралгүй, хичээгээд ажиллахыг зорилгоо болгосон. Эцэст нь хэлэхэд үргэлж шинийг таниулж, судлуулж, адал явдалтай учруулдаг ажилдаа баярлалаа. Энэ замаар алхах боломжийг нээж өгсөн нийт сургалтын багш нартаа, суралцах орчныг бүрдүүлж, биднийг дэмжсэн Монгол-Японы төвийн хамт олонд дахин талархал илэрхийлье.



*Зураг 40. “Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт” Суралцагч Т.Баярмаа*

**“Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт”  
Суралцагч Т.Баярмаа**





## Сургалтын талаарх сэтгэгдэл

Би Кёото их сургууль, Монгол-Японы төв хоорондын гэрээт япон хэлний бэлтгэл сургалтад 2023 оны 6 сараас эхлэн 2 сарын хугацаанд суралцсан билээ. Анх япон хэлний бэлтгэл сургалт гэж сонсоод ганцаарчилсан байх юм гэж огт төсөөлөөгүй. Надтай ижил түвшний олон хүүхэдтэй нэг дор, нэг ангид суралцах байх гэж бодоод, ангид өөр хүүхдүүд байгаа гэсэн хүлээлттэй очсон. Гэтэл төсөөлж байснаас минь огт өөр буюу ангийн голд ганцхан ширээ, миний овог нэрийг бичсэн цаас, хичээлийн ном товхимлууд цэвэрхэн гэгч нь өрөөстэй байв. Сургалтын нээлтийг ч надад зориулаад тайлбарлахад бэлдчихсэн. Өмнө нь хэлний ганцаарчилсан сургалтад явж үзээгүй, дээрээс нь 3 гаран жил япон хэл сурахдаа ярианы хичээлд ганц ч сууж үзээгүй надад зөвхөн миний төлөө орох энэ 75 цагийн хичээл дахиж хэзээ ч олодохгүй боломж шиг санагдаж билээ. /Яг л киноны хэсэг шиг, ангиас гэрэл цацраад л ккк/



*Зураг 41. “Кёото их сургуульд элсэн орохын өмнөх япон хэлний бэлтгэл сургалт-2023”  
Суралцагч Б.Ариунзул*

Энэхүү ганцаарчилсан сургалт миний өнөөг хүртэл сууж үзсэн сургалтуудаас хамгийн үр дүнтэй сургалт болсон. Япон, монгол багш нартайгаа ганцаарчлан тулж ажиллаад л, мэдэх мэдэхгүй зүйлсийнхээ тухай, сонирхолтой сэдвүүдийн тухай ч чөлөөтэй ярилцах цаг бүрдсэний дээр, хичээлээс гадуур япон соёлын тухай ч олон зүйлийг мэдэж авсан. Марүгото номын маань хичээлүүд үнэхээр сонирхолтой, бас миний хувьд хамгийн дутагдалтай байсан чадварууд болох ярих, бичих чадвар дээр маань маш сайн ажиллаж өгсөн. Зөвхөн номоос ч гэлтгүй багш нар маань ирээдүйн мэргэжил, сонирхолтой маань холбоотой мэдээллүүдийг авч болох япон сайтууд, youtube сувгуудыг хүртэл зааж өгч байв. Сургалтын төгсгөлд япон хэлний N1 түвшнийг хангасныг багш нартаа дуулгахад надаас илүү баярлаж билээ. Багш нар маань бүх зүйлд үнэн сэтгэлээсээ ханддаг байсан болохоор сургалт маань илүү үр дүнтэй болсон шиг санагддаг юм. Үүнээс цааш би нь “япон хэлийг” бус “япон хэлээр” сурах аян замд гарах гэж байна. Эндээс цааш урагшлах, япон хэлийг яг л өөрийн юм шиг ашиглах хүч, урам зориг, итгэл төрүүлж өгсөн багш нартаа хамгаас илүү баярлалаа.

*“Кёото их сургуульд элсэн орохын өмнөх япон хэлний бэлтгэл сургалт-2023”  
Суралцагч Б.Ариунзул*

# НОМЫН САН, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАСАГ





## 1. 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТАЙЛАН

Монгол-Японы төвийн номын сан, хамтын ажиллагааны тасаг нь хоёр орны хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд нээлттэй семинар, япон киноны өдөр, Японд суралцахыг хүссэн оюутан сурагчдад зориулсан “Мэдээллийн яармаг, семинар”, Японд тэмдэглэдэг уламжлалт баяр наадмаар дамжуулан япон соёлыг мэдэж авах “Япон хэл, соёлын танилцуулга хичээл”, ЕБС-иудын япон хэлний багш, сурагчдын хамрагддаг Хакүходо боловсролын сангийн япон хэл сурч буй хүүхдийн боловсролыг дэмжих “Япон хэл, солилцооны хөтөлбөр” зэрэг ажлуудыг тогтмол зохион байгуулахын зэрэгцээ нийтийн номын сангийн үйл ажиллагаа явуулдаг.

Дээр дурдсан үйл ажиллагаануудын талаар та онцлох мэдээ хэсгээс дэлгэрүүлэн уншина уу.

Энэ жил компьютерийн цогц болон бичээчийн сургалт танхимаар, цахимаар нийт 15 удаа хичээллэлээ.

### 1) Номын сангийн үйл ажиллагаа

Номын сангийн бүртгэлтэй уншигчдын тоо 2023 оны 12-р сарын байдлаар 29,050 болсон ба жилийн өмнө 7000 хүн номын санд ирсэн бол энэ жил 7209 хүнд үйлчилсэн нь корона вирусийн дараах үйлчилгээ эргэн сэргэсэн жилээс ч өссөн үзүүлэлт байлаа.

Номын сангийн фондод япон хэл суралцагчдад зориулсан ном, толь бичиг, Японд суралцах шалгалт, япон хэлний түвшин тогтоох шалгалтад бэлтгэх ном, товхимол, япон, монгол зохиолчдын бүтээл, дэлхийн сонгодог зохиол, комик зэрэг 11,700 гаруй ном материал байна. Түүнээс гадна Японы 100 гаруй их, дээд сургуулийн танилцуулга, холбогдох материалууд номын санд бий. Энэ жил номын сангийн фондоо 400 гаруй номоор баяжуулжээ. “Read Japan Project” төсөлд 2 дахь жилдээ хамрагдан Японы улс төр, түүх нийгэм, урлагийн талаарх англи хэлээр гарсан 19 ном хүлээн авлаа. Түүнээс гадна монгол, япон хэлээрх ном хандивласан монгол, япон хувь хүн, албан байгууллага, хэвлэлийн газарт гүнээ талархаж байна.

Бид энэ жил бүртгэлийн системээ бүрэн цахимжуулж номын санд бүртгүүлэхээр ирсэн үйлчлүүлэгч өөрийн мэдээллийг таблет ашиглан бичдэг болгож өөрчлөн цаасан бүртгэлийг бүрэн халлаа. 11-р сарыг Соёлын яамнаас жил бүр “Соёлын бүтээлч сар” болгон зарладаг болсонтой холбогдуулан номын сан энэ удаа уншигчдын дунд 4 насны ангилалаар “Номын тэмдэглэлийн уралдаан” зохион байгуулж, хөдөө орон нутаг, хотоос ЕБС-ийн сурагчид анги хамт олноороо, оюутнууд, насанд хүрэгсэд өргөн оролцож ангилал тус бүрээс шалгарсан оролцогчдод гарын бэлэг гардууллаа.

Мөн жилийн эцэст номын сангийн уншигчдаас хамгийн их танхимаар үйлчлүүлсэн болон гэрээр ном авч ашигласан нэг уншигчийг бүртгэлийн системээр тодруулахад Шихихутаг их сургуулийн 1-р дамжааны оюутан Б.Ундармаа шалгаран гарын бэлэг авлаа.



Ном хэвлэлээр үйлчлэхээс гадна бид японы соёлыг түгээн дэлгэрүүлэх үүднээс японы үндэсний хувцас юката, япон эд хэрэглэлийн зүйлсийн түрээсийн үйлчилгээг мөн үзүүлдэг билээ. Энэ жил 120 гаруй хувь хүн, байгууллагуудад 500 гаруй хувцас, эд хэрэглэлийн түрээсийн үйлчилгээ үзүүлжээ.

Номын сангийн мэдээллийн буланд Японы ЭСЯ-аас хариуцан явуулдаг тэтгэлэгт шалгалт, Япон хэлний багш нарын холбоо, ЖАССО /Японы оюутныг дэмжих байгууллага/-оос явуулдаг хувийн зардлаар Японд суралцах шалгалт, мөн Япон сангийн япон хэлний түвшин тогтоох шалгалттай холбоотой мэдээллийг түгээдэг.

## 2) Япон киноны өдөр

Соёлын уламжлалт үйл ажиллагааны нэг болох япон киноны өдрийг энэ онд Японы элчин сайдын яам болон Японы үндэсний телевиз NHK World Japan-тай хамтран албан ёсны эрхтэйгээр 2022 оны 5-р сарын 7-нд дэлгэцнээ хүртээл болсон “17 настны засаглал” хэмээх онц сонирхолтой 5 ангит киног орчуулан, 3 өдрийн турш цувралаар хүргэлээ. Давхардсан тоогоор 189 үзэгчид хүрэлцэн иржээ. Үүнээс өмнөх жилүүдэд бид зөвхөн нэг ангит кино гаргадаг байсан бол энэ удаа олон ангит киног цувралаар анх удаа гаргасан нь бидэнд нэгэн шинэлэг ажил болж чадлаа.

## 3) Нээлттэй семинар

Төв нээгдсэн цагаасаа хойш нээлттэй семинарыг тогтмол зохион байгуулж ирсэн билээ. 2023 онд 83 дахь удаагаа зохиогдсон нээлттэй семинар энэ удаа Монголд амьдарч буй япончуудад зориулсан үйл ажиллагаа байлаа. Семинарын сэдэв: “Өдгөө ч өдөр тутамдаа өмссөөр буй үзэмж төгөлдөр үндэсний хувцас дээл”. Тус семинарын агуулга, хэрхэн явагдсан талаар сонирхолтой мэдээллийн дэлгэрэнгүйг та “Онцлох мэдээ”-ээс хүлээн авна уу.

## 4) Японд суралцах тухай мэдээллийн яармаг – 2023

Жил бүрийн намар явагддаг уламжлалт нэгэн арга хэмжээ бол Японд суралцахыг хүссэн хэн бүхэнд зориулсан “Японд суралцах мэдээллийн яармаг”. Энэ онд 14 дэх жилдээ зохион байгуулагдсан тус яармагийг Японоос ирсэн 10 их сургуулиудын төлөөлөлтэй хамтран төвдөө зохион байгууллаа. Мөн бид ноднинггоос Монголд хараахан хүрэлцэн ирж амжаагүй их сургуулиудыг материалаар оролцуулж эхэлсэн юм. Энэ удаа үүнд 4 их сургууль оролцов. Тухайн их сургуулиудын танилцуулга брошюр, тараах материалыг яармагийн хоёр өдөр оролцогчдод тараахаас гадна, сургуулийн мэдээлэл нь манай [www.edujapan.mn](http://www.edujapan.mn) тусгай вэб сайтад байршиж байгаа юм. Ийнхүү нийт 14 их сургуулийн мэдээ мэдээлэл нийтэд хүрлээ.

Оролцогч их сургуулиудын явуулсан танилцуулга материалуудыг хүлээн авах танхимд булан байгуулан танилцуулгыг байршуулж, мөн номын сан дахь тараах материалын булангаар дамжуулан тараахын зэрэгцээ үйлчлүүлэгчийг тухайн сургуультай холбож өгөх үйлчилгээг үзүүлж байна.





Бид ирэх жил “Японд суралцах мэдээллийн яармаг” үйл ажиллагаагаа хавар, намар хоёр удаа зохион байгуулахаар төлөвлөж байна. 2024 оны 4-р сард хаврын мэдээллийн яармагийг, 10-р сард намрын мэдээллийн яармагийг зохион байгуулахаар тус тус төлөвлөж байна. Дэлгэрэнгүйг онцлох мэдээнээс хүлээн авна уу.

### 5) Гэрээгээр гүйцэтгэх ажил

Жил бүр хэрэгждэг Хакүходо боловсролыг дэмжих сангийн “Япон хэл, солилцооны хөтөлбөр” энэ жил ч мөн амжилттай явагдлаа. 13 дахь хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад тэнцсэн Дархан хотын 19-р сургуулийн япон хэлний багш Л.Энхтуяа багшийн дадлага сургалт болон Япон улстай танилцах хөтөлбөрт шавь нарын хамт амжилттай яваад ирэв. Ийнхүү 13 дахь хөтөлбөр дуусч мөн үүнтэй зэрэгцэн 14 дэх хөтөлбөр эхэлж энэ удаад Эрдмийн Ундраа Цогцолбор 54-р сургуулийн япон хэлний багш Т.Энхпүрэв шалгарч 2023 оны 11-р сард багшийн дадлага сургалтандаа мөн амжилттай оролцоод ирлээ.

Энэ жил дээрх гэрээт ажлаас гадна бизнесийн хамтын ажиллагааны тасагтай нийлж ЖАЙКА-тай хамтран 6-р сард зохиогдсон ICT EXPO-2023 арга хэмжээнд оролцохоор Японоос ирсэн 19 компаний 23 хүний оролцсон 7 хоногийн бизнес аяллын зохион байгуулалтыг хариуцан ажиллав. 9-р сард орчуулгын болон зохион байгуулалтын хэд хэдэн гэрээт ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн байгууллага дээрх соёлын танилцуулга сургалтыг “Хаан банк”-ны хамт олонд 3 удаа хийж гүйцэтгэлээ.

#### Хүснэгт 18. Нээлттэй семинар

№	Сэдэв	Илтгэгч	Он сар өдөр	Хаана	Оролцогчдын тоо
1	№83. “Өдгөө ч өдөр тутамдаа өмссөөр буй үзэмж төгөлдөр үндэсний хувцас ДЭЭЛ”	Номын сан, хамтын ажиллагааны тасаг	2023.11.25	Их танхим	29
<b>Нийт</b>					<b>29</b>

#### Хүснэгт 19. Япон киноны өдөр

№	Киноны нэр (Хадмал орчуулгатай)	Он сар өдөр	Хаана	Хүний тоо
1	NHK World Japan “17 настны засаглал” 5 ангит кино	2023.5.17-19	Их танхим	189
<b>Нийт</b>				<b>189</b>





### Хүснэгт 20. Гэрээгээр гүйцэтгэх ажил

№	Үйл ажиллагааны нэр	Он сар өдөр	Оролцогчид	Хаана	Хүний тоо
1	Хакүходо боловсролын сангийн "Япон хэл, солилцооны хөтөлбөр" гэрээт ажил	2023.5, 11-р сар	ЕБС-ийн япон хэлний багш	Япон, Токио	6
2	"ICT EXPO-2023"- ICT Tour	2023. 6-р сар	ЛСА, Японы 19 компаний төлөөлөл	ҮСАХ МЯТ IT park	23
3	AERONEXT-н симпозиум "Шинэ үеийн ухаалаг тээвэрлэлт Монголд"	2023. 9-р сар	ЛСА Ньюком групп AERONEXT компани	ҮСАХ White rock center	84
4	Японы оюутныг дэмжих байгууллага ЖАССО-н гарын авлагын орчуулга, хэвлэлт	2023.9-р сар	ЖАССО	Impress Colour LLC	1
5	"Хаан банк"-ны ажилтнуудад япон соёлын танилцуулга сургалт	2023.11, 12-р сар	Хаан банкны ажилтнууд	Хаан банк төв оффис	80
6	Анагаах ухаан, нийгмийн халамжийн олон улсын их сургуулийн гэрээт ажил	2023.12-р сар	Тухайн их сургуулийн багш, мэргэжилтнүүд, элсэгчид	Монгол-Японы төв /цахим/	8
<b>Нийт</b>					<b>202</b>

### Хүснэгт 21. Япон сангийн Япон хэл, соёлын танилцуулга хичээл


№	Үйл ажиллагааны нэр	Он сар өдөр	Оролцогчид	Хаана	Хүний тоо
1	Цагаан сар	2023.01.14	Оюутан, сурагчид	204, 205	20
2	Охидын баяр	2023.03.04	Сурагчид	Их танхим	32
3	Хүүхдийн баяр	2023.05.06	Сурагчид	204, 205	32
4	Сар харах баяр	2023.09.09	Иргэд		24
<b>Нийт</b>					<b>108</b>



**Хүснэгт 22. Номын сангийн үйлчлүүлэгчдийн тоо**

Сараар	2023												Нийт
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Үйлчлүүлэгчдийн тоо	360	448	784	750	774	612	151	637	733	811	705	444	7209

График 7. Номын сангийн үйлчлүүлэгчдийн тоо 2023.01-12



**Хүснэгт 23. Компьютерийн сургалт**

№	Сургалтын нэр	Хугацаа	Давтамж	Агуулга	Багшийн нэр	Оролцогчдын тоо
1	Арван хурууны бичээчийн сургалт /танхим, цахим/	2023.01-2023.12	10 удаа	Компьютерийн гарын үндсэн байрлалыг эзэмшиж, МонГТ программ ашиглан арван хуруугаар зөв, хурдан бичиж сурна.	Т.Болормаа	119
2	Компьютерийн цогц сургалт		5 удаа	Тус сургалтаар анхан шат, интернетийн хэрэглээнээс эхлээд MS-Word, MS-Excel, MS-Powerpoint программыг цогц хэлбэрээр заана. MS-Word, MS-Excel программын үндсэн функц, зураг, хүснэгт, график, диаграмм, санхүүгийн тооцоо, цалингийн тооцоо хөтлөх, түгээмэл хэрэглэгддэг томъёоны функц гэх мэт аргачлалуудыг сурна. PowerPoint ашиглан сонирхолтой боловсронгуй байдлаар илтгэл бэлтгэх аргачлалыг сурна.	Э. Сүх-Эрдэнэ	47
<b>Нийт</b>						<b>166</b>



## 2. Онцлох мэдээ

### 1. “Японд суралцах тухай мэдээллийн яармаг – 2023”



Зураг 42. Мэдээллийн яармагийн постер

2023 оны 10-р сарын 7 (Бя), 8 (Ня)-ний өдрүүдэд Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвд “Японд суралцах тухай мэдээллийн яармаг-2023” зохион байгуулагдлаа. 14 дэх удаагаа зохион байгуулагдаж буй тус арга хэмжээнд Японы 9 их сургууль танхимаар, 4 их сургууль материалаар тус тус оролцлоо. Энэхүү арга хэмжээнд Японд суралцах хүсэлтэй оюутан залуус 2 хоногийн нийлсэн дүнгээр 1200 гаруй хүн оролцсон байна.

Мэдээллийн яармагийн өмнөх өдөр буюу 10-р сарын 6 (Ба)-ны өдөр, Японы их сургуулиудын төлөөлөгчид япон

болон англи хэлийг гүнзгийрүүлэн суралцдаг бүрэн дунд сургуулиудтай танилцах хөтөлбөрт хамрагдсан юм. Энэхүү хөтөлбөр нь мэдээллийн яармагт оролцож буй япон сургуулиудыг танилцуулах болон элсэлтийн талаарх мэдээллийг тухайн сургуулийн сурагчидтай хуваалцаж, Японд суралцах талаар санал солилцдог билээ.

Мэдээллийн яармагийн эхний өдөр буюу 10-р сарын 7-ны бямба гарагт арга хэмжээг нээж Япон улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Кобаяши Хироюки үг хэлэн, МУИС-ийн оюутны хөгжлийн бодлогын газрын дарга В. Дашдаваа, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн захирал Ц. Даваадорж нар мэндчилгээ дэвшүүлэв.



Зураг 43. Нээлтийн үйл ажиллагаа

“Японд суралцах тухай мэдээллийн яармаг-2023”-ын энэ жилийн хөтөлбөрт Япон улсын засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн танилцуулга, Японд суралцах талаар ерөнхий танилцуулга (JASSO), Япон сангийн зохицуулагч Цүрүта Ясүюкигийн “Япон хэл сурах арга барил”, Япон улсад тэтгэлгээр суралцаж ирсэн оюутны яриа, мэдээллийн яармагт оролцож буй сургуулиудын танилцуулга болон сургууль тус бүрийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх булан зэрэг зорьж ирсэн оюутан залуусдаа цогц мэдээлэл авах боломжийг хангаж өгөхийг зорьсноороо онцлогтой байлаа. Оюутан залуус маань



өөрсдийн суралцах чиглэлээр элсэлт авч буй сургуулийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх буланд очиж тэтгэлэгт хөтөлбөрөөс гадна өөрт хэрэгтэй мэдээллүүдээ олж авч байсан.

Мэдээллийн яармагийн сүүлийн өдөр буюу 10-р сарын 8 (Ня)-ний өдөр, Японд сургууль төгсөгчдийн “Жугамо” нийгэмлэгээс “Японд сурч мэдсэн туршлага” сэдвээр нээлттэй хэлэлцүүлэг хийлээ. Тус нээлттэй хэлэлцүүлэг нь “Жугамо” нийгэмлэгээс зохион байгуулдаг “TALKio-Let’s about ideas & opportunities”-ын ээлжит цуврал бөгөөд улсын болон хувийн зардал, G30 хөтөлбөрөөр япон англи хэлээр Японд суралцсан залуус өөрсдийн туршлагаа хуваалцаж, оролцогчдын сонирхсон асуултад хариулсан.



Зураг 44. “Японд сурч мэдсэн туршлага”-ын илтгэгчид

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь Монголынхоо оюутан залуусыг Японы их дээд сургуульд амжилттай суралцаж төгсөөд, ирээдүйд Монгол орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах боловсон хүчин болохыг дэмжиж жил бүр энэхүү мэдээллийн яармагийг зохион байгуулахын сацуу Японд суралцах талаар зөвлөгөө зөвлөмжийг байнга өгдөг билээ.

Ирэх жил ч гэсэн Япон улсаас олон олон их сургууль, байгууллагын төлөөлөгчид “Японд суралцах мэдээллийн яармаг”-т оролцож, Японд суралцахыг хүсэж буй оюутан залууст хэрэгцээтэй мэдээлэл өгнө гэдэгт итгэж байна.

**Ерөнхий зохион байгуулагч:** Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв

**Хамтран зохион байгуулагч:** Монгол Улсын Их Сургууль

Японд сургууль төгсөгчдийн “JUGAMO” нийгэмлэг

**Дэмжигч байгууллага:** Монгол дахь Япон улсын элчин сайдын яам

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)

Японы оюутныг дэмжих байгууллага (JASSO)

**Оролцогч их сургуулиуд:** Анагаах ухаан, нийгмийн халамжийн олон улсын их сургууль, Киото дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль, Нагоя худалдаа, бизнесийн их сургууль, Осакагийн их сургууль, Олон улсын их сургууль, Рицүмэйкан ази номхон далайн их сургууль, Токио олон улсын их сургууль, Тооёо их сургууль, Хёого мужийн их сургууль

Материалаар оролцогч сургуулиуд: Кэйо их сургууль, Мүсашино их сургууль, Токиогийн их сургууль, Ямагата их сургууль





**Хүснэгт 24. Оролцогч сургуулиуд**

 <p><b>Киото дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль</b></p>	 <p><b>Хёого мужийн их сургууль</b></p>	 <p><b>Нагоя худалдаа, бизнесийн их сургууль</b></p>	 <p><b>Токио олон улсын их сургууль</b></p>	<p>Shape your world</p>  <p>Ritsumeikan Asia Pacific University</p> <p><b>Рицүмэйкан Ази Номхон далайн их сургууль</b></p>
 <p><b>Тооёо их сургууль</b></p>	 <p><b>Осакагийн их сургууль</b></p>	 <p><b>Олон улсын их сургууль</b></p>	 <p><b>Ямагата их сургууль</b></p>	 <p><b>Кэйо их сургууль</b></p>
<p>世界の幸せをカタチにする。 Creating Peace &amp; Happiness for the World</p>  <p><b>Мүсашино их сургууль</b></p>	 <p><b>Токиогийн их сургууль (PEAK хөтөлбөр)</b></p>	 <p><b>Анагаах ухаан, нийгмийн халамжийн олон улсын их сургууль</b></p>		

**2. 83-р нээлттэй семинар: “Өдгөө ч өдөр тутамдаа өмссөөр буй үзэмж төгөлдөр үндэсний хувцас ДЭЭЛ”**



Зураг 45. Дээлний түүх, соёлын танилцуулгын үзэр

2023 оны 83 дахь удаагийн нээлттэй семинараа Монголд ажилж амьдарч буй япон иргэдэд зориулан “Өдгөө ч өдөр тутамдаа өмссөөр буй үзэмж төгөлдөр үндэсний хувцас ДЭЭЛ” гэх сэдвийн дор зохион байгууллаа. Монгол үндэсний хувцас дээлний талаарх түүх, соёлыг танилцуулахаас гадна дээл өмсөж үзэх болон мэргэжлийн багшаас монгол бүжиг сурах боломжийг олгосон юм.

Цахим орчноос хүссэн мэдээллээ олж авах боломжтой болсон өнөө үед бодитоор харж, гараар хүрч, өөрийн биеэр туршиж үзэх боломжтой ийм төрлийн үйл ажиллагаа гадаад иргэдийн дунд эрэлт их байгааг бидэнд ойлгуулсан чухал үйл ажиллагаа боллоо.



Бидний хувьд дээлийн талаар япон хүмүүст ойлгомжтой бөгөөд өргөн цар хүрээтэй мэдээлэл хүргэхийг зорьсон билээ. Дээлийг гарал үүсэл, онцлог чанар, материал, хэрэглээ, эртний болон орчин үеийн гэх зэргээр ангилан танилцуулгаа бэлтгэсэн. Нутаг нэгтнүүдийн хамтаар өөрсдийн эх хэл дээрээ мэдээлэл авахын сацуу тэр бүр олдоод байдаггүй өөрсдийн биеэр туршиж үзэх боломж олгосон нь оролцогчдоос өндөр үнэлгээ авлаа. Ороцогчид маань ч өөрт байдаг дээл өмсгөлөө авч ирэн биднээс торго дурдан болон түүн дээрх хээ угалзны утга агуулга гэх мэт сонирхсон асуултуудаа асуун цагийг үр бүтээлтэй бөгөөд хөгжилтэй өнгөрүүлээ.



*Зураг 46. Монгол бүжиг сурч буй байдал*

Бид ч цаашид зөвхөн үндэсний хувцас гэлтгүй Монголчуудын өдөр тутамдаа баримталдаг зан заншил, уламжлалт тоглоом наадгай /шагай, оньсон тоглоом/, бүжиг, зоог гэх мэт олон төрлийн сэдвээр япон жуулчдад танилцуулга хичээлийг онол практик хосолсон байдлаар зохион байгуулахаар ажилдаа ханцуй шамлан ороод байна.



*Зураг 47. Дурсгалын зураг*





### 3. Хакүходо боловсролын сангийн “Япон хэл, солилцооны хөтөлбөр”

~Хүүхдүүд япон хэлээр дамжуулан хоорондоо харилцаж, бусад орны соёлтой танилцахад дэмжлэг үзүүлэх~

“Хэл ярианы хүчийг үндэс болгон, хүүхдийн хөгжилд хувь нэмэр оруулах” санаачилгаар үүсгэн байгуулагдсан улсаас итгэмжлэлтэй Хакүходо Сангийн явуулж буй “Япон хэл, солилцооны хөтөлбөр” нь япон хэлээр дамжуулан бусад орны соёлтой танилцаж, хүүхдүүд хоорондоо харилцах замаар японы болон бусад орны сурагчидтай



Зураг 48. Багшийн дадлага, сургалт

харилцан ойлголцлоо гүнзгийрүүлэн, дэлхийн тулгамдсан асуудлын гаргалгааг хамтдаа шийдвэрлэх чадвартай олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц хувь хүн болон хөгжих боломжийг олгох зорилготой бөгөөд Япон төв дээр 2009 оноос энэхүү үйл ажиллагааны хөтөлбөрийн нэг хэсгийг хариуцан явуулж байна.

Хөтөлбөрийн агуулга нь гадаад улсад япон хэл заадаг дунд боловсрол олгох сургууль (Японы дунд сургуультай дүйцэх)-ийн япон хэлний

багш Япон улсад сургалтад хамрагдах “Хилийн чанад дахь япон хэлний багш нарын сургалт”, япон хэл сурдаг гадаад улсын сурагч япон сургуульд зочлон, япон дунд сургуулийн үе тэнгийн сурагчидтай япон хэлээр харилцаж, гадаад орны соёлтой танилцах “Гадаад орны хүүхдүүд Япон улстай танилцах хөтөлбөр” юм.



Зураг 49. Япон хэл солилцооны хөтөлбөр

Энэ жилийн “Япон хэл, солилцооны хөтөлбөр”-ийн 13 дахь сонгон шалгаруулалтад Дархан-Уул аймгийн 19-р сургуулийн япон хэлний Л.Энхтуяа багш тэнцсэн юм. Ийнхүү хөтөлбөрийн хүрээнд багш маань 2022 оны 11-р сард “Японд багшийн чадамж дээшлүүлэх хөтөлбөр” болон “Япон улстай танилцах хөтөлбөр”-т 4 шавь нарын хамт дараа оны буюу 2023 оны 5-р сард оролцсоноор “Япон хэл, солилцооны 13 дахь хөтөлбөр” маань амжилттай дууслаа.



Япон улсад зочилсон хөтөлбөрт оролцогч сурагчид Японоос гадна Истани, Индонези, Тайланд, Турк гэх мэт 9 орны хүүхдүүдтэй япон хэлээр ярилцаж, өөрсдийн сургуулийг танилцуулах, морин хуур тоглох, баг болж өгөгдсөн сэдвийн дагуу судалгаа хийж тайлагнах үйл ажиллагаанд оролцсон. Мөн япон сургууль болон япон айлд зочлох, Токиогийн аялал жуулчлалын газруудаар аялан японы соёл, нийгэмтэй танилцаад эх орондоо ирсэн юм. Оролцогч 4 сурагч сэтгэгдэлдээ “Япон хүмүүсийн хүнийг хүндлэх ёс, үйлчилгээний соёлыг нь хараад биширсэн”, “Хүнтэй зөв боловсон харьцах соёлыг сурсан”, “Японы Токио хотын орчин үеийн болон уламжлалт соёлыг хадгалж үлдсэн газруудаар аялсандаа маш их баяртай байна.”, “Монголынхоо морин хуурыг дарж үзүүлэхэд бүгдээрээ алга ташин хүлээж авсан”, “Япон сурагчид багшийнхаа үгийг маш сайн сонсож дагаж мөрддөг”, “Япон хүүхдүүдийн хичээлээ хичээнгүйлэн хийж байхыг хараад илүү хичээлдээ шамдах урам зориг төрсөн” гэх мэт төрөл бүрийн зүйлсийг бичсэн байна.



Зураг 50. Япон хэл солилцооны хөтөлбөр

Эх орондоо эргэж ирсний дараа сурагчид хоносон айл болон бусад орны оролцогч хүүхдүүдтэй үргэлжлүүлэн интернэтээр харилцаж байгаа бөгөөд өөрсдийн биеэр сурч мэдсэн зүйлсээ үе тэнгийнхэнтэйгээ хуваалцан сургууль дээрээ шинэ санаа дэвшүүлж, идэвхтэй хэрэгжүүлж байна.

Ирээдүйг авч явах хүүхдүүдийн зүй зохистой төлөвшилд нөлөөлөх энэхүү үйл ажиллагааг 2024 онд ч гэсэн үргэлжлүүлэн дэмжиж ажиллах болно.

#### 4. Зохиолч уншигчдын уулзалт: Мүраками Харүки “Эрэг дээрх Кафка” номын хэлэлцүүлэг

Номын дэлгүүрийн худалдаанд, цахим номын борлуулалтын шилдэг номын тоонд байнга бүтээл нь орж байдаг нэгэн зохиолч бол яахын аргагүй Японы орчин үеийн утга зохиолын томоохон төлөөлөл Мүраками Харүки билээ.

Түүний ээлжит нэгэн бүтээл “Эрэг дээрх Кафка” номоор нь энэ удаагийн зохиолч, уншигчдын уулзалтаа зохион байгууллаа. Тус роман нь зохиолчийн 10 дахь роман бөгөөд 2002 онд Японд хэвлэгдээд 2017 онд монгол хэлээр орчуулагдан уншигчдын хүртээл болжээ. Хэдийгээр үйл ажиллагаа маань “Зохиолч, уншигчдын уулзалт” нэртэй боловч гадаад зохиогчтой номын тухайд бид орчуулагчийг урьж оролцуулдаг билээ.

Тухайн бүтээлийн талаар орчуулагчийн сэтгэгдлийг сонсон, орчуулгын явцын талаарх санал бодлыг ч сонирхон асуух нь гадаад уран зохиолыг эх хэлээр нь унших юмсан гэж бодож явдаг хүүхэд залууст тун хэрэгтэй мэдээлэл болж, урам зориг өгсөн явдал болох нь ч бий.





Уншигчид 5 багт хуваагдан номын хэлэлцүүлэг өрнүүлж, орчуулагчтай санал бодлоо солилцон, номын талаар идэвхтэй яриа өрнүүллээ.

- *Хэрээ хэмээх хүү хэн бэ? Тэр Кафка Тамурагийн дотоод сэтгэлийн ямар хэсгийг төлөөлдөг вэ?*
- *Франц Кафка, Тамура Кафка, Хэрээ хэмээх хүү хоорондоо ямар хамааралтай вэ?*
- *Хэрээ романд ямар чухал мөчүүдэд гардаг вэ? Тэд юуг бэлгэдэж байна вэ?*
- *Зохиолд хувь тавилан буюу утга учиртай давхцал ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?*
- *Кафкагийн хувь заяа үйлийн үр мөн үү?*

гэх зэрэг орчуулагчийн зүгээс бэлдсэн асуултын дагуу багууд хоорондоо ярилцан, багаас нэг төлөөлөл гарч бусдадаа өөрсдийн ярилцсан тайлбараа танилцуулж байлаа.



Зураг 51. Уулзалтын үеэр



Зураг 52. Номын сан дахь Мүраками зохиолчийн номууд

Нийт 25 уншигч ирсний дотор МУИС-ийн монгол хэлний ангид суралцаж буй хоёр япон оюутан оролцсон нь уулзалтыг улам сонирхолтой болгосон юм. Япон хүний үүднээс хэлсэн зохиолын талаарх тэдний сэтгэгдэл монгол уншигчдад тун ч сонирхолтой байлаа. Мөн оролцогчид дунд цахим орчинд Мүраками Харүкигийн зохиол бүтээлийг ярилцаж, мэдээ мэдээлэл хүргэн танилцуулж байдаг олон мянган гишүүнтэй бүлгийн админ ч хүрэлцэн ирсэн байлаа. Уншигчид өөрийн номон дээрээ орчуулагчийн гарын үсэг авч, орчуулагч ч уншигчдад төрсөн сэтгэгдлийг олон өнцгөөс харсан тайлбар сонсож, тэр өдрийн үйл ажиллагаанд бүгд маш сэтгэл хангалуун оролцлоо. Мүраками Харүки зохиолчийн доорх бүтээлүүд манай номын санд монгол, япон хэлээр бий. Та бүхэн манай номын санд хүрэлцэн ирж Японы уран зохиолыг монгол, япон, англи хэлээр уншаарай.



**Хүснэгт 25. Төвийн номын санд байгаа Мүраками Харүкигийн бүтээлийн жагсаалт**

№	Зохиолын нэрс	Ангилал	
1	1Q84 (Нэгдүгээр дэвтэр)	К- 280	Монгол хэлээр
2	1Q84 (Хоёрдугаар дэвтэр)	К- 281	
3	1Q84 (Гуравдугаар дэвтэр)	К- 296	
4	Норвегийн ой	К- 294	
5	Өнгөгүй Тазаки Цүкүрү ба түүний эргэлтийн он жилүүд	К- 328	
6	Эрэг дээрх Кафка	К- 0077	
7	Торгон цэргийн хороон даргын аллага-1	К- 136	
8	Торгон цэргийн хороон даргын аллага-2	К- 177	
9	Эмсгүй эрс	900-827	Япон хэлээр
10	Нэжимаки шувуу буюу он цагийн дараалал-1	P900-(mu-1)	
11	Нэжимаки шувуу буюу он цагийн дараалал-2	P900-(mu-2)	
12	Нэжимаки шувуу буюу он цагийн дараалал-3	P900-(mu-3)	
13	Салхины чимээг анирдахуй	P900-(mu-14)	
14	Хонь тойрсон адал явдал-1	P900-(mu-13)	
15	Хонь тойрсон адал явдал-2	P900-(mu-12)	

**5. Япон соёлын танилцуулга хичээл “Юката өмсөцгөө”**

Монгол-Японы төв нь хоёр орны найрамдалт харилцаа, хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулсаар ирсэн билээ. Энэ удаа бид барилгын зураг төслийн компанид ажилладаг Имакадо Чикако хэмээх өөрийн сонирхлоороо японы үндэсний хувцасны соёлыг түгээж яваа япон эмэгтэйтэй хамтарч ажиллаа. Хамт ажилладаг монгол ажилтантайгаа монгол хэлээр ярихын тулд анх Монгол орныг сонирхож эхэлсэн бөгөөд түүний сонирхол нь Монголд ирж япон соёлын танилцуулга хичээл зохион байгуулах хэмжээнд хүртэл хөтөлсөн байна.

Анх 2023 оны 2 сард дээрх үйл ажиллагааг хамтарч зохион байгуулах саналыг бидэнд тавьж, 5 сарын турш хоёр талд бэлтгэл ажил явагдсаар 2023 оны 7-р сарын 20-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Нийт 22 хүн оролцож, японы үндэсний хувцасны соёлтой танилцахаас гадна өөрийн биеэр өмсөж үзсэн бөгөөд оролцогч дундаас 3 азтан шалгаруулж өмсөж байсан юкатаг нь бэлгэлсэн.



Зураг 53. Бүс бүслэх аргыг зааж буй байдал




Зураг 54. Юката өмсөж буй байдал

Дашрамд дурдахад тус үйл ажиллагаанд ашигласан бүх юкатаг Имакадо Чикако гуай өөрийн инстаграм хуудсаараа дамжуулан Япон орон даяар 4 сарын турш цуглуулсан бөгөөд тухайн өдөр Имакадо Чикако гуайн эмэгтэй дүү мөн тус үйл ажиллагаанд туслахаар алс холын Япон орноос зорин ирсэн байлаа. Багш, оролцогчид бүгд тус үйл ажилагаанд сэтгэл хангалуун байсан бөгөөд дахин уулзахын ерөөл тавин тус үйл ажиллагаа өндөрлөсөн.

### 6. Японд амьдрахад таны мэдвэл зохих шаардлагатай багц мэдээлэл

Сүүлийн жилүүдэд Япон орныг сурч, ажиллахаар зорих монголчуудын тоо эрс нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор явахынхаа өмнө соёлын ялгаатай байдлыг сайн судалж, мэдээгүйгээс болж асуудалд орох, нэн шаардлагатай бичиг баримтаа цаг тухай бүрд нь бүрдүүлж чадахгүй хоцрох зэрэг Японд дахь амьдрал нь нэг л болж өгөхгүй санаагаа чилээж суугаа монголчууд цөөнгүй. Тэдгээр монголчууддаа зориулан Монгол-

Японы төв нь ЖАЙКА-тай хамтран анх удаа Япон дахь амьдралд нь дэмжлэг болох зорилгоор зайлшгүй мэдэх шаардлагатай бичиг баримт бүрдүүлэлт, өдөр тутмын амьдралд гарч ирэх асуудлууд, дүрэм журам, соёлын ялгаа зэргийг цуврал хичээл болгон хүргэлээ.



Зураг 55. Хичээлийн үеэр



Зураг 56. Ярилцлагын цаг



Цуврал хичээлүүд маань Японд очсоны дараа бүрдүүлэх нэн шаардлагатай бичиг баримтууд, Японд амьдарч байх хугацаанд шаардлагатай болох бичиг баримтууд зэрэг нийт 2 хэсгээс бүрдсэн ба бүх хичээлүүдийн агуулгыг японд сурч, ажиллаж байсан ажилтнуудынхаа туршлага дээр үндэслэн боловсруулсан гэдгээрээ онцлогтой байлаа. Хичээлийн сэдвүүдээс дурдвал оршин суух үнэмлэх, тамга, банкинд данс нээлгэх, нийтийн тээвэр, байрны түрээслэх, ажлын анкет, жолооны үнэмлэхээ солиулах, цагийн ажил хайх, цалингаас татвар бодох, эмнэлэгт үзүүлэх, эргэн төлөгдөх даатгал, монгол-японы соёлын ялгаа зэрэг японд ажиллаж, амьдрахтай холбоотой бүхий л хүрээг хамарч чадсан юм.

Мөн тус цуврал хичээлүүдийнхээ дундуур японд сурч, ажиллаж байсан ажилтнуудыгаа урьж оролцуулан, ярилцлагын цагийг гаргаж өгснөөрөө оролцогч тус бүр өөрт хэрэгтэй мэдээллээ олж авах, санаа зовниж буй асуудлаа ярилцах таатай боломж бүрдэж өгсөн юм.



# ЕРӨНХИЙ УДИРДЛЫН ТАСАГ





## I. 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТАЙЛАН

Ерөнхий удирдлагын тасаг нь төвийн санхүү хөрөнгийн удирдлага, хүний нөөц, мэдээлэл технологи, аж ахуй, албан бичиг хөглөлт, цэвэрлэгээ үйлчилгээ, харуул хамгаалалтын зохицуулалт гэсэн үндсэн ажлуудаа 2022 онд 98%-ийн гүйцэтгэлтэйгээр амжилттай зохион байгуулж ажиллалаа.

2022 онд цар тахлын эсрэг авах арга хэмжээг буруулсантай холбоотойгоор төвийн сургалтууд урьдын адил хэвийн зохион байгуулагдаж, хөл хөдөлгөөн ихтэй жил боллоо.

Мөн бид дотоод нөөц бололцоогоороо төвийн барилга байгууламжийн засвар үйлчилгээг цаг тухайл нь хийж, цар тахлын хууль цуцлагдах хүртэл ЗГ болон УОК-оос заасан журмын дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийг цаг тухайд нь тогтмол хийж төвийн ажилтнууд болон төвөөр үйлчлүүлэгчдийн аюулгүй, тайван орчинд ажиллаж үйлчлүүлэх боломжийг бүрдүүлж чадсан. Энэхүү ажлын бүтээмж өндөр гүйцэтгэлтэй гарсан нь төвийн хамт олны хичээл зүтгэл, хамтын ажиллагааны үр дүнтэй салшгүй холбоотой.

Танхим ашиглуулсан байдал

**Хүснэгт 26. Байгууллагаар**

№	Зохион байгуулагч	Үйл ажиллагааны тоо (удаа)
1	Япон Улсын Элчин Сайдын Яам	4
2	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага ЖАЙКА	20
3	Монгол Улсын Их Сургууль	9
4	Монголын Япон хэлний багш нарын холбоо	5
5	Бусад байгууллага	90
Нийт		128



### Хүснэгт 27. Байгууллагаар

#### Үйл ажиллагааны төрлөөр

№	Үйл ажиллагааны төрөл	Үйл ажиллагааны тоо
1	МУИС-ийн үйл ажиллагаа	6
2	ЖАЙКА -ийн үйл ажиллагаа	15
3	Бизнесийн сургалт, семинар	49
4	Эрдэм шинжилгээний хурал, семинар	15
5	Япон хэлний сургалт, шалгалт	10
6	Олон нийтэд зориулсан нээлттэй сургалт, семинар	7
7	Ажлын байрны сургалт	3
8	Японд суралцах тухай мэдээллийн яармаг, семинар, шалгалт	2
9	Бусад	20
Нийт		127

Эх сурвалж: Монгол-Японы Төв, Ерөнхий удирдлагын тасаг

Дээрх ажлуудыг ЖАЙКА, Япон сан болон МУИС-ийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн удирдлага заавар, бүх талын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэсэн. Доорх үзүүлэлтээс харахад үйл ажиллагаа зохион байгуулсан тоо цар тахлын өмнөх үеийн түвшинд хараахан хүрээгүй байгаа ч, цаашид үйл ажиллагааны тоо улам нэмэгдэх хандлагатай байна.

Сүүлийн 5 жилийн төвийн үйлчлүүлэгчийн тоо 2023 оны 12-р сарын 31 хүртэл нийт:

2,633,326 хүн (давхардсан тоо)



График 8. Сүүлийн 7-н жилийн гаднаас зохион байгуулсан үйл ажиллагааны тоо





График 9. Сүүлийн 3 жилийн гаднаас зохион байгуулсан үйл ажиллагааны чанарын үзүүлэлт

**Байнгын үйлчлүүлэгч:**  
Жилд 2-оос дээш удаа үйлчлүүлэгч







## I. ОНЦЛОХ МЭДЭЭ

### 1. Олон улсын тэмцээнийг амжилттай хамтран зохион байгууллаа



*Зураг 57. Тэмцээний бяцхан тамирчид ерөнхий шүүгчийн хамт*

Бид “Отелло” хөлөгт тоглоомны Ази номхон далайн бүсийн Отеллогийн аврага шалгаруулах анхдугаар тэмцээнийг 2023 оны 6 сарын 23-25 өдрүүдэд өөрийн байрандаа амжилттай хамтран зохион байгуулж чадлаа. Тус тэмцээнд Япон, Хятад, Солонгос, Тайван, Сингапур, Австрали, Монгол улсаас нийт 114 тамирчин оролцсоноос 5-15 насны 64 өсвөрийн тамирчин, 40 эмэгтэй тамирчин өрсөлдсөн нь Отеллогийн хувьд түүхэн амжилт байлаа



*Зураг 57. Тэмцээний зохион байгуулагчид болон шагнал хүртсэн тамирчид*

# БАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



# ТАЙЛАН

МОНГОЛ-ЯПОНЫ ХҮНИЙ  
ТӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ



## 2023 ОНЫ БАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Монгол-Японы төвийн нийт ажилтнууд өөрийн хариуцсан ажлаас гадна төвийн нийт үйл ажиллагааны сайжруулалт болон ажилтан хоорондын харилцааг сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх зорилгоор хэд хэдэн багт хуваагдан ажиллаж байна. 2023 онд тасаг бүрийн ажилтны төлөөллөөс бүрдсэн “Маркетинг баг”, “5S Кайзен баг”, “Эрүүл мэнд, спортын баг”, “Үйл ажиллагаа зохион байгуулах баг”, “Харилцан туслалцах баг” гэсэн 5 баг тус тусын үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Ингэснээр ажилтан хоорондын багийн ажиллагаа, уялдаа холбоо сайжрахаас гадна шинийг санаачлах, өөрийгөө шинээр нээх боломжтой болж байна.

### 1. МАРКЕТИНГИЙН БАГ

Тус баг нь Монгол-Японы төвийг олон нийтэд таниулахын зэрэгцээ төвөөс явуулж байгаа сургалт, үйл ажиллагаанд хамрагдах суралцагч, оролцогчдын тоог өсгөх, тогтоон барих зорилготойгоор 2016 онд анх тасаг бүрийн төлөөлөгч 4 гишүүнтэйгээр байгуулагдаж, өдийг хүртэл амжилттай үйл ажиллагаа явуулж ирлээ.

2023 оны үйл ажиллагааны тойм:

№	Огноо	Үйл ажиллагаа	Тайлбар
1	2023.03	Төвийн арван тавдугаар тайлан	Тухайн жилийн үйл ажиллагааг тайлан болгон гаргадаг бөгөөд 2023 оны 15 дэх удаагийн тайланг гаргалаа. Энэ жилийн тайлан цахим хэлбэрээр гаргасан анхны тайлан байлаа.
2	2023	Төвийн бүхий л үйл ажиллагааны постер танилцуулга	Тухайн жилийн төвийн бүхий л үйл ажиллагааны постер танилцуулга нийт 125+ баннер болон станд 20 гаруйг өөрсдийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан хийж гүйцэтгэжээ. Ингэснээр бид 2.475.000₮-н хэмнэлт хийж 6-н сая гаруй төгрөгийн орлого олж чаджээ.
3	2023	Сошиал маркетинг	Фэйсбүүк дагагчын тоо 15%-р өсөж 69000-д хүрсэн бол инстаграмм итвэхтэйгээр хөтлөн дагагчдын тоо 1500д хүргэлээ. 4200 гаруй чагад хариу мэдээлэл өгч, нүүр хуудас болон гүрүнд ирсэн 10 гаруй халдлагаас сэргийлж чадлаа.
4	2023	Багийн гишүүд	Багт шинээр орсон гишүүд багийн үйл ажиллагааг гүйцэд ойлгож чадалгүй гарах тохиолдол байсан тул багийн хуучин гишүүд зөвлөхөөр ажиллаж өөрсдийн хийсэн болон хийхээр төлөвлөсөн ажилыг амжилттайгаар үргэлжлүүлж чадлаа.





## 2. 5S КАЙЗЕН БАГ

Тус төвд 2016 оноос эхлэн 5S Кайзэн хөдөлгөөнийг тасралтгүй хэвшил болгон хэрэгжүүлсээр ирлээ. 5S кайзэн баг нь төв дэх “Сэйри-Сэйтон-Сэйсоо” гэх мэт үйл ажиллагаанаас гадна орлого нэмэгдүүлэх болон зардал бууруулахад нөлөөлөхүйцээр үргүй зардлыг бууруулах ажлуудыг санаачлан хэрэгжүүлж байна. Мөн ажилтнуудын уур амьсгал бүрдүүлэх зорилготой “Талархлын карт” аянг хэрэгжүүлж, түүнээс гадна 5S хөдөлгөөний хэрэгжилтийн нөхцөл байдлыг шалгах патролыг хэрэгжүүлэв.

Сүүлийн жилүүдэд залуу шинэ ажилтнууд нэмэгдэж байгаатай холбогдуулан, төвийн 5S хөдөлгөөний үндсэн зорилгыг дахин эргэцүүлэн бодох зорилготойгоор “5S Кайзэн гэж юу вэ?”, “Япон төвд яагаад 5S шаардлагатай вэ” сэдэвт 4 удаагийн сургалтыг ажилтнууддаа зориулан зохион байгууллаа. Энэ сургалтын хувьд төвийн дотоод нөөц бололцоогоо ашиглан, төвийн ажилтнууд сургалтаа удирдан чиглүүлсэн бөгөөд “5S Кайзэн гэж юу вэ? “Анзаарга гэдэг нь” “Мүри-Мүда-Мүра” гэсэн сэдвүүдтэй байв. Улмаар бодитоор 5S хөдөлгөөн өрнүүлж буй “Мон-Шибасаки” хэмээх компани дээр танилцах сургалтад бүх ажилтнуудаараа хамрагдсан юм.

Энэ жилийн үйл ажиллагааны хүрээнд хэд хэдэн сайжруулан өөрчилсөн ажлууд бий. Түүний нэг бол урьд жилүүдээс хэрэгжүүлэн ирсэн “Улаан шошго” хэмээх аяныг “Улаан хайрцаг” нэртэй болгон өөрчилсөн явдал юм. “Улаан хайрцаг” гэдэг нь хэрэгтэй зүйл болон хэрэггүй зүйлийг ангилж, хэрэггүй зүйлээ хийдэг улаан хайрцаг юм. Тухайн хүнд шаардлагагүй зүйл байлаа ч өөр хэн нэгэнд шаардлагатай зүйл байж болох юм. Хэрэггүй зүйлийг шууд устгах биш шаардлагатай хүн нь авч хэрэглэсэнээр үргүй зардлыг бууруулах боломжтой юм.

Бас өөр нэг сайжруулалт бол “Kaizen BOX” /Кайзан саналын хайрцаг/ юм. Энэ аян нь төвийн хэмжээний ажлууд болон ажлын орчинтой холбоотой сайжруулах санал санаачлагаа бичин хийдэг хайрцаг юм. Кайзан саналын хайрцагт ирсэн саналыг эхний ээлжинд 5S баг дотроо хэлэлцсэний үндсэн дээр холбогдох хүмүүст сайжруулалтын санааг хэрэгжүүлэхийг санал болгож ирсэн. Сайжруулалтын хүрээ нь “Сэйри”, “Сэйтон”, “Сэйсоо”-г гадна, орлого нэмэгдүүлэх болон зардал бууруулахтай холбоотой өргөн хүрээтэй байлаа. Энэхүү “Кайзэн саналын хайрцаг” аяны хувьд хэрэгжилтийн анхны жил байсан ба нийт 39 санал, санаачлага ирсэн бөгөөд үүнээс 21 сайжруулалтын санал хэрэгжиж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж чадсан юм. Үлдсэн 18 санал нь одоо ч гэсэн хэлэлцэгдэн, хэрэгжүүлэх арга хэмжээг авсаар байна.

5S Кайзэн багийн хувьд цаашид ч гэсэн 5S хөдөлгөөнөөр дамжуулан илүү таатай ажлын байрны орчинг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулахын зэрэгцээ, шинэ ажилтнууд нэрэлхэлгүйгээр өөрийн санал, санаачлагаа гаргах боломжтой тогтолцоог бүрдүүлэхийг зорин ажилласаар байх болно.





“Ажилтнуудад зориулсан сургалт 2023”

“Кайзэн саналын хайрцаг” аян



**3. ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН БАГ**

Зорилго:

Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх замаар ажилчдын харилцаа холбоог сайжруулах, эрүүл амьдралын хэмнэлийг хэвшүүлэхэд оршино.

2023 онд хийгдсэн ажил:

No	Хэзээ	Үйл ажиллагааны нэр	Хаана	Бусад
1	1 сар-12 сар 8:55~	Өглөөний дасгал	Хүлээлгийн танхим	Тогтмол явуулах, ажилийн байрны дасгал нэмэгдэн мягмар болон пүрэв гарагуудад хийж хэвшив
2	9 сар- 12 сар 18:00-20:00	Спортын цаг	19-р сургуулийн заал	Ажилтнуудын бие бялдар болон дархлааг дэмжих, хамт олны уур амьсгалыг бүрдүүлэх, волейболын анхан шатны техник, ур чадварыг олгох, цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор нэгдэв. (Ажилчид өөрсдийн зардлаар)
3	3 сар, 11 сар	Эм болон бусад хэрэгтэй зүйлсийн худалдан авалт	-	Эмийн санд дууссан эмийг болон бусад хэрэгцээт зүйлсийг худалдан авч эмийн сангийн .
4	1 сар	Багш ажилтны спортын их наадам	МУИС спорт заал	МУИС багш ажилтны спортын их наадамд амжилттай оролцож багийн дүнгээр гуравдугаар байранд оров.



#### 4. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ БАГ

2023 онд Монгол-Японы төвийн үйл ажиллагаа зохион байгуулах баг нь “Ажлын байранд ажилтан хоорондын уур амьсгалыг сайжруулж, ажиллахад таатай орчин бүрдүүлцгээ” зорилгын хүрээнд 198 хүнийг хамарсан байгууллагын дотоод үйл ажиллагааг зохион байгууллаа.

##### 1. “Дээлтэй Монгол” өдөрлөг

Энэ жил шинэ оны эхний арга хэмжээ болгон уламжлал ёсоор “Дээлтэй Монгол” өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр Монгол-Японы төвийн захирал Ц.Даваадорж мэндчилгээ дэвшүүлж “Усан туулай” жилийн эхний ажлын өдрийг эхлүүлэв.



Зураг 59. “Дээлтэй Монгол” өдөрлөг

##### 2. “Олон улсын эмэгтэйчүүдийн баяр” болон “Цэргийн баяр”-ын хосолсон арга хэмжээ

Тус оны 3 сарын 17 өдөр “Олон улсын эмэгтэйчүүдийн баяр” болон “Цэргийн баяр”-ын өдрийг тохиолдуулан хосолсон арга хэмжээг зохион байгуулав. Үйл ажиллагааны хүрээнд хөгжөөнт тоглоом тоглож, амтат зоог барих зэргээр цагийг хөгжилтэй өнгөрүүлсэн юм.



### 3. Мэргэжилтэн болон ажилтныг угтах, үдэх өдөрлөг

ЖАЙКА-гаас Монгол-Японы төвд ерөнхий зөвлөхийг тодорхой хугацаагаар томилон ажиллуулдаг. Энэ жил Монгол-Японы төвийн ерөнхий зөвлөх Ониши Ёшифүмигийн 4 жилийн томилолтын хугацаа дууссан тул зөвлөхийн үдэлтийг хийхийн хамт шинэ ажилтнуудаа төвийн хамт олноороо угтаж авах өдөрлөг зохион байгуулав.



Зураг 60. Монгол-Японы төвийн захирал Ц.Даваадорж, Ерөнхий зөвлөх Ониши Ёшифүми нар



Зураг 61. Зүүн гар талаас Э.Гэгээнчулуун, Б.Буманицэцэг, Х.Жаргалмаа

### 4. Төвийн ажилтнуудын хүүхдүүдэд зориулсан “Эх үрсийн баяр”-ын арга хэмжээ

“Эх үрсийн баяр”-ын хүрээнд хүүхдүүдэд зориулсан хөгжилтэй арга хэмжээг жил бүр зохион байгуулж байсан ч, өнгөрсөн 3 жилийн хугацаанд халдварт өвчний улмаас нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах боломжгүй байлаа. Харин энэ жил хориг тавигдан, халдварт өвчин намжсан тул төвийн ажилтнуудын хүүхдүүдэд зориулсан арга хэмжээг сэргээн зохион байгууллаа. Энэ өдөр бяцхан хүүхдүүд маань хөгжөөнт тоглоом тоглож, авьяас чадвараа үзүүлж, амтат зоог барихын зэрэгцээ бие биетэйгээ танилцан нэгэн өдрийг эцэг эхийн хамт хөгжилтэй өнгөрөөлөө.



Зураг 62. “Хүүхдийн баяр” арга хэмжээний үйл явцаас






### 5. Ажилтнуудад зориулсан хээрийн дадлага сургалт

Монгол-Японы төвийн ажилтнуудын хээрийн дадлага сургалтыг зохион байгуулах хүрээнд байгалийн үзэсгэлэнт Түнхэл тосгон руу вагонтой аялал хийлээ. Япон мэргэжилтнүүдээс гадна монгол ажилтнууд дунд ч гэсэн “Анх удаа вагонд сууж үзлээ” гэх хүмүүс байсан ба байгалийн үзэсгэлэнт газраар аялж хамтдаа нэгэн өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлэв. Хээрийн дадлага сургалтын үеэр Жайкагаас шинээр томилогдож ирсэн Изаки Хироши ерөнхий зөвлөхийн угталтын арга хэмжээг давхар зохион байгуулав.



Зураг 63. Ажилтнуудад зориулсан хээрийн дадлага сургалтын үеэр

### 6. Ажилтанд зориулсан төрсөн өдрийн цахим мэндчилгээ



Зураг 64. Ажилтнуудад зориулсан цахим мэндчилгээ

Жил бүр байгууллага дотооддоо төрсөн өдөр болон бусад тэмдэглэлт баярын мэндчилгээ дэвшүүлдэг уламжлалтай бөгөөд өнгөрсөн жилээс эхлэн ихэвчлэн цахим хэлбэрээр баярын мэндчилгээ дэвшүүлдэг болсон. Энэ жилийн хувьд ажилтны төрсөн өдрийг тохиолдуулан тухайн ажилтанд зориулсан видео мэндчилгээг бэлдэн хаалттай фэйсбүүк

группэд нийтлэлээ. Ингэснээр ажлын байран дээр харилцаа холбоо нэмэгдэж, ажилтан хоорондын уур амьсгал ч мөн тодорхой хэмжээнд сайжрах болов уу.